

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН 2014 ОНЫ ТАЙЛАН
ДЭЛХИЙ ДАХИНЫ ХҮНИЙ ЭРХИЙН БАЙДАЛ

14

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ

АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

ХЯМРАЛ МӨРГӨЛДӨӨНИЙ ХОР ХОХИРОЛ БА ЭМЗЭГ БАЙДАЛ
УЛС ТӨРИЙН ОРОН ЗАЙ ХУМИГДАЖ, ХҮНИЙ ҮНДСЭН ЭРХИЙГ
БАЙНГА ЗӨРЧИЖ БАЙГАА НЬ
ЯЛ ЗАВШИХ БУЮУ ШУДАРГА ЁСЫГ ТОГТООХОД УЧИРЧ БУЙ АЛДАА
ЯДУУРАЛ БА ЗҮДҮҮРЭЛ
АЛАГЧЛАЛ БА НИЙГМЭЭС ГАДУУРХАЛТ
ЦААШДЫН ТӨЛӨВ

АМЕРИК ТИВИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХҮНИЙ ЭРХ
ЭРҮҮ ШҮҮЛТ БА БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ ХАРЬЦАХ
ШУДАРГА ҮНЭНИЙГ ТОГТООХ БА ЯЛ ЗАВШИХ ЯВДЛЫГ ЗОГСООХЫН
ТӨЛӨӨХ ТЭМЦЭЛ
ШОРОНГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ
ЦАГААЧИД БОЛОН ТЭДНИЙ ҮР УДМЫН ЭРХ
УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХ
ЭРСДЭЛД БУЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧИД
ОХИД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ
ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨН
ТЕРРОРИЗМЫН ЭСРЭГ ТЭМЦЭЛ БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ
ЦААЗААР АВАХ ЯЛ

АЗИ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

ИДЭВХИТНҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨСӨЛТ
ӨӨРӨӨР СЭТГЭГЧДИЙГ НУХЧИН ДАРЖ БАЙГАА НЬ
ЭРҮҮ ШҮҮЛТ БА БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ ХАНДАХ
ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨН
ЯЛ ЗАВШИХ
ДҮРВЭН НҮҮЖ БУЙ ХҮМҮҮС
ӨСӨН НЭМЭГДСЭЭР БУЙ ШАШНЫ БОЛОН УГСААТНЫ ҮЛ ТЭВЧИХ
ҮЗЭЛ
АЛАГЧЛАЛ
БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ БА НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ

ЦААЗААР АВАХ ЯЛ
КОМПАНИЙ ХАРИУЦЛАГА
ЛЕСБИ, ГЕЙ, БИСЕКСУАЛЬ, ТРАНСЖЕНДЕР БОЛОН ИНТЕРСЕКС
ХҮМҮҮСИЙН ЭРХ
ЕВРОП БА ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ
ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ БА ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ
ДҮРВЭГЧИД БА ЦАГААЧДЫН ЭРХ
ЭРҮҮ ШҮҮЛТ БА БУСАД ХЭЛБЭРИЙН ХЭРЦГИЙ ШИЙТГЭЛ
ЦААЗААР АВАХ ЯЛ
ШИЛЖИЛТИЙН ШУДАРГА ЁС
ТЕРРОРИЗМЫН ЭСРЭГ ТЭМЦЭЛ БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ
АЛАГЧЛАЛ
ОХИД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ
БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ БА НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ

ОЙРХИ ДОРНОД БА ХОЙД АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

ӨӨРӨӨР СЭТГЭГЧДИЙГ НУХЧИН ДАРЖ БАЙГАА НЬ
ХУУЛЬ ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО
ЭРҮҮ ШҮҮЛТ БОЛОН БУСАД ХЭЛБЭРИЙН ХЭРЦГИЙ ШИЙТГЭЛ
ЯЛ ЗАВШИХ
УГСААТНЫ БОЛОН ШАШНЫ ЦӨӨНХИЙН АЛАГЧЛАЛ
ДҮРВЭГЧИД БА ДОТООДДОО ШИЛЖИН СУУРЬШИГЧИД
ЦАГААЧДЫН ЭРХ
АЛБАДАН НҮҮЛГЭЛТ
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

ӨМНӨХ ҮГ

“Засгийн газрын зэвсэгт хүчин ба зэвсэгт бүлэглэлийнхний хоорондын мөргөлдөөн Дамаск хотын Ярмук дүүрэг дэх манай хорооллыг зөгийн үүр шиг түйвээсэн. Ярмук бол олон хөлийн газар. Одоо бусад хорооллоос дүрвэж ирсэн маш олон хүний хорогдох газар болсон.

Би хүмүүнлэгийн тусламжийн байгууллагад хэвлэл мэдээллийн идэвхитнээр ажиллаж байсан. Гэвч багтай эрс хүмүүнлэгийн ажилтнууд ба сөрөг хүчний зэвсэгт дайчдыг ялгаж салгадаггүй. Олон найз нөхөд маань баривчлагдсан учраас би ч бас нуугдахаас аргагүй болсон.

Тэндээс зугтах хэрэгтэй гэж шийдээд юм хумаа багласан ч би хаашаа явах билээ? Сирийн палестин дүрвэгчид виз авалгүйгээр ямар ч улс руу нэвтэрч чадахгүй.

Ливан руу явбал арай хялбар байж болох юм гэж бодсон ч Ливан дахь палестин дүрвэгчдийг арьс өнгөөр нь алагчилж, эрхийг нь зөрчдөг гэж сонссон.”

Египет, Туркийн нутаг дэвсгэр болон амь насанд халгаатай тэнгисийн замаар дамжин Итали хүрч, Европ руу дүрвэсэн Сирийн палестин дүрвэгч

Өнгөрсөн он хүний эрхийн төлөө тэмцэгчид хийгээд дайны бүсэд хашигдсан хүмүүсийн хувьд маш хүнд жил байлаа. Засгийн газрууд энгийн номхон иргэдийг хамгаалах хэрэгтэй гэж хоосон ярихаас хэтэрсэнгүй. Дэлхийн улс төрчид тусламж дэмжлэг хамгийн их шаардлагатай байгаа хүмүүсийн төлөө юу ч хийсэнгүй. Гэвч ийм байдлыг өөрчлөх ёстой, өөрчилж чадна гэдэгт Эмнести Интернэшнл итгэж байна.

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй буюу зэвсэгт мөргөлдөөний үед мөрдөх ёстой хууль дүрэм маш тодорхой байдаг. Дайралт довтолгооныг хэзээ ч энгийн номхон иргэдийн эсрэг чиглүүлэх ёсгүй. Энгийн номхон иргэд ба байлдагч талуудыг ялгаж салгаж үзэх зарчим бол дайн дажны хөлд нэрвэгдсэн хүмүүст олгогдох ёстой суурь хамгаалалт юм.

Хэдий тийм боловч энгийн номхон иргэд хаа сайгүй хямрал мөргөлдөөний золиос болсоор байна. Руандад болсон геноцидын 20 жилийн ой тохиосон өнгөрсөн онд ч улс төрчид энгийн номхон иргэдийг хамгаалах дүрэм журмыг уландаа гишгэх буюу эсхүл бусад хүмүүс тэрхүү дүрмийг зөрчиж, энгийн иргэдийн амь насыг хохироож байхад мэдээгүй юм шиг өнгөрүүлсээр байв.

НҮБ-ын Аюулгүйн зөвлөл Сирийн хямралыг эхний жилүүдэд нь шийдвэрлэж чадаагүйгээс үүдэн тоо томшгүй хүний амь насыг аврах боломжийг алдсан. 2014 онд ч тэр алдаагаа давтсаар. Сүүлийн 4 жилд 200 000 гаруй хүн амь насаа алдсаны дийлэнхи хувь нь энгийн номхон иргэд байсан бөгөөд ихэнхи тохиолдолд засгийн газрын зэвсэгт хүчний довтолгоонд өртсөн байна. Одоогийн байдлаар Сирийн 4 сая орчим дүрвэгч бусад улс оронд амьдарч байна. 7.6 сая гаруй хүн Сири улсын дотоодод дүрвэн амьдарч байна.

Сирийн хямрал хөрш Ирак улсад өрнөж байгаа хямралтай нийлэх боллоо. Сири улсад дайны гэмт хэрэг үйлдсээр байгаа Исламын улс гэж өөрсдийгөө нэрлэдэг зэвсэгт бүлэглэл Иракийн хойд бүс нутагт хүнийг хүчээр хулгайлах, цаазаар аваачих, угсаатны цэвэрлэгээг өргөн хүрээнд хийж байна. Түүний зэрэгцээ Иракийн шийтийн босогчид Иракийн засгийн газрын дуугүй дэмжлэгтэйгээр олон тооны энгийн номхон суннитүүдийг хүчээр хулгайлж, амь насыг нь хөнөөсөн.

7-р сард Израйлийн зэвсэгт хүчний явуулсан дайралтын улмаас 2000 гаруй палестинчууд амь насаа алджээ. Тэдний дийлэнхи хувь нь буюу дор хаяж 1500 нь энгийн номхон иргэд байв. Эмнести Интернэшнлийн хийсэн нарийвчилсан дүн шинжилгээгээр Израйлийн бодлого энгийн иргэдийг огтхон ч үл тоомсорлосон төдийгүй дайны гэмт хэргийн шинжтэй байв. Хамас ч мөн Израйлийн нутаг дэвсгэр рүү пуужин хамаагүй харваж, 6 хүний аминд хүрсэн нь дайны гэмт хэрэг юм.

Нигериа улсын хойд хэсэгт засгийн газрын зэвсэгт хүчин ба Бoko Харам зэвсэгт бүлэглэлийн хооронд өрнөж байгаа мөргөлдөөн Бoko Харам бүлэглэл Чибок хотын 276 сурагч охидыг хулгайлсны дараа дэлхийн хэвлэл мэдээллийн анхаарлын төвд орлоо. Хэвлэлийн анхаарал төдийлөн татаагүй нэг зүйл бол Бoko Харам бүлэглэлийн гишүүд болон тэднийг дэмжигчдийн эсрэг Нигериа улсын хүчний байгууллаагынхны үйлдсэн аймшигт гэмт хэрэг буюу алагдсан хүмүүсийн цогсыг нийтийн оршуулгын нүх рүү шидэлж байгаа видео бичлэгийг 2014 оны 8-р сард Эмнести Интернэшнл нийтэд дэлгэсэн явдал байв.

Төв Африкийн БНУ-д олон улсын зэвсэгт хүчин байршиж байгаа хэдий ч шашны хүчирхийллээс болж 5000 хүн амиа алдлаа. Эрүү шүүлт, хүчингийн хэрэг, хомроглон устгах гэмт хэрэг дэлхийн хэвлэл мэдээллийн эхний нүүрэнд гарах нь ховор байна. Гэвч амь насаа алдаж буй хүмүүсийн дийлэнхи хувь нь энгийн номхон иргэд байсаар байна.

Дэлхийн хамгийн залуу улс болох Өмнөд Суданд засгийн газар болон сөрөг хүчний мөргөлдөөний улмаас олон зуун мянган энгийн номхон иргэд амь насаа алдаж, 2 сая хүн орон гэрээсээ дүрвэжээ. Хоёр талын аль аль нь дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсээр байна.

160 гаруй орны хүний эрхийн нөхцөл байдлын тухай энэхүү тайланд тод томруун тусгасанчлан дээр дурдсан зүйлс нь зөвхөн асуудлын өнгөн хэсгийг л хөндөж байна. Зарим хүмүүс бид юу ч хийж чадахгүй, дайн болоход энгийн иргэд угаасаа хохирдог, юуг ч бид өөрчилж чадахгүй гэдэг.

Гэвч энэ бол буруу ойлголт юм. Энгийн номхон иргэдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх нь туйлын чухал. Нэг чухал практик алхмыг бид хийх шаардлагатай байгаа бөгөөд Эмнести Интернэшнл одоогоор 40 гаруй засгийн газрын дэмжлэг хүлээгээд байгаа геноцид, дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн үед Аюулгүйн Зөвлөлөөс авах арга хэмжээнд саад учруулах тохиолдолд хориг тавих эрхээсээ сайн дураар татгалзах ёс зүйн дүрмийг Аюулгүйн Зөвлөлөөр батлах саналыг талархан дэмжиж байна.

Энэ бол маш чухал алхам болж бөгөөд олон хүний амийг аварч чадна.

Гэвч бидний алдаа зөвхөн хомроглон устгахаас урьдчилан сэргийлж чадахгүй байгаад оршиж байгаа юм биш. Хүчирхийлэлээс зугтан тосгон суурингаасаа дүрвэсэн олон сая хүнд шууд тусламж хүргэж чадахгүй байна.

Бусад засгийн газрын алдаа дутагдлын талаар хамгийн чанга шүүмжилдэг засгийн газрууд өөрсдөө тэдгээр дүрвэгчдэд нэн тэргүүнд шаардлагатай байгаа санхүүгийн болон шилжүүлэн суурьшуулахад хэрэгтэй туслалцаа үзүүлэх талаар туйлын хойрго хандсаар байна. 2014 оны эцсийн байдлаар Сирийн дүрвэгчдийн 2 хувь орчим нь л шилжин суурьшаад байгаа бөгөөд энэ тоог 2015 онд дор хаяж 3 дахин нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм.

Түүнчлэн олон тооны дүрвэгчид болон цагаачид Европын эрэгт хүрэхээр зүтгэх замдаа Газрын дундад тэнгист амь насаа алдаж

байна. Европын Холбооны зарим гишүүн орон эрэл хайгуул болон аврах үйл ажиллагаанд хангалттай дэмжлэг үзүүлэхгүй байгаа нь нас барагчдын тоо цочирдмоор өндөр байгаад мөн нөлөөлж байна.

Хямрал мөргөлдөөний үед энгийн номхон иргэдийг хамгаалах нэг алхам бол хүн ам суурьшсан газарт дэлбэрэх зэвсэг хэрэглэхийг хориглох явдал юм. Хэрэв тийм хорио байсан бол Оросын дэмжлэгтэй салан тусгаарлагчид болон Киевийн талыг багримтлагчдын аль аль нь энгийн иргэдийн орон сууцны хорооллуудыг онилж байгаа Украин улсад олон хүний амь насыг аврах боломжтой байх байсан.

Энгийн номхон иргэдийг хамгаалах тухай дүрэм журам гаргахын ач холбогдол нь тэдгээрийг зөрчсөн тохиолдолд жинхэнэ ёсоор хариуцлага тооцох, шударга үнэнийг тогтоох явдал юм. Тийм ч учраас Эмнести Интернэшнл Женев дэх НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл 2009 онд Шри Ланка улсад болж байсан мөргөлдөөний сүүлийн саруудад олон арван мянган энгийн иргэдийг хөнөөсөн хүний эрхийн зөрчлийг олон улсын төвшинд хянан шалгах шийдвэр гаргасныг баяртайгаар хүлээн авсан билээ. Эмнести Интернэшнл сүүлийн 5 жилийн турш уг шийдвэрийг гаргуулахын төлөө кампанит ажил өрнүүлсэн юм. Ингэж хариуцлага тооцохгүйгээр бид урагшилж чадахгүй.

Хүний эрхийн бусад салбарт ч мөн хийх зүйл их байна. Мексик улсад 9-р сард 43 оюутан сураггүй алга болсон нь 2006 оноос хойш тус улсад сураггүй алга болсон 22 000 хүний нэг хэсэг юм. Тэдний дийлэнхийг гэмт хэргийн

бүлэглэлүүд хүчээр хулгайлсан боловч цагдаа болон армийн зүгээс зарим тохиолдолд гэмт хэргийн бүлэглэлүүдтэй хуйвалдан хүчээр сураггүй болгосон олон тохиолдол бүртгэгдсэн. Цогцос нь олдсон цөөн хэдэн хохирогчдын биед эрүү шүүлт болон бусад хэлбэрээр хэрцгий хандсаны ул мөр илэрхий үлдсэн байв. Холбооны болон мужийн засгийн газар эдгээр гэмт хэргийг мөрдөн шалгаж, засгийн газрын ажилтнууд уг хэрэгт оролцсон эсэхийг тогтоох, хохирогчид болон тэдний төрөл төрөгсдөд хууль шүүхээр үнэн мөнийг тогтоолгох боломж олгох талаар маш хангалтгүй ажилласан. Түүнээс гадна засгийн газар хүний эрхийн хямралыг нуун дарагдуулахыг чармайж байгаа төдийгүй өндөр албан тушаалтнууд ял завших, авлига авах болон нийгэм цэрэгжих үйл явц улам гаарч байна.

2014 онд дэлхийн олон засгийн газар иргэний нийгмийн байгууллагын үүрэг ролийг сулруулахын тулд ТББ-ууд хийгээд иргэний нийгмийн байгууллагуудыг нухчин дарах ажлаа үргэлжлүүлээ. ОХУ Хүйтэн дайны үеийг санагдуулсан “гадаадын агентын хууль” гэгчээ улам чангатгав. Египет улсад Мубаракийн үеийн Жагсаал цуглааны тухай хуулийг ашиглан ТББ-уудыг нухчин дарж, засгийн газар өөрөөр сэтгэгчдийг хүлцэн тэвчихгүй гэдгээ хүчтэй илэрхийлэв. Хүний эрхийн зонхилох байгууллагууд өөрсдийнх нь эсрэг хатуу арга хэмжээ авахаас айсны улмаас Египетын хүний эрхийн нөхцөл байдлын тухай НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн тогтмол тайланд оролцохоос татгалзжээ.

Өмнө нь олон удаа тохиолдож байсанчлан жагсагчид заналхийлэл,

хүчирхийллээс үл эмээн эр зоригоо харуулж чадсан. Хонконгт олон арван мянган хүн албан ёсны заналхийллийг давж, цагдаагийн хүч хэтрүүлэн хэрэглэх явдалтай нүүр тулсан бөгөөд үг хэлэх, эвлэлдэн нэгдэх үндсэн эрх чөлөөгөө хэрэгжүүлсэн тэдний үйл хэрэг “шүхэрт хөдөлгөөн” хэмээн нэрлэгдсэн юм.

Заримдаа хүний эрхийн байгууллагуудын өөрчлөлт авчрах мөрөөдлийг биелэгдэх боломжгүй зүйл гэж буруутгах нь бий. Гэвч бид онцгой зүйлийг ч гэсэн хийж болно гэдгийг санах ёстой. 12-р сарын 24-нд Зэвсгийн худалдааны гэрээг түүнээс гурван сарын өмнө 50 дахь улс соёрхон баталснаар хүчин төгөлдөр болсон билээ.

Эмнести Интернэшнл болон бусад байгууллагууд уг гэрээг батлуулахын тулд 20 жил кампанит ажил өрнүүлсэн юм. Бидэнд ийм гэрээ байгуулах ямар ч боломжгүй гэж байнга хэлдэг байсан. Гэтэл уг гэрээ одоо хүчин төгөлдөр болсон төдийгүй харгислал үйлдэж болзошгүй этгээдэд зэвсэг худалдахыг хориглож чадсан. Энэ гэрээ ирэх жилүүдэд маш чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд түүний хэрэгжилтийг хангах явдал чухлаар тавигдах болно.

2014 онд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенци батлагдсаны 30 жил тохиолоо. Уг конвенцийг батлуулахын тулд Эмнести Интернэшнл олон жилийн турш кампанит ажил өрнүүлсэн бөгөөд түүнийхээ ачаар 1977 онд Нобелийн энх тайвны шагнал хүртсэн билээ.

Энэ ойг бид ёслон тэмдэглэхийн хамт өнөөг хүртэл дэлхий даяар эрүү шүүлт оршоор байгааг санах учиртай бөгөөд тийм ч учраас

Эмнести Интернэшнл энэ жил Эрүүдэн шүүхийн эсрэг дэлхий нийтийн кампанит ажлаа эхлүүлсэн юм.

Эрүүдэн шүүхийн эсрэг энэхүү үзэл санаа АНУ-ын 2001 оны 9-р сарын 11-ний халдлагаас хойшхи жилүүдэд эрүү шүүлтийг зөвтгөх хандлагатай байсныг харуулсан АНУ-ын Сенатын тайланг хэвлэгдэн гарсны дараа онцгой анхаарал татах болсон билээ. Бусдыг эрүү шүүлт тулгасан хэрэгт хариуцлага хүлээх ёстой хүмүүсийн зарим нь одоо хүртэл ичээд байх зүйл хийгээгүй гэдэгтээ итгэсээр байгаа нь хачирхалтай байв.

Вашингтоноос Дамаск хүртэл, Абужагаас Коломбо хүртэл засгийн газрын удирдагчид элс орноо “аюулгүй” байлгах нэрийн дор хүний эрхийн аймшигтай зөрчлүүдийг зөвтгөсөөр байна. Үнэндээ бодит байдал эсрэгээрээ байна. Хүний эрхийн зөрчлүүд нь бид бүхэн өнөөдөр ийм аюултай дэлхий ертөнцөд амьдарч байгаагийн нэг шалтгаан юм. Хүний эрхийг хэрэгжүүлдэггүй газар аюулгүй байдлыг хангаж чадахгүй.

Хүний эрхийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа цаг үед ч гайхамшигтай өөрчлөлт авчирч болохыг бид олонтаа харсан билээ.

Олон жилийн дараа бид 2014 оныг эргэн харахдаа 2014 онд бид бүхэнд тохиолдсон бүхэн сайн сайхан ирээдүйг цогцлоох гарааны цэг болсон гэдэгт илтгэл дүүрэн байх учиртай.

Ерөнхий нарийн бичгийн дарга Салил Шетти

АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Африк тив Руандагийн геноцидийн 20 жилийн ойг тэмдэглэсэн 2014 оны туршид тус тивийн дийлэнхи хэсэгт хямрал мөргөлдөөн үргэлжилсээр байв. Ялангуяа Төв Африкийн БНУ, Өмнөд Судан болон Нигериа улсад цус урсгасан хямрал мөргөлдөөн улам даамжирч байгаа бол Бүгд Найрамдах Ардчилсан Конго улс, Судан болон Сомали улс дахь хямрал үргэлжилсээр байна.

Эдгээр хямрал мөргөлдөөний явцад олон улсын хүний эрхийн ба хүмүүнлэгийн эрх зүйг системтэйгээр бөгөөд ноцтойгоор зөрчсөөр байна. Зэвсэгт мөргөлдөөнийн улмаас төсөөлөхийн аргагүй гэмт хэрэг, шударга бус явдал, хэлмэгдүүлэлт гарч байна.

Хүмүүсийг гадуурхах, алагчлах болон бусад үндсэн эрх чөлөө, нийгэм-соёлын эрхийг нь байнга зөрчих нь хямрал мөргөлдөөн, тогтворгүй байдал үүсэн гарах таатай хөрс болж байна.

Олон талаар Африк тив өсөн өндийж байгаа бүс нутаг билээ. Олон оронд хөгжлийн агуулга болон хэлбэр өөрчлөгдөж байна. 2014 оны турш нийгэм, хүрээлэн буй орчин болон эдийн засгийн хурдацтай өөрчлөлт явагдлаа. Хурдацтай өсч буй хүн ам, эдийн засгийн өсөлт ба хотжилт хүмүүсийн амьдралыг эрчимтэй өөрчилж байна.

Африкийн олон улс орон тулгарч буй хэцүү сорилтуудыг үл хайхран НҮБ-ын Мянганы хөгжлийн зорилтод хүрэх чиглэлд ихээхэн ахиц гаргалаа. Африк тивийн 2014

оны Мянганы хөгжлийн зорилтын тайланд дурдсанаар МХЗ-д хүрэх чиглэлээр дэлхийн хамгийн сайн гүйцэтгэлтэй 10 улсын 8 нь Африк тивд байв.

Хэдий тийм боловч эдийн засгийн хурдацтай өсөлт хүмүүсийн амьдралын нөхцлийг сайжруулж чадаагүй гэдгийг олон үзүүлэлт харуулж байгаа нь харамсалтай юм. Африк тивд ядуурлын нийт төвшин сүүлийн арван жилд буурсан хэдий ч ядуу нөхцөлд буюу өдөрт 1.25 ам.доллараас бага орлогоор амьдардаг африкчуудын тоо өсчээ. Хямрал мөргөлдөөнд нэрвэгдсэн хоёр улс болох Нигериа (25.89%) ба Ардчилсан Конго улсад (13.6%) тус тивийн нийт ядуусын бараг 40% нь ногдож байгаа юм. Африк тив нь залуусын ажилгүйдлын төвшингөөр дэлхийд тэргүүлдэг бөгөөд тэгш бус байдлаараа Латин Америкийн дараа хоёрт ордог бүс нутаг юм. Эдгээр нь нэг талаас хямрал мөргөлдөөн ба тогтворгүй байдал, нөгөө талаас нийгэм-соёлын үндсэн эрхийг эдлүүлэхгүй байх, нийгмээс тусгаарлах, тэгш бус байдал, туйлын ядуурал зэрэг нь хоорондоо хэрхэн холбоотой болохыг харуулж байна.

Хэлмэгдүүлэлт болон хүний үндсэн эрхийг байнга зөрчих явдал тогтворгүй байдал хийгээд хямрал мөргөлдөөнд хүргэж болдгийг 2014 онд Буркина Фасо, Төв Африкийн БНУ, Өмнөд Судан болон Судан улсад өрнөсөн үйл явдал харууллаа.

Африкийн олон оронд хэлмэгдүүлэлт болон улс төрийн орон зай хумигдах чиг хандлага жилийн турш үргэлжлэв. Хэд хэдэн улсад аюулаас хамгаалах хүчнийхэн тайван жагсаал цуглаан, эсэргүүцлийг хүч хэрэглэн

тараасан. Маш олон газар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, тайвнаар эвлэлдэн нэгдэх эрхийг боомилсоор байна. Уг чиг хандлага зөвхөн авторитар засгийн газартай орнууд төдийгүй мөн авторитар биш эсхүл улс төрийн шилжилт хийхээр бэлтгэж байгаа газруудад ч түгээмэл ажиглагдаж байна.

2014 онд Африкийн олон орон, түүний дотор Кени, Сомали, Нигериа, Мали улс болон Сахелын бүс нутагт оршдог улсууд Ал-Шабаб, Боко Харам зэрэг хэт даврагчдын зэвсэгт бүлэглэлүүдийн үйлдсэн хүчирхийлэл нэмэгдсэний шууд нөлөөгөөр аюулгүй байдлын ноцтой сорилтод өртлөө. Олон арван мянган энгийн номхон иргэд амь насаа алдаж, олон зуун хүмүүс хулгайлагдаж, тоо томшгүй олон хүн байнгын айдас түгшүүрт амьдарч байна. Гэвч олон засгийн газар хариу арга хэмжээ авахдаа ялгаварлалгүйгээр харгис хэрцгий хандаж, хүмүүсийг бөөнөөр нь дур зоргоороо баривчилж хорин, хуулиас гадуур цаазласаар байна. Оны төгсгөлд Кени улс Аюулгүй байдлын тухай хууль батлаж, 22 хуулинд нэмэлт өөрчлөлт оруулсан нь хүний эрхийн асуудлыг ноцтойгоор хөндлөө.

Африк тивд өрнөж байгаа хямрал мөргөлдөөний бас нэг нийтлэг тал бол аюулаас хамгаалах хүчнийхэн ба зэвсэгт бүлэглэлүүдийн үйлдсэн олон улсын эрх зүйгээр шийтгэгдэх ёстой гэмт хэрэгт хариуцлага тооцож чадахгүй байгаа явдал юм. 2014 онд Төв Африкийн БНУ, Ардчилсан Конго улс, Нигериа, Сомали, Өмнөд Судан ба Судан улсад буруутай этгээдүүд ял завших явдал үргэлжилсээр байсан төдийгүй Олон улсын эрүүгийн

шүүхийн эсрэг улс төрийн томоохон жагсаал цуглаан гарсан. Түүнчлэн Африк тивд албаа хашиж буй төрийн тэргүүнүүд болон албан тушаалтнуудад шүүхэд татагдахгүй байх халдашгүй эрх олгох талаар урьд өмнө байгаагүй улс төрийн хүчин чармайлт өрнөсөн. Түүний үр дүнд Африкийн Шударга ёс ба хүний эрхийн шүүхийн дүрмийн протоколд албаа хашиж буй төрийн тэргүүнүүд болон өндөр албан тушаалтнуудад шүүхэд татагдахгүй байх халдашгүй эрх олгосон нэмэлт өөрчлөлт оруулсан нь ухралт болсон.

2014 онд Африкийн холбооны “хямрал мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, удирдах, зохицуулах талаар шийдвэр гаргагч байнгын байгууллага” болох Африкийн холбооны Энх тайван, аюулгүй байдлын зөвлөл байгуулагдсаны 10 жилийн ой тохиолоо.

Африкийн холбоо болоод түүний Энх тайван, аюулгүй байдлын зөвлөл Африк тивд шинээр үүсч буй хямрал мөргөлдөөнийг шийдвэрлэх талаар нааштай алхмууд хийсний дотор Төв Африкийн БНУ-д Олон улсын дэмжих хүчин илгээж, Өмнөд Судан Мөрдөн шалгах комисс байгуулж, Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын асуудал эрхэлсэн Тусгай элч бий болгосон төдийгүй энгийн номхон иргэдийн эсрэг үйлдэж буй хүчирхийлэл, халдлагыг буруушаасан улс төрийн хэд хэдэн мэдэгдэл гаргасан. Гэвч олон тохиолдолд дээрх хүчин чармайлт хэтэрхий өчүүхэн, хэтэрхий оройтсон байдаг нь Африкийн холбооны хямрал мөргөлдөөнийг шийдвэрлэх талаар хүчин чадал дутмаг байгааг харуулдаг. Тэр ч байтугай Африкийн холбооны

энхийг сахиулах хүчин хүний эрхийн зөрчлийн хамсаатан болсон тохиолдолд гарсны дотор Төв Африкийн БНУ-дахь Олон улсын дэмжих хүчний бүрэлдэхүүнд багтаж байсан Чад улсын энхийг сахиулагчид тийм зөрчил гаргасны улмаас уг хүчний бүрэлдэхүүнээс гарсан.

Гэсэн хэдий ч Африк тив дэх хямрал мөргөлдөөнийг шийдвэрлэх асуудал Африкийн Холбооны хүчин чадлаас давж гараад байна. Тухайлбал, Төв Африкийн БНУ-д удал хойшлуулсны эцэст НҮБ энхийг сахиулах хүчин илгээж олон хүний амь насыг аварсан хэдий ч хүний эрхийн ужгирсан зөрчлийг зогсоох хангалттай нөөц бололцоо байхгүй байна. Зарим тохиолдолд олон улсын хамтын нийгэмлэг дуугүй өнгөрч байв. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл хүний эрхийн хараат бус мониторинг, тайлан, хариуцлага хүлээлгэх асуудал чухлаар шаардагдаж буйг эс харгалзан Судан улс дахь хямрал мөргөлдөөний эсрэг үр дүнтэй хариу арга хэмжээ авч чадаагүй. 7-р сард НҮБ-ын ЕНБД Дарфур дахь НҮБ-ын Энхийг сахиулах хүчний ажилтнууд хүний эрхийн зөрчлийг нуун дарагдуулсан хэрэгтэй холбогдуулан мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлж байгаагаа зарласан.

Африк тивд даамжирсаар байгаа хямрал мөргөлдөөнийг шийдвэрлэхийн тулд Африкийн удирдагчид улс төрийн хүсэл зоригоо нэн даруй үндсээр нь өөрчлөх шаардлага тулгарч байгаагийн зэрэгцээ үндэсний хэмжээнд ял завшдаг тогтолцоог устгах, хямрал мөргөлдөөний уг шалтгааныг арилгах талаар бүс нутгийн болон олон улсын

төвшинд хүчин чармайлтаа нэгтгэх шаардлагатай байна. Чингэхгүй аваас “2020 он гэхэд буу зэвсгийг дуугүй болгох” бүс нутгийн алсын хараа хүршгүй хоосон амлалт төдий зүйл болж үлдэнэ.

ХЯМРАЛ МӨРГӨЛДӨӨНИЙ ХОР ХОХИРОЛ БА ЭМЗЭГ БАЙДАЛ

Хямрал мөргөлдөөнд нэрвэгдэж, аюулгүй байдлыг хангаж чадахгүй байгаагаас Африк тивийн тоо томшгүй олон хүн амь насаа алдаж байгаа бөгөөд хямралын идэвхжлийн төвшин өөр өөр байгаа ч тус тивийн бараг бүх орныг хамарч байна. Эдгээр хямрал мөргөлдөөний онцлог нь засгийн газрын зэвсэгт хүчин болоод зэвсэгт бүлэглэлүүдийн аль аль нь хүний эрхийн зөрчил, харгислалыг системтэйгээр үйлдэж байгаа явдал юм.

Төв Африкийн БНУ-д шашны хүчирхийлэл болон хомрогдсон харгислал, түүний дотор аллага, эрүү шүүлт, хүчин, бие махбодийг зэрэмдэглэх, хулгайлах, хүчээр нүүлгэн шилжүүлэх болон хүүхэд-цэрэг элсүүлэх явдал гаарсаар байна. 7-р сард гал зогсоох хэлэлцээр байгуулж, 9-р сараас НҮБ-ын энхийг сахиулах хүчин үүрэг гүйцэтгэх болсныг эс харгалзан 2014 оны сүүлийн саруудад тус улсын төвийн бүс нутагт дайралт эрчимжсэн. Янз бүрийн зэвсэгт бүлэглэлийн хоорондох хямрал мөргөлдөөн эрчимжихэд энгийн номхон иргэд хүний эрхийн зөрчлийн золиос болох нь ихэсдэг. Тус улсын нийслэл Бангуй хотод 10-р сард шинээр хүчирхийлэл эрчимжсэн. Мөргөлдөөнд оролцож буй бүх талууд буюу Селека, Балакагийн

эсрэг болон Пойлх угсаатны зэвсэглэсэн гишүүд бүгд энгийн номхон иргэдийг системтэйгээр, ямар ч ял зэм хүлээхгүйгээр онилцгоож байна. НҮБ-ын байдлыг тогтворжуулах MINUSCA хүчнийг 9-р сард байрлуулсан нь өөрчлөлт гарах найдвар авчирсан ч ганц сарын дараа тус улсыг хамарсан томоохон хэмжээний бослого, хүчирхийлэл өрнөсөн. Энэ нь тухайн газарт илгээж байгаа олон улсын хүчний чадавхи, хариу үйлдлийг бэхжүүлэх шаардлага байгааг харуулсан билээ.

Хөрш Өмнөд Судан улсад 2013 оны 12-р сард эхэлсэн хямрал мөргөлдөөний улмаас олон арван мянган хүн, түүний дотор олон энгийн номхон иргэд амь насаа алдаж, 1.8 сая хүн орон гэрээ орхин дүрвээд байна. Засгийн газар болон сөрөг хүчнийхэн олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн гэрээ конвенци үл тоомсорлон дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсээр байна. Хямрал мөргөлдөөнд оролцож байгаа бүх тал энгийн номхон иргэдийг үндэс угсаагаар нь ялгаварлан хөнөөж байгаа бөгөөд ингэхдээ эргэл мөргөлийн газар болон эмнэлэгт аврал эрж оргоносон хүмүүсийг ч ялгахгүй байна. Бэлгийн хүчирхийлэл, өмч хөрөнгийг эвдэн сүйтгэх, тонон дээрэмдэх явдал газар авлаа. Сая сая хүн өлсгөлөн, өвчнөөр амь насаа алдах эрсдэл байгааг эс харгалзан хоёр талын аль аль нь хэд хэдэн удаа гал зогсоох хэлэлцээрийг зөрчсөн. Өнгөрсөн онд ял завших явдлыг таслан зогсоох, түүний дотор Африкийн холбооны Өмнөд Суданы нөхцөл байдлыг шалгах комиссын тайланд дурдагдсан

асуудлуудыг шийдвэрлэх талаар ямар нэг ахиц гарсангүй.

2013 онд Боко Харам хэмээх исламын зэвсэгт бүлэглэл кампанит ажлаа гүнзгийрүүлсний улмаас Нигериа улсын Зүүн хойд муж дахь зэвсэгт мөргөлдөөний цар хүрээ, амиа алдагсдын тоо нэмэгдсэн. Энэ нь Африкийн хамгийн олон хүн амтай улсад болон бүс нутгийн энх тайван, аюулгүй байдалд учирч буй аюул заналыг тод томруун харуулсан хэрэг болсон.

2014 онд жижиг хот тосгод дахь хямрал мөргөлдөөн эрчимжсэн бөгөөд 2009 оноос хойш 4000 энгийн номхон иргэд амь насаа алджээ. 4-р сард Боко Харам бүлэглэл 276 сурагч охиныг хулгайлсан нь энгийн номхон иргэдийн эсрэг уг бүлэглэлийн террорист үйл ажиллагааны томоохон жишээ юм. Нөгөө талаар олон жилийн турш Боко Харамын дайралтад өртсөн айл хотлууд тэдгээр дайралтын эсрэг асар их хүчээр ялгаварлалгүй дайралт хийж, хүмүүсийг хомроглон баривчилж, зодож нүдэн, эрүү шүүлт тулгадаг засгийн газрын аюулгүйн хүчнийхний хүчирхийлэлд өртөх эрсдэл нэмэгдсээр байна. Эмнести Интернэшнлийн олж цугуулсан видео бичлэг, нүдээр үзсэн гэрчүүдийн мэдүүлэг зэрэг нь бүх талуудын үйлдсэн дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон хүний эрхийн зөрчлүүдийн шинэ баримт нотолгоо болж байна.

Нигериа улсын аюулаас хамгаалах хүчнийхэн тус улс даяар, түүний дотор Зүүн хойд бүс нутаг дахь хямрал мөргөлдөөний хүрээнд Эрүү шүүлт болон бусад хэрцгий хандлагыг байнга системтэйгээр хэрэглэж байна. Гэвч аюулгүй

байдлын албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэх нь ховор байна. 2013 оны 5-р сард онц байдал зарласны дараа нутгийн зүүн хойд хэсэгт хууль бусаар хомроглон баривчилж хорих явдал даамжирсан бөгөөд оны төгсгөл гэхэд цэрэг цагдаагийнхан хууль бусаар хүмүүсийг цаазалсан тухай хэд хэдэн мэдээ ирсэн.

Түүний зэрэгцээ аль хэдийнэ ужгирсан бусад хямрал мөргөлдөөнийг шийдвэрлэх боломж харагдахгүй байна.

Судан улсын Дарфур, Өмнөд Кордофан болон Хөх Нилийн бүс нутаг дахь хямрал мөргөлдөөн үргэлжилсээр байгаа төдийгүй Хойд Кордофан руу халдварлаад байна. Мөргөлдөөнд оролцогч бүх тал олон улсын хүний эрхийн болон хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөөр байна. Дарфурт дайтаж буй талуудын хоорондын өргөн тархсан хүчирхийлэл, засгийн газрын талын зэвсэгт бүлэглэлүүдийн болон сөрөг хүчний зэвсэгт бүлэглэлүүдийн дайралтын улмаас энгийн номхон иргэдийн шилжин суурьшилт болон амь насаа алдах явдал ихээхэн нэмэгдлээ.

Ардчилсан Конго улсын зүүн нутагт Сокола 1 цэргийн ажиллагааны үеэр зэвсэгт бүлэглэлийнхний үйлдсэн хүчирхийллийн олон мянган хүн амь насаа алдаж, сая гаруй хүн орон гэрээсээ дүрвэхэд хүрчээ. Засгийн газрын аюулаас хамгаалах хүчнийхэн болон зэвсэгт бүлэглэлийнхний аль аль нь аллага, бөөнөөр нь хүчирхийлэх хэрэг үйлдэж байсан нь хүчирхийллийг улам гааруулж байв.

Сомали улсын өмнөд болон төв мужид засгийн газрын талын зэвсэгт хүчин, Африкийн холбооны

энхийг сахиулах хүчин, Аль Шабааб исламын зэвсэгт бүлэглэл хоорондын мөргөлдөөний улмаас 100 000 гаруй энгийн номхон иргэд амь насаа алдах буюу гэмтэж бэртэж, нутгаасаа дүрвэхэд хүрсэн. Уг мөргөлдөөнд оролцогч бүх тал олон улсын хүний эрхийн болон хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн. Зэвсэгт бүлэглэлүүд хүмүүсийг, тэр ч байтугай хүүхдүүдийг хүчээр элсүүлж, хулгайлж, эрүүдэн шүүж, амь насыг нь хөнөөж байна. Хүчин болон бусад хэлбэрийн бэлгийн хүчирхийлэл өргөн тархсан. Хямрал мөргөлдөөн, ган гачиг, хүмүүнлэгийн тусламжийн үүд хаалга хумигдсанаас шалтгаалж хүмүүнлэгийн нөхцөл байдал доройтжээ. Нэг сая хүн хүмүүнлэгийн хямралд нэрвэгдээд байгаа бөгөөд 2014 оны төгсгөлийн байдлаар нэмээд 2.1 сая хүнд хүмүүнлэгийн туслалцаа хэрэгтэй байна.

Цаашид хямрал мөргөлдөөн гарах сэрэмжлүүлэх дохио хэдийнэ асаад байна. Ялангуяа Сахелын бүс нутаг улс төрийн аюулгүй байдал хангагдаагүй, зэвсэгт бүлэглэлүүд болон зохион байгуулалттай гэмт хэрэг даамжирч, туйлын ядуурал болон нийгмээс гадуурхах явдал гүнзгийрч байгаа зэргээс шалтгаалж ихээхэн тогтворгүй байна. Энэ байдал дотоодын зэвсэгт мөргөлдөөнд нэрвэгдсэний улмаас аюулгүй байдал нь хангагдаж чадахаа больсон, ялангуяа нутгийн хойд хэсэгт засгийн газар нь хяналт тавьж чадахаа больсон Мали улсад тод харагдсан. 2013 онд засгийн газар ба зэвсэгт бүлэглэлийн хооронд гарын үсэг зурсан энх тайвны гэрээг үл тоон зэвсэгт бүлэглэлийнхэн хүмүүсийг хулгайлах, амь насыг нь хөнөөх

зэргээр хүний эрхийг зөрчиж байгаа бөгөөд 2014 онд засгийн газар ба зэвсэгт бүлэглэлийн хооронд энх тайвны яриа хэлэлцээ явагдаж байгаа хэдий ч хүчирхийлэл намжсангүй.

Сомали, Кени, Нигериа улс болон Сахелын бүс нутаг даяар өсөн нэмэгдэж буй террорист ажиллагаа, тэдгээрийн эсрэг засгийн газрын зэвсэгт хүчний явуулж буй хүний эрх зөрчсөн хариу арга хэмжээ зэрэг нь хүчирхийлэл, айдас хүйдсийг улам нэмэгдүүлж байна. Зэвсэгт бүлэглэлүүд хүмүүсийн амь насыг хууль бусаар хөнөөж, хулгайлж, эрүү шүүлт тулгаж, энгийн иргэдийн эсрэг халдлага үйлдсээр байна. Сомали улсад Аль Шабааб бүлгийнхэн тагнуул хийсэн буюу өөрсдийн баримталдаг исламын шашны хуулийг дагасангүй гэсэн шалтгаанаар хүмүүсийг эрүүдэн шүүж, амийг нь хороодог. Тэд хүмүүсийг олон нийтийн өмнө чулуу шидэх гэх мэт аргаар алдаг бөгөөд, гар хөлийг нь тайрах буюу ташуурддаг. Камерун болон Нигериа улын Исламын бүлгүүд, түүний дотор Боко Харам бүлэглэл энгийн номхон иргэдийг хөнөөж, барьцаалж, хулгайлж байгаагаас гадна хүний эрхийг хамгаалагчид руу дайрч байв.

УЛС ТӨРИЙН ОРОН ЗАЙ ХУМИГДАЖ, ХҮНИЙ ҮНДСЭН ЭРХИЙГ БАЙНГА ЗӨРЧИЖ БАЙГАА НЬ

Африк тивийн маш олон оронд өнгөрсөн жилийн турш хэлмэгдүүлэлт нэмэгдэж, улс төрийн орон зай хумигдах үйл явц үргэлжилсэн.

Эритрей улсад ямар ч улс төрийн сөрөг хүчний нам, хараат

бус хэвлэл мэдээллийн буюу иргэний нийгмийн байгууллагыг үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөггүй бөгөөд олон мянган үзэл санааны болон улс төрийн хоригдлуудыг дур зоргоороо хорьсоор байна. Этиоп улсад хараат бус хэвлэл мэдээлэл, түүний дотор блогчид ба сэтгүүлчдийг ахин онилж, сөрөг хүчний намын гишүүд болон тайван жагсагчдыг баривчлах ажил сэргэсэн. Руанда улсад хүний эрхийн талаар засгийн газрын явуулж буй бодлогод иргэний нийгмийн зүгээс шүүмжлэлтэй хандах орон зай бараг байхгүй. Бурунди улсад 2015 оны сонгууль ойртохын хэрээр шүүмжлэлтэй дуу хоолой, түүний дотор сөрөг хүчний гишүүд иргэний нийгмийн идэвхитнүүд, хуульчид болон сэтгүүлчдийн дуу хоолойг хязгаарлаж байна. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлаж, хурал цуглаан, жагсаал хийхийг тогтмол хориглож байна.

Гамби улсын Ерөнхийлөгч Яхя Жаммех засгийн эрх барьсан 20 жилийнхээ ойг тэмдэглэсэн бөгөөд энэ бүх хугацаанд тэрээр сэтгүүлчид, улс төрийн өрсөлдөгчид болон хүний эрхийг хамгаалагчдыг айлган сүрдүүлж, эрүүдэн шүүж, өөрөөр сэтгэгчдийг огт хүлээн зөвшөөрөхгүй байсаар ирсэн. Оны төгсгөлд буюу 12-р сарын 30-ны тус улсад төрийн эргэлт хийхийг завдсан бөгөөд арав гаруй хүнийг баривчилж, хэвлэл мэдээллийн хэрэгслийг хаасан. Буркина Фасод 11-р сард шилжилтийн засгийн газар байгуулагдсан бөгөөд 2015 онд болох парламентийн болон ерөнхийлөгчийн сонгууль хүртэл улс орноо удирдах үүрэг хүлээсэн. Энэ явдал Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн

төслийг эсэргүүцсэн нийтийг хамарсан жагсаал цуглааны дүнд ерөнхийлөгч асан Блэз Компаорег албан тушаалаас нь огцруулсны дараа болсон.

Ангол, Буркина Фасо, Чад, Гвиней, Сенегал, Того болон бусад улсад аюулаас хамгаалах хүчнийхэн жагсаал цуглаан болон эсэргүүцлийн эсрэг хүч хэтрүүлэн хэрэглэж байна. Ихэнхи тохиолдолд, эрх баригчид хүч хэтрүүлэн хэрэглэсэн асуудлын талаар мөрдөн шалгалт явуулахгүй, нэг ч хүнд тийм хэрэгт холбогдуулан хариуцлага тооцоогүй.

Олон оронд засгийн газрын ажилтнууд буюу зэвсэгт бүлэглэлийнхэн сэтгүүлчид, хүний эрхийг хамгаалагчид болон улс төрийн өрсөлдөгчдөд заналхийлэх, тэднийг дур зоргоороо баривчлах, хорих, зодож нүдэх, эрүүдэн шүүх, хүчээр сураггүй болгох, тэр ч байтугай амь насыг нь хөнөөх явдал өргөн хүрээтэй оршсоор байна. Ангол, Буркина Фасо, Камерун, Чад, Эритрей улс, Этиоп улсад, Гамби улсад, Гвиней, Мавритани, Руанда улс, Сомали улс, Свазиланд, Того, Уганда, Замби болон Зимбабве зэрэг улсад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон тайвнаар эвлэлдэн нэгдэх эрхийг нухчин дарж, хязгаарлах явдал гарсаар байна.

Ангол, Бурунди, Гамби улсад шинээр батлагдсан хууль тогтоомж, дүрэм журам хэвлэл мэдээллийн болон иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг улам хязгаарлалаа.

Судан улсын засгийн газар энх тайвныг тогтоох үндэсний яриа хэлэлцээг дэмжиж, үндсэн хуулиар олгогдсон эрхийг хамгаална

гэдгээ амалж байгаа хэдий ч тус улсад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх эрхийг нэлээд хэмжээгээр хязгаарлаад байна. Тус улсын засгийн газар эрх баригч Үндэсний конгресс намын өрсөлдөгчдийг хууль бусаар баривчлан хорьж, хэвлэл мэдээллийг хянаж, олон нийтийн хэлэлцүүлэг, эсэргүүцлийг дарахад Үндэсний Тагнуул ба Аюулгүйн хүчин болон бусад аюулгүйн хүчний байгууллагыг ашигласаар байна.

Өмнөд Судан улсын Үндэсний аюулгүй байдлын алба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах, зэвсэгт мөргөлдөөнийг хэрхэн дуусгах тухай нийтийн хэлэлцүүлгийг намжаах ажиллагааны хүрээнд зарим сонины газруудыг хааж, сэтгүүлчдийг нь айлган сүрдүүлж, хууль бусаар хорьжээ. Үндэсний аюулгүй байдлын албанд өргөн хүрээтэй эрх мэдэл, түүний дотор хуулийн зохих заалт буюу хараат бус хөндлөнгийн хяналт, зөрчлөөс хамгаалах хамгаалалтгүйгээр хүмүүсийг баривчилж хорих эрх олгосон хуулийн төслийг парламентаар баталсан бөгөөд ерөнхийлөгчийн батламжлах эсэхийг хүлээж байв.

ЯЛ ЗАВШИХ БУЮУ ШУДАРГА ЁСЫГ ТОГТООХОД УЧИРЧ БУЙ АЛДАА

Африк тив дэх зэвсэгт мөргөлдөөнүүдийн хувьд ял завших явдал түгээмэл бөгөөд олон улсын эрх зүйд хамаарах гэмт хэргийн сэжигтнүүдэд хариуцлага хүлээлгэх явдал туйлын ховор байна.

Төв Африкийн БНУ-д зэвсэгт бүлэглэлийн доогуур тушаалын

зарим гишүүдийг баривчилсан бөгөөд Олон Улсын Эрүүгийн Шүүхийн прокурор хүчирхийллийн талаар шинэ мөрдөн шалгалт эхлүүлж байгаагаа зарласан. Гэвч иймэрхүү итгэл найдвар төрүүлсэн алхам маш ховор хэвээр байгаа бөгөөд ял завших явдал Төв Африкийн БНУ дахь хямрал мөргөлдөөний галыг өдөөсөөр байгаа юм. Оны эцсийн байдлаар олон улсын эрх зүйгээр шийтгэгдэх гэмт хэрэг үйлдсэн зэвсэгт бүлэглэлийн бараг бүх удирдагчид эрх чөлөөтэй явцгааж байв.

Ардчилсан Конго улсад тус улсын арми хийгээд зэвсэгт бүлэглэлүүдийн үйлдсэн олон улсын эрх зүйгээр шийтгэгдэх ёстой гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх хүчин чармайлт тодорхой үр дүнд хүрэлгүй байсаар байна. Минова тосгонд 130 гаруй охид эмэгтэйчүүдийг хомроглон хүчиндэж, хүмүүсийг алж хядан, тонож дээрэмдсэн Конго улсын цэргүүдийн хэргийг цэргийн шүүхээр авч хэлэлцсэн боловч хүчингийн хэрэгт яллагдагчаар татагдсан 39 цэргээс зөвхөн хоёрт нь л ял оноожээ. Яллагдагчаар татагдсан бусад цэргүүд нь хүн амины хэрэг, дээрэм тонуул болон цэргийн гэмт хэрэгт ял сонссон байна.

Буруутай этгээдэд зохих хариуцлага хүлээлгэж чадахгүй байгаа нь мөргөлдөөний бүсээс гадна ч асуудал үүсгэж байгаа бөгөөд хүний эрхийг зөрчигчид эрх чөлөөтэй явсаар байна.

Экваторын Гвиней, Эритрей, Этиоп, Гамби, Мавритани, Нигерия болон Того улсад дэгээр гэмт хэргийг үйлдэгчид ял завшаар байгаа учраас хүмүүсийг эрүүдэн шүүх буюу бусад хэлбэрээр хүнлэг бус харьцах явдал үргэлжилсээр

байна.

2007-2008 онд Кени улсад гарсан сонгуулийн дараахи хүчирхийлэлтэй холбоотой олон улсын гэмт хэрэг, түүний дотор хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хариуцлага тооцох явдал хангалтгүй хэвээр байна. Олон улсын эрүүгийн шүүх тус улсын дэд ерөнхийлөгч Самозэй Руро ба Жошуа Арап Санг нарын хэргийг гэрч нарыг сүрдүүлэх буюу худалдаж авсан тухай шуугианыг эс харгалзан үргэлжилсээр байна. Олон улсын эрүүгийн шүүхийн прокуророос Кени улсын засгийн газар хамтран ажиллахаас татагалзаж байгаа тухай гаргасан гомдлыг хүлээж аваагүй учраас ерөнхийлөгч Ухуру Кенятагийн эсрэг үүсгэсэн хэргийг хүчингүй болгосон. Үндэсний төвшинд сонгуулийн дараахи хүчирхийллийн үед үйлдэгдсэн хүний эрхийн ноцтой зөрчлийн төлөө хариуцлага хүлээлгэх ажилд ямар ч ахиц гарсангүй.

Нөгөө талаар Олон улсын эрүүгийн шүүх 2014 онд Томас Лубанга Дылод оноосон ялыг хэвээр үлдээсэн. Тэрээр 2012 онд 15-аас доош настай хүүхдүүдийг цэрэгт татаж, тэднийг Ардчилсан Конго улсад өрнөж байсан зэвсэгт мөргөлдөөнд татан оролцуулсан дайны гэмт хэрэг үйлдсэн хэрэгт буруутай нь тогтоогдоод байсан юм. Түүнчлэн Force de Résistance Patriotique en Ituri бүлэглэлийн командлагч Жермайн Катанга хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон дайны гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдож 12 жилийн хорих ялаар шийтгэгдсэн. Олон Улсын Эрүүгийн Шүүх Боско Нтаганда гэгчийг 2002-2003 онд Ардчилсан Конго улсын Итури мужид хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны

гэмт хэрэг, түүний дотор бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн хэргээр шүүхэд татсан болохыг нотлов. Шүүх хурлыг 2015 оны 6-р сард хийхээр товлосон. Кот д'Ивуарын ерөнхийлөгч асан Лорен Гбагод хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэмээн үүсгэсэн хэргийг Олон Улсын Эрүүгийн Шүүх 6-р сард нотолсон. Одоогоор шүүх хурлыг 2015 оны 7-р сард хийхээр товлоод байна.

Олон улсын гэмт хэргээс ял завших явдалтай тэмцэх үндэсний хүчин чармайлтын нэг жишээ бол Мали улс хүчээр сураггүй алга болгосон хэргүүдийг мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлсэн явдал мөн. 2013 оны 7-р сард Чад улсын ерөнхийлөгч асан Хиссен Хабре 1982-1990 онд Чад улсад үйлдэгдсэн хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон дайны гэмт хэрэгт буруутган баривчилсан бөгөөд тэрээр Сенегал улсад уг хэрэгт зориулан байгуулсан Африкийн Онцгой Танхимаар хэргээ шүүлгэхийг хүлээж байна.

3-р сард Кот д'Ивуар улс Олон Улсын Эрүүгийн Шүүх 2010 оны сонгуулийн дараа хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэрэгт буруутгасан Чарльз Бле Гудег баривчлан хүлээлгэж өглөө. 12-р сард Олон Улсын Эрүүгийн Шүүхийн урьдчилсан шүүх хуралдаанаар түүнийг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн 4 тохиолдолд буруутай гэдгийг тогтоож, хэргийг эцэслэн шүүх шийдвэр гаргасан. Мөн 12-р сард Олон Улсын Эрүүгийн Шүүхийн урьдчилсан шүүх танхим Кот д'Ивуар улсаас Симоне Ггабогийн эсрэг үүсгэсэн хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг ОУЭШ шүүн таслах эрх зүйн үндэс байгаа эсэх талаар

гаргасан гомдлыг няцаасан.

10-р сард Өмнөд Африкийн Үндсэн хуулийн шүүх Өмнөд Африкийн Цагдаагийн алба болон Африкийн Хүний эрхийн Маргаан таслах төв хоёрын оролцсон хэрэг болон өөр нэг хэргийг хэлэлцээд шүүхийн түгээмэл байдлын талаар онцгой ач холбогдолтой шийдвэр гаргасан юм. Өмнөд Африкийн Үндсэн хуулийн шүүх уг шийдвэртээ Зимбабве улсад Зимбабве улсын иргэдийн эсрэг Зимбабве улсын иргэдийн үйлдсэн эрүү шүүлтийг шүүхийн түгээмэл байдлын зарчимд үндэслэн Өмнөд Африкийн Цагдаагийн алба мөрдөн шалгах ёстой гэж дурдсан.

Гэвч олон улсын болон бүс нутгийн төвшинд олон улсын шударга ёсны талаар Африк тивд өмнө нь хүрээд байсан амжилтаасаа ихээхэн ухарсан. Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрэмд бусад бүс нутагтай харьцуулахад хамгийн олон буюу Африк тивийн 34 улс нэгдэн орсон боловч 2014 улс төрийн шалтгаанаар хариуцлага тооцох чиглэлээр хүрсэн амжилтаа сулруулсан. Тухайлбал Кени улс Ромын дүрэмд 5 нэмэлт өөрчлөлт оруулахыг, түүний дотор 27-р зүйлд албаа хашиж буй төрийн тэргүүн ба засгийн газрын тэргүүнийг Олон Улсын Эрүүгийн Шүүх шүүх ёсгүй гэсэн нэмэлт өөрчлөлт оруулахыг санал болгосон.

Африкийн холбооны сайд нар 5-р сарын хурлаараа Африкийн Шударга Ёс ба Хүний эрхийн Шүүхийн дүрмийн протоколд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж, уг шүүхийн шинээр хамаарах болсон эрүүгийн гэмт хэргээр шүүхэд дуудагдахгүй байх дархан эрхийг эдлэх

хүмүүсийн жагсаалтыг өргөтгөх талаар тохиролцсон. Африкийн холбооны 23-р ээлжит чуулганаар албаа хашиж буй Африкийн удирдагчдыг геноцид, дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт холбогдуулан шүүхэд татахгүй байх халдашгүй эрх олгох зорилготой уг нэмэлт өөрчлөлтийг эцэслэн батласан нь өмнөхөөсөө ухарсан алхам болсон төдийгүй хохирогчдоос урвасан хэрэг мөн. Төрийн тэргүүнүүд болон засгийн газрын тэргүүнүүд олон улсын гэмт хэргийн хохирогчдод шударга үнэнийг тогтоож өгөхийн оронд өөрсдийгөө болон ирээдүйн удирдагчдыг хүний эрхийн ноцтой зөрчлийн төлөө шүүхээр шалгагдахгүй байхыг сонголоо. Гэсэн хэдий боловч Олон Улсын Эрүүгийн Шүүх албаа хашиж буй Африкийн төрийн тэргүүнүүд болон Ромын дүрэмд нэгдэн орсон аливаа улсын засгийн газрын тэргүүнүүдийн хэргийг шүүн таслах эрхээ хадгалах болно. 2014 он Африкийн зарим улс болон Африкийн холбоо Олон Улсын Эрүүгийн Шүүхийн үйл ажиллагааг сулруулах талаар идэвхийлэн зүтгэсэн жил байлаа хэмээн түүхэнд тэмдэглэгдэх болно.

ЯДУУРАЛ БА ЗҮДҮҮРЭЛ

2014 оны туршид эдийн засаг хурдацтай өссөн хэдий ч олон африкчуудын амьдралын нөхцөл сайжирсангүй. Олон улс орон Мянганы хөгжлийн зорилтуудад хүрэх чиглэлд гайхамшигтай дэвшил гаргасан боловч Африк тив хөгжиж буй бусад бүс нутагтай харьцуулахад 2015 онд тэдгээр зорилтод хүрэхэд ихээхэн хоцорч байгаа юм. Африкийн ядуурлын хэмжээ буурч байгаа хэдий ч 2015

онд ядуурлын хэмжээг тал хувиар бууруулах зорилтод хүрэх хэмжээнд эрчимтэй буурч чадахгүй байна. Үнэн хэрэгтээ ядуурлын төшингөөс (өдөрт 1.25 доллараас бага) доогуур амьдарч буй африкчуудын тоо өссөн үзүүлэлттэй байна. Мөн дутуу жинтэй хүүхдийн тоо болон эхийн эндэгдлийг бууруулах зэрэг бусад зорилтод хүрч чадахгүй нь тодорхой болоод байна.

Африкийн хотууд урьд байгаагүйгээр хурдан өргөжин тэлж, хотжилт гүнзгийрэхийн хэрээр аюулгүй байдал алдагдаж, тэгш бус байдал даамжирч байна. Хотын ядуурлын улмаас маш олон хүн, ялангуяа зөвшөөрөлгүй газар болон ядуусын хороололд амьдарч байгаа хүмүүс шаардлага хангасан орон байр, бусад наад захын зүйлсээр хангагдаж чадахгүй байна. Хүчээр нүүлгэн шилжүүлсний улмаас хүмүүс аж амьдрал, эд хөрөнгөнөөсөө салж, ядуурлын ангал руу улам гүнзгий орж байна. Ангол улсын Луанда мужид дор хаяж 4000 гэр бүлийг хүчээр нүүлгэсэн. Кени улсын шүүх шаардлага хангасан орон байраар хангагдах эрхийг хүлээн зөвшөөрч, хүчээр нүүлгэн шилжүүлэхийг хориглосон шийдвэр гаргасаар байна. Дээд шүүх 2013 онд тус улсын нийслэл Найроби дахь ядуусын суурингаас албадан нүүлгэсэн оршин суугчдад засгийн газар 390 000 орчим долларын нөхөн олговор олгохыг үүрэг болгосон шийдвэр гаргасан.

Баруун Африкийн зарим оронд 3-р сард вируст эбола өвчин дэгдсэн бөгөөд ДЭМБ уг үйл явдлыг 1976 оноос хойш гарсан эбола вирус хамгийн өргөн бөгөөд ноцтой тархалт гэж тодорхойлсон. 2014 оны эцсийн

байдлаар Гвиней, Либери, Мали, Нигериа болон Сьерра Леон улсад 8000 хүн эбола өвчнөөс болж амиа алдаад байв. 20 000 орчим хүн халдвар авсан бөгөөд 2015 оны эхээр хүнсний томоохон хямрал үүсч болзошгүй гэсэн болгоомжлол байна. Эрүүл мэндийн үйлчилгээ сүйрлийн ирмэгт хүрсэн.

Уг өвчинд хамгийн их нэрвэгдсэн Гвиней, Либери, Сьерра Леон зэрэг улс удаан жилийн хямрал мөргөлдөөн, тогтворгүй байдлаас дөнгөж саяхан гарсан тул эрүүл мэндийн тогтолцоо нь маш сулхан байсан. Гвиней улсад олон зуун хүн, түүний дотор 70 гаруй эрүүл мэндийн ажилтан нас барсан хэдий ч засгийн газрын цаг алдсан хариу арга хэмжээ, нөөц бололцоо дутмаг байсан зэрэг нь эбола өвчний хурдацтай бөгөөд аюултай тархалтад ихээхэн түлхэц болсон.

Дээрхи бүхэн засгийн газар иргэдийнхээ боломжтой дээд төвшинд эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхийг хүндэтгэн, хамгаалж, хэрэгжүүлэх үүргээ хэрэгжүүлж чадахгүй байгааг харуулсан төдийгүй энэхүү хямралын эсрэг олон улсын хамтын нийгэмлэг зохих хариуг өгч чадаагүй. 2014 оны эцсийн байдлаар хүмүүнлэгийн тэргүүлэх байгууллагууд олон улсын хамтын нийгэмлэгээс илүү их дэмжлэг үзүүлэхийг уриалсаар байв. НҮБ эболагийн тархалтыг зогсоохын тулд 2014 оны 10-р сараас 2015 оны 3-р сар хүртэл нийт 1.5 тэрбум доллар шаардлагатай гэж мэдэгдсэн боловч 12-р сарын байдлаар зөвхөн 1.2 тэрбум доллар цуглараад байна. Хэрэв өвчний тархалт энэ хурдаараа үргэлжилбэл 2015 оны 4-р сараас 2015 оны 9-р сар хүртэл дахин 1.5 тэрбум доллар

шаардлагатай болно гэж НҮБ тооцоолж байна.

АЛАГЧЛАЛ БА НИЙГМЭЭС ГАДУУРХАЛТ

Олон зуун мянган хүн зэвсэгт мөргөлдөөн, улс төрийн мөрдлөг мөшгилтөөс болж эсхүл илүү сайхан амьдрал хайж нутгаа орхин дүрвэж байна. Тэдний олонхи нь улс орныхоо дотоодод буюу олон улсын хил хязгаарыг гатлан аюулгүй амьдрах газар олохоор орон гэрээсээ дүрвэхээс аргагүйд хүрч, аюултай бөгөөд эрсдэлтэй алхам хийдэг. Маш олон дүрвэгчид ба цагаачид галын шугамд хоригдож, илүү их хүчирхийлэлд өртдөг бол түүнээс ч олон хүн эрүүл мэнд, ус, ариун цэвэр, хүнс, боловсролын үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал дүрвэгчдийн хуаранд амьдрахаас аргагүйд хүрдэг.

Дээрхи тоон дээр Эритрей улсаас сар болгон дүрвэж байгаа олон мянган хүн нэмэгдэнэ. Тэдний олонхи нь хугацаагүй цэргийн албанд татдаг тогтолцооноос зайлсхийсэн байдаг. Тэдний дундаас олон хүн хүний наймааны сүлжээ, түүний дотор Судан болон Египет улсын хүний наймааны сүлжээнд өртдөг. Камерун улсад Төв Африкийн БНУ болон

Нигериа улсын зэвсэгт бүлэглүүдээс дайжин ирсэн дүрвэгчид хил орчмын нутагт хүний тоо нь хэтэрсэн, наад захын шаардлага хангаагүй дүрвэгчдийн хуаранд амьдарч байна. Судан улс дахь хямрал мөргөлдөөнөөс болж нэг сая гаруй хүн дотоодын дүрвэгч болсон бөгөөд 600 000 хүн Чад, Өмнөд Судан, Этиоп улсын дүрвэгчдийн хуаранд амьдарч байна. Кени улс дахь Сомалийн

олон мянган дүрвэгчдийн нөхцөл байдал тэднийг хүчээр хуаран руу нүүлгэх бодлого буюу амьдарч буй орон гэрээс нь хөөж хүмүүс чихэлдсэн, бохир хуаранд амьдруулах бодлогын улмаас ихээхэн доройтжээ. Өмнөд Африк улс дахь дүрвэгчид ба орогнол эрэгчдийн эсрэг гадаадынхныг үзэн ядах үзлийн халдлага үйлдэгдсээр байгаа бөгөөд эрх баригчдын зүгээс тэдэнд өчүүхэн төдий буюу огт хамгаалалт үзүүлэхгүй байна.

Бусад олон бүлгийн хүмүүс хүний эрхийн хамгаалалтаас ангид байгаа буюу хохирлоо барагдуулах эрхээ эдлэж чадахгүй байна. Хямрал мөргөлдөөнд нэрвэгдсэн нийгмийн хатуужлыг бэхжүүлэхэд эмэгтэйчүүд гол үүрэг гүйцэтгэж чадах ч тэднийг үндэсний энхийг цогцлоох үйл явцын гадна үлдээх тохиолдол олон байна. Хямрал мөргөлдөөнд нэрвэгдсэн буюу их хэмжээний дүрвэгчдийг ороггнуулж байгаа улсуудад, тухайлбал Өмнөд Судан болон Сомали улсад охид эмэгтэйчүүд хүчин болон бусад хэлбэрийн бэлгийн хүчирхийллийн золиос болох нь элбэг байна. Хямрал мөргөлдөөнөөс ангид байгаа орнуудын хувьд ч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл түгээмэл байгаа нь зарим тохиолдолд соёл, заншлын хэм хэмжээтэй холбоотой хэдий ч зарим улсад хүйсэд суурилсан алагчлалыг хууль тогтмоожоороо баталгаажуулсан байдагтай холбоотой.

Лесби, гей, бисексуаль, трансгендер болон интерсекс (ЛГБТИ) хүмүүсийн хувьд 2014 онд Африкийн Хүний болон Ард түмнүүдийн эрхийн комисс хүмүүсийг бэлгийн чиг баримжаа, хүйсийн онцлог шинж дээр нь

үндэслэн хүчирхийлэх, алагчлах буюу бусад байдлаар хүний эрхийг нь зөрчих явдлыг буруушаасан түүхэн тогтоол баталсан нь ихээхэн итгэл найдвар авчирсан. Тэгш байдал, шударга ёсны төлөө итгэл найдвар төрүүлсэн өөр нэг зүйл бол Малави улс ижил хүйсийн харилцан зөвшөөрсөн бэлгийн харилцааг гэмт хэрэгт тооцохоо болих амлалт авсан явдал юм.

Гэсэн хэдий боловч, Камерун, Гамби улсад, Сенегал, Уганда, Замби зэрэг олон оронд хүмүүсийг бэлгийн чиг баримжаанаас нь болж мөрдөн мөшгиж, гэмт хэрэг үйлдсэн хэмээн буруутгасаар байна.

Хэд хэдэн оронд өмнө хүрсэн амжилтаасаа ухарч, хүмүүсийг хүйсийн онцлог шинжээр нь гэмт хэрэгт үйлдсэнд тооцох явдлыг шударга бус хуулийн үйлчлэлийг өргөтгөх буюу шинээр хууль батлах замаар улам өргөжүүлж байна. Нигериа улсын ерөнхийлөгч

Ижил хүйсийн гэрлэлтийг хориглох тухай хуулийг батламжилснаар бэлгийн чиг баримжаа болон хүйсийн онцлог шинжид суурилсан алагчлалыг хуулиар зөвшөөрөв. Уганда улсын Үндсэн хуулийн шүүх хэдийгээр Ижил хүйстнүүдийн эсрэг хуулийг хууль бус гэсэн шийдвэр гаргасан боловч уг хуулийг ирц хүрээгүй ч парламентаар баталсан учраас олон ЛГБТИ буюу ЛГБТИ гэж тооцогддог хүмүүс хууль бусаар баривчлагдаж, зодуулж, гэр орноосоо хөөгдөж, ажлаасаа халагдах буюу хилэгнэсэн хүмүүсийн халдлагад өртсөөр байна.

2014 онд Гамби улсын ерөнхийлөгч тус улсын парламентаар батлагдсан Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг батламжилсан

бөгөөд “хүндрүүлсэн гомосексуаль үйлдэл” хэмээх маш өргөн хүрээтэй бөгөөд цаазаар авах ялаар шийтгүүлж болох гэмт хэргийн төрлийг бий болгосон. Мөн ижил хүйстнүүдийн эсрэг агуулгатай хуулийн төслийг Чад улсын парламентад өргөн барьсан бөгөөд түүнд ижил хүйстний үйл ажиллагаанд буруутай нь тогтоогдсон хүмүүст 20 хүртэл жилийн ял оноохоор тусгажээ.

ЦААШДЫН ТӨЛӨВ

2014 оны турш бүс нутаг даяар хувь хүмүүс хийгээд айл хотлууд хүний эрхийг ойлгох, хүндэтгэн сахих үйлсийг цогцлоож, бас бэхжүүлээ. Заримдаа амь нас, аюулгүй байдалдаа эрсдэл дагуулан байж дуу хоолойгоо өргөж, үйл хэргээ зориулж байгаа тэдгээр хүмүүсийн ачаар шударга ёс, хүний нандин чанар, итгэл найдварын төлөө хүний эрхийн хөдөлгөөн өргөжиж байна.

Гэсэн хэдий боловч, өнгөрсөн жил Африк тивд тулгарч буй хүний эрхийн сорилтуудын цар хэмжээ, хүний эрхийг хэрэгжүүлэхэд илүү гүнзгий, илүү хурдацтай ахиц гаргах хэрэгтэй байгааг харуулсан жил боллоо.

Болж өнгөрсөн үйл явдлууд Африк тивд ужиграад буй хямрал мөргөлдөөнийг намжаах, шийдвэрлэхэд нэгдсэн, тууштай арга хэмжээ хойшлуулшгүй авах шаардлагатай байгааг харууллаа. Цаашдаа Африк тив дэх бүх буу зэвсгийг чимээгүй болгох талаар Африкийн холбооны комиссын тавьж буй хүчин чармайлтыг дэмжин ажиллах хэрэгтэй байна. Хямрал мөргөлдөөнийг олон улсын хүний эрхийн болон хүмүүнлэгийн эрх зүйд тулгуурлан шийдвэрлэх

талаар олон улсын болоод бүс нутгийн байгууллагуудын аль аль нь илүү хүчтэй, тууштай, харилцан уялдаатай арга барилаар ажиллах шаардлага амин чухлаар тавигдаж байна.

Бүс нутагт энх тайван, аюулгүй байдал, шударга ёсыг тогтооход нэн түрүүнд шаардлагатай байгаа өөр нэг зүйл бол Африк тивийн улс орнууд олон улсын шударга ёс, түүний дотор Олон Улсын Эрүүгийн Шүүхийн үйл ажиллагааны эсрэг нэгдсэн дайралт хийхээ зогсоож, харин бүс нутгийн болон олон улсын төвшинд хүний эрхийн ноцтой зөрчлүүд болон олон улсын эрх зүйн бусад гэмт хэрэг үйлдэгчид ял завшиж байгаагийн эсрэг хатуу тэмцэх ёстой.

Ирэх жилүүд томоохон өөрчлөлт авчрах нь гарцаагүй. Мянганы хөгжлийн зорилтуудын дараа 2015 оноос хойшхи үйл ажиллагааны хүрээ нь Африкийн холбооны гишүүн улс орнуудад тоо томшгүй олон хүний амьдралыг дээшлүүлж чадах хүний эрхийн үйл ажиллагааны хүрээг зөвшилцөн тогтоох түүхэн боломж олгож байна. 2015 оноос хойшхи үйл ажиллагааны хүрээнд шударгаар шүүлгэх эрхийн талаар тодорхой зорилт, үзүүлэлтүүдийг тодорхойлох замаар хариуцлагын тогтолцоог суулгах шаардлагатай бөгөөд ингэхдээ оролцоо, тэгш байдал, алагчлахгүй байх, хуулийн засаглал болон бусад үндсэн эрх, эрх чөлөөг бэхжүүлэх явдалтай хослуулах ёстой.

АМЕРИК ТИВИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Америк тив даяар тэгш бус байдал, алагчлал, хүрээлэн буй орчны доройтол, ял завших явдал ужгирсан болон аюулгүй байдал алдагдаж, хямрал мөргөлдөөн өсөн нэмэгдэж байгаа нь хүмүүсийн эрхээ бүрэн дүүрэн эдлэх боломжийг хаасаар байна. Үнэндээ тэдгээр эрхийг хамгаалах тэргүүн эгнээнд байгаа хүмүүс ихээхэн хэмжээний хүчирхийлэлд өртөж байна.

2014 онд эдгээр хүний эрхийн зөрчлийн эсрэг Америк тив даяар Бразилаас АНУ, Мексикээс Венесуэл хүртэл олон нийт шийдвэртэй эсэргүүцсэн. Нэг улсын дараа нөгөө улсад хүмүүс гудамжинд гарцгааж, төр засгийн зүгээс явуулж байгаа дарангуйлал, хэлмэгдүүлэлтийг эсэргүүцсэн. Эдгээр жагсаал цуглаан нь өндөр албан тушаалтнуудыг ял завшуулдаг, авлигад идэгдсэн, цөөхөн хэдэн хүнд давуу тал олгодог эдийн засгийн бодлогыг сөрсөн олон нийтийн дуудлага байсан билээ. Олон зуун мянган хүн аяндаа гарсан эдгээр хөдөлгөөнд шинэ технологи болон нийгмийн сүлжээг ашиглан нэгдэж, ингэснээрээ илүү олон хүнийг эгнээндээ элсүүлж, мэдээлэл харилцан солилцож, хүний эрхийн зөрчлийг олон нийтэд дэлгэсэн юм.

Хүний эрхийг хүндэтгэн сахихыг шаардсан эдгээр уур хилэн, гутрал, шаардлагууд нь ардчиллын орон зай хумигдаж, өөрөөр сэтгэгчдэд ял тулгах болсон цаг үед тохиож байгаагаараа онцлог юм. Төрийн ба төрийн бус оролцогчдын нийт ард иргэд болон ялангуяа нийгмийн

хөдөлгөөнийхөн болон идэвхитнүүд эсрэг хүчирхийлэл үйлдэх нь өсвөр байна. Бүс нутгийн ихэнхи оронд хүний эрхийг хамгаалагчдын эсрэг халдлагын тоо хэмжээ төдийгүй хүчирхийллийн төвшин мэдэгдэхүйц нэмэгдсэн.

Хүчирхийлэл ийнхүү өсөн нэмэгдэж байгаа нь сүүлийн жилүүдэд нийгмийн болон улс төрийн бэрхшээлтэй асуудлыг юуны түрүүнд цэрэг зэвсгийн хүчээр шийдэх гэх болсонтой холбоотой. Бүс нутгийн олон оронд эрх баригчид хямрал мөргөлдөөн бий болсныг албан ёсоор хүлээн зөвшөөрөөгүй хэдий ч гэмт хэргийн сүлжээ, нийгмийн сөргөлдөөн зэргийн эсрэг хүч хэрэглэх нь түгээмэл үзэгдэл болоод байна. Зарим газарт гэмт хэргийн сүлжээ болон зэвсэгт бүлэглэлүүд, үндэстэн дамнасан корпорациуд зэрэг бусад хувийн хэвшлийнхэн эрх мэдэл улам бүр өсөн нэмэгдэж байгаа нь төрийн эрх мэдэл, хууль дээдлэх ёс болон хүний эрхэд нэлээд сорилт бий болгож байна.

Хүний эрхийн ноцтой зөрчил тус бүс нутгийн олон арван мянган хүмүүсийн амьдралд хохирол учруулж байна. Бүх хүнд хүний эрхийг тэгш эдлүүлэх чиглэлээр ахиц дэвшилд хүрэхийн оронд 2013-2014 онд тус бүс нутаг харин ч ухралт хийсэн.

НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын мэдэгдсэнээр 2014 оны эхний 9 сарын байдлаар Америк тивд хүний эрхийн хамгаалагч 40 хүний амь насыг хөнөөжээ. 10-р сард Америк дундын Хүний эрхийн шүүх Доминиканы эрх баригчдыг Хаити гаралтай Доминиканчууд болон Хаитигаас ирсэн цагаачдыг ялгаварлан гадуурхаж байна хэмээн буруутгасны хариуд Доминиканы БНУ уг шүүхийг нээлттэйгээр шүүмжиллээ.

9-р сард Мексикийн Аяотзинапа хотын багшийн коллежийн 43 оюутныг хүчээр сураггүй болгожээ. Тэдгээр оюутныг Герреро мужийн Игуала хотын орон нутгийн цагдаа зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээтэй хуйвалдан хорьсон ажээ. 12-р сарын 7-нд Холбооны Ерөнхий прокурор тэдгээр оюутны нэгнийх нь цогцсыг хараат бус шүүхийн шинжээчид хэн болохыг нь тогтоосон гэж мэдэгдсэн. Оны эцэс гэхэд үлдсэн 42 оюутны хувь заяа хэрхсэн нь тодорхойгүй байв.

8-р сард АНУ-ын Миссури мужийн Фергусон хотод цагдаагийн ажилтан Даррен Вильсон 18 настай, гартаа зэвсэг бариагүй, Африк гаралтай Америк залууг буудаж хөнөөсөн. Энэ явдлын улмаас хүмүүс гудамжинд гарч эсэргүүцлээ илэрхийлсэн бөгөөд 11-р сард тангарагтны шүүхээс уг цагдаагийн албан хаагчийг буруугүй гэж үзсэнийг эсэргүүцсэн хөдөлгөөн өрнөсөн бөгөөд тус улсын томоохон хотууд түүний дотор Нью Йорк хотод 12-р сард 7-р сард Эрик Гарнер гэдэг хүнийг хөнөөсөн цагдаагийн ажилтныг буруугүй гэж тангарагтны шүүх үзэн суллах шийдвэр гаргасан нь байдлыг улам дордуулсан.

Түүнчлэн 8-р сард тариачдын нэр хүндтэй удирдагч Маргирита Муриллог Хондурасын баруун хойд зүгт оршдог Эль Планон хотод буудан хөнөөсөн. Тэрээр цагдаагийн хяналтад байсан бөгөөд халдлага болохоос хэдхэн хоногийн өмнө түүнийг заналхийлсэн байна.

Венесуэл улсад 2-р сард аюулаас хамгаалах хүчнийхэн болон засгийн газрын талынхныг дэмжигчдийн хооронд гарсан мөргөлдөөний үеэр 43 хүн, түүний дотор аюулаас хамгаалах хүчнийхэн амь насаа алдсан бөгөөд түүнээс ч

олон хүн бэртэж гэмтлээ.

2013 онд Эль Сальвадор улсад Беатриз хэмээх залуу эмэгтэйд хэдийгээр амь насанд нь шууд эрсдэл тулгарч байсны зэрэгцээ түүний хэвлий дэх ургийн тархи, гавлынх нь нэг хэсэг байхгүй, бас эхийн хэвлийгээс гадна амьдрах чадваргүй байсан ч үр хөндүүлэхийг зөвшөөрөөгүй. Беатризын нөхцөл байдал үндэсний болоод олон улсын төвшинд хүмүүсийн уур хилэнг бадраасан бөгөөд хэдэн долоо хоногийн турш эрх баригчдад шахалт үзүүлсний эцэст түүнд жирэмсний 23 дахь долоо хоног дээр нь хийсвэр хийхийг зөвшөөрсөн. Эль Сальвадор улс үр хөндөлтийг бүрмөсөн хориглодог нь охид эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн сонголтыг гэмт хэрэг болгож, тэднийг амь насаа эсхүл эрх чөлөөгөө алдах эрсдэл рүү түлхсээр байна. 2014 онд жирэмслэлттэй холбоотой асуудлаар 40 хүртэл жилийн хорих ял сонссон 17 эмэгтэй өршөөл хүссэн бөгөөд оны эцсийн байдлаар тэдний өргөдөл шийдэгдээгүй байв.

2013 оны 5-р сард Гватемал улсын ерөнхийлөгч асан Генерал Эфрэйн Риос Монттод геноцид ба хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэмээн ял оноов. Харамсалтай нь ердөө 10 хоногийн дараа түүнд оноосон ялыг техникийн шалтгаанаар хүчингүй болгосон нь 30 гаруй жил шударга ёсыг хүсэмжилсэн хохирогчид болон тэдний хамаатнуудад хүнд цохилт боллоо. Риос Монтт нь 1982-1983 оны дотоодын зэвсэгт мөргөлдөөний үеэр 1771 Маяан-Иксил уугуул иргэдийг амь насаа алдаж, эрүү шүүлт, бэлгийн

хүчирхийлэл, хүчээр нүүлгэн шилжүүлэхийн золиос болж байх цагт Ерөнхийлөгч бөгөөд армийн Ерөнхий командлагч байжээ.

Хүний эрх ноцтойгоор зөрчигдсөн тухай энэхүү урт жагсаалт хэдийгээр бүс нутгийн улс орнууд бүс нутгийн болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, гэрээ конвенцийг соёрхон баталж, идэвхийлэн дэмждэг боловч хүний эрхийг хүндэтгэн сахих явдал бүс нутгийн олон хүний хувьд хоосон үг хэвээр байгааг харуулж байна.

НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХҮНИЙ ЭРХ

Засгийн газрын бодлогын эсрэг эсэргүүцлийг дарахын тулд аюулаас хамгаалах хүчнийхэн хүч хэтрүүлэн хэрэглэх явдал хаа сайгүй гарсаар байна. Бразил, Канад, Чили, Эквадор, Гватемал, Хаити, Мексик, Перу, АНУ болон Венесуэл улсад аюулаас хамгаалах хүчнийхэн нийтийн дэг журмыг хамгаалах нэрээр хүч хэрэглэхдээ олон улсын хэм хэмжээг зөрчсөөр байна. Хүч хэтрүүлэн хэрэглэх явдлыг огт хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ тов тодорхой илэрхийлэхийн оронд засгийн газрууд хүчирхийлэл үйлдэгдсэн нөхцөлд ч асуудлыг тодруулахыг хүсэхгүй байна.

2014 оны эхээр Венесуэл улсын өнцөг булан бүрт засгийн газрыг эсэргүүцэгчид болон дэмжигчид оролцсон нийтийг хамарсан жагсаал цуглаан өрнөсөн. Тэрхүү эсэргүүцлийн хөдөлгөөн хийгээд эрх баригчдын хариу үйлдэл зэрэг нь тус улсад арав гаруй жил ужгирсан туйлшралын илрэл юм. Нийгмийн сэтгэл ханамжгүй байдал болон жагсагчид ба аюулаас хамгаалах хүчнийхний хоорондох хүч хэрэглэсэн

мөргөлдөөнөөс үүдэн өргөн хүрээтэй хүний эрхийн зөрчил, түүний дотор аллага, дур зоргоор баривчлах, эрүү шүүлт болон бусад байдлаар харгис, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах явдал даамжирсан. Мянга мянган жагсагчдыг баривчилсны дотор олон хүнийг хууль бусаар баривчилсан бөгөөд тэдэнд эрүү шүүлт тулгах буюу бусад байдлаар зүй бусаар харьцсан тухай мэдээлэл ирсэн. Жагсаал цуглаан хөдөлгөөнийг дарахаар аюулаас хамгаалах хүчний явуулсан ажиллагааны улмаас наад зах нь 43 хүн алагдаж, 870 хүн шархадсан бөгөөд тэдний дунд аюулаас хамгаалах хүчнийхэн ч мөн багтсан.

Бразил улс 2014 оны Дэлхийн хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээний бэлтгэл ажлыг хангаж байх үеэр мянга мянган хүмүүс гудамжинд гарч эсэргүүцлээ илэрхийлсэн.

Жагсагчид нийтийн тээврийн үнийг нэмснийг болон нийтийн үйлчилгээнд хангалттай хөрөнгө оруулалт хийгээгүй атлаа Хөл бөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд асар их хөрөнгө зарцуулж байгаад сэтгэл дундуур байгаагаа илэрхийлж байв. Эсэргүүцлийн цар хэмжээ урьд хожид үзэгдээгүй өргөн хүрээтэй байсан бөгөөд олон зуун мянган хүн олон арван хотод олныг хамарсан жагсаал цуглаанд оролцсон. 2013 ба 2014 онд өрнөсөн эсэргүүцлийн давалгааны эсрэг, түүний дотор Хөл бөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний үеэр цагдаагийн байгууллага ажиллахдаа олон тохиолдолд хүч, эрх мэдлээ хэтрүүлэн хэрэглэж байв. Цэрэг цагдаагийн

нэгтгэлүүд нулимс асгаруулагч хийг жагсагчдын эсрэг ялгаварлалгүй хэрэглэж байсан ба нэг удаа бүр эмнэлэг дотор хэрэглэсэн тохиолдол гарсан. Түүнчлэн тэд ямар ч гэмгүй хүмүүсийг резинэн сумаар буудаж, бороохойгоор зодож байв. Олон зуун хүн гэмтэж бэртсэний дотор гэрэл зурагчин Сержио Сильва резинэн суманд оногдсоны улмаас зүүн нүдээ алджээ. Зуу зуун хүнийг бөөнөөр нь баривчлан хорьсны дотор тухайн хүн ямар нэг гэмт хэрэгт оролцсон гэх ямар ч нотолгоо байхгүй байхад тэдний заримыг зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн дагуу баривчилсан байна.

АНУ-д Майкл Брауныг буудан хөнөөсөн хэрэг хийгээд тангарагтны шүүх уг хэргийг үйлдсэн цагдаагийн ажилтанд хэрэг үүсгэхээс татгалзсан шийдвэр гаргасан нь Фергусон хот болон түүний ойр орчимд хэдэн сар үргэлжилсэн эсэргүүцлийн галыг ноцоосон юм. Босогчдын эсрэг хэрэглэдэг хүнд тоноглол, цэргийн зориулалттай зэвсэг хэрэгсэл ашиглаж байсан нь тайван замаар жагсаал цуглаан хийх эрхээ хэрэгжүүлж байсан жагсагчдыг айлган сүрдүүлэх зорилготой байв. Жагсагчид болон сэтгүүлчид аюулаас хамгаалах хүчнийхний хэрэглэсэн резинэн сум, нулимс асгаруулагч хий болон жагсаал цуглааныг тараах бусад түрэмгий тактикийн улмаас гэмтэж бэртсэн бөгөөд цагдаагийнхан хуулиар тухайн нөхцөлд тийм үйл ажиллагаа явуулах эрхгүй байсан.

ЭРҮҮ ШҮҮЛТ БА БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ ХАРЬЦАХ

Америк тив нь үндэсний болон бүс нутгийн төвшинд эрүүдэн шүүхийн

эсрэг чиглэсэн хамгийн хүчтэй хууль тогтоомж, механизмтай газар билээ. Хэдий тийм боловч бүс нутаг даяар эрүү шүүлт тулгах буюу бусад хэлбэрээр хэрцгий харьцах явдал өргөн тархсан бөгөөд буруутай этгээдүүдийг шударга шүүхээр шүүж чадахгүй байна.

Эмнести Интернэшнл *“Хяналтаас гарсан нь: Мексик улсад эрүү шүүлт тулгах буюу бусад хэлбэрээр хэрцгий харьцаж байгаа нь”* хэмээх тайландаа тус улсад уг хууль бус практик сэтгэл түгшмээр ихээр нэмэгдсэн тухай дурдсан. Тайланд сүүлийн 10 жилд Мексик улсад эрүү шүүлтийг хүлцэн тэвчиж, буруутнууд нь ял завших практик ихээхэн өргөн дэлгэрснийг онцолсон бөгөөд энэ хугацаанд холбооны шүүхээс зөвхөн 7 хүнд бусдыг эрүүдэн шүүсэн хэргээр ял оноожээ. Муж улсын төвшинд бүр ч цөөн хүн ийм хэргээр ял сонссон байна.

Мексик улсад хүний эрхийн зөрчлийг, тухайлбал багшийн коллежийн 43 оюутан сураггүй алга болсон хэргийг хагас дутуу, хязгаарлагдмал хүрээнд мөрдөн шалгасан нь Мексикийн засгийн газрын зүгээс өргөн тархсан, ужгирсан авилгын хэргүүд болоод төрийн албан хаагчид болон зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээний хуйвалдааныг мөрдөн шалгах ажил ихээхэн учир дутагдалтай, буруутай этгээдүүд ял завших явдал ердийн үзэгдэл болсныг тод харуулсан билээ.

Эрүү шүүлт болон бусад хэлбэрээр хэрцгий харьцах явдлыг гэмт хэрэгт сэжигтнээр татагдсан хүмүүсээс мэдээлэл олж авах, гэм буруугаа хүлээсэн мэдүүлэг гаргуулах, эсхүл тэднийг цээрлүүлэх зорилгоор хэрэглэх нь түгээмэл

байна. Даниел Кинтеро хэмээх 23 настай оюутан 2014 оны 2-р сард Венесуэл улсад болсон засгийн газрын эсрэг жагсаал цуглаанд оролцсон хэргээр хоригдсон бөгөөд түүнийг өшиглөж, нүүрэн дундуур нь болон хавирган дундуур нь цохиж, хүчиндэнэ гэж сүрдүүлж байжээ. Доминиканы БНУ-д 2014 оны 4-р сард Ана Патрисиа Фермин хэмээх эмэгтэй түүний хоёр хамаатныг нийслэл Санто Доминго хотын цагдаа хорьж саатуулж байхдаа эрүүдэн шүүсэн талаар гомдол гаргасны дараа түүний амь насанд заналхийлсэн байна. Түүний нөхөр болсон эрүү шүүлтэд өртсөн хамаатных нь нэгийг 9-р сард цагдаа буудан хороосон юм.

ШУДАРГА ҮНЭНИЙГ ТОГТООХ БА ЯЛ ЗАВШИХ ЯВДЛЫГ ЗОГСООХЫН ТӨЛӨӨХ ТЭМЦЭЛ

Олон хүний хувьд, тэр дундаа хамгийн ядуу айл хотлоос гаралтай хүмүүсийн хувьд шударга шүүхээр шүүлгэх эрх бүтэшгүй зүйл мэт санагддаг. Шударга шүүхээр шүүлгэхэд учирдаг гол саад бол үр дүн муутай хууль шүүхийн тогтолцоо, хууль шүүхийн хараат бус байдал хангагдаагүй байх, зарим салбарынхны хариуцлага хүлээхээс зайлсхийхийн тулд болон улс төрийн, гэмт хэргийн болон эдийн засгийн ашиг сонирхлоо хамгаалахын тулд эрс шийдэмгий арга хэмжээ авахад бэлэн байдаг явдал юм.

Шударга үнэнийг тогтооход учирч байгаа бэрхшээлийг хүний эрхийг хамгаалагчид, гэрчүүд, хуульчид, прокурорууд болон шүүгчдийн эсрэг хийгдэж буй халдлагууд улам ч хүндрүүлж байна. Ингэхдээ эрх мэдлээ

урвуулан ашиглах, хүний эрхийн зөрчил, авлигын хэргийг олон нийтэд дэлгэхийг зорьсон сэтгүүлчдийг онилох нь түгээмэл. Түүнчлэн, хүний эрхийн зөрчил үйлдсэн аюулаас хамгаалах хүчний гишүүдийн хэргийг олон оронд, түүний дотор Чили, Эквадор АНУ зэрэг улсад цэргийн шүүхээр оруулж шийтгэх явдал арилахгүй байгаа нь шүүх ажиллагаа хараат бус бөгөөд шударга явагдана гэдэгт эргэлзээ төрүүлсээр байгаа юм.

Өнгөрсөн зуунд цэргийн дэглэмүүд, түүний дотор Аргентин, Чилийн эрх баригчдын үйлдсэн хүний эрхийн зөрчлийг мөрдөн шалгах ажиллагаа болон яллах ажиллагаанд зарим нэг ахиц гарлаа. Гэвч тус бүс нутагт 20-р зууны сүүлийн хагаст мянга мянган хүний хүчээр сураггүй алга болгож, шүүхээс гадуур цаазалсан этгээдүүд ял завшсан хэвээр байгаа нь тэднийг шүүхэд татаж үнэн мөнийг тогтоох улс төрийн зориг эрмэлзэл дутуу байгаагаас ихээхэн шалтгаалж байна. Янз бүрийн оронд, түүний дотор Бразил, Боливи, Эль Сальвадор, Гватемал, Хаити, Мексик, Парагвай, Перу болон Уругвай улсад мянга мянган хохирогчид болон тэдний ар гэрийнхэн шударга үнэнийг тогтоохыг шаардсаар байна.

ШОРОНГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Бүс нутгийн хэмжээнд сүүлийн 20 жилд хоригдлуудын тоо асар их нэмэгдсэн бөгөөд хүний эрхийн байгууллагууд Латин Америкийн шоронгуудад ял эдлэнэ гэдэг амьд үлдэхийн төлөө тэмцдэг зүүдэнд ормоор аймшигтай газар болсныг олон удаа баримтжуулсан. Эрүүгийн хэргийг шүүн таслах

ажиллагааны хүнд суртлаас шалтгаалж олон арван мянган хүн урьдчилан хорих байранд удаан хугацаагаар хоригддог.

Латин Америк ба Карибын дийлэнхи улсын шоронгийн хоригдлууд хэт чихэлдсэн, хүчирхийлэлтэй, наад захын шаардлага хангаагүй нөхцөлд хоригдож байна. Олон орны шоронд хоол хүнс, цэвэр ус дутмаг, ариун цэврийн шаардлага хангаагүй, эмнэлгийн үйлчилгээ хангалтгүй, хоригдлуудын хэргийг ахин хэлэлцэх шүүх хуралд очих тээврээр хангадаггүй, тэр ч байтугай хоригдлууд нэгэн лүүгээ дайрч, амь насыг нь хөнөөх тохиолдол ч түгээмэл байгаа нь тогтоогдсон. Бүс нутгийн одоогийн удирдагчдаас хэд хэдэн хүн өргөст торны цаана сууж байсан хэдий ч шоронгийн нөхцөл байдлыг сайжруулах талаар улс төрийн дорвитой алхам хийгдэхгүй байна.

АНУ даяар олон арван мянган хоригдол мужийн болон холбооны шоронд хоногт 22-24 цаг нийгэм болон хүрээлэн буй орчноос хатуу тусгаарласан нөхцөлд ганцаарчлан хоригдож байна.

Засгийн газрууд эдгээр ноцтой асуудлыг яаралтай шийдвэрлэх талаар дорвитой арга хэмжээ аваагүй. Хорих газруудыг олон улсын хүний эрх хэм хэмжээ, хоригдлын амьд явах эрх, хүний нандин чанарыг хамгаалах зарчимд нийцүүлэх талаар маш бага ахиц гарсан.

ЦАГААЧИД БОЛОН ТЭДНИЙ ҮР УДМЫН ЭРХ

Эх оронд нь амьдрахад аюултай, амьдрал нь гачигдалтай байгаагийн улмаас Мексикээр дамжин АНУ руу цагаачлах Төв Америкийн

цагаачид, ялангуяа ганцаараа яваа хүүхдүүдийн тоо өсөн нэмэгдэж байна. Мексикээр дамжин явж байгаа цагаачид олон тохиолдолд Мексикийн төрийн албан хаагчидтай хуйвалдан ажилладаг гэмт хэргийн бүлэглэлүүдэд алуулах, хулгайлагдах болон сүрдүүлэгт нь өртөх эрсдэлтэй тулгардаг бөгөөд Мексикийн эрх баригчдын хэрцгий, хүнлэг бус хандлагад өртдөг. Ялангуяа, охид эмэгтэйчүүд, хүүхдүүд бэлгийн хүчирхийлэл болон хүний наймаанд өртөх эрсдэл өндөр байдаг. Хүний эрхийн эдгээр зөрчлийн дийлэнхи хувийг огт мөрдөн шалгадаггүй бөгөөд буруутай этгээдүүд нь эрх чөлөөтэй явсаар байна. Албадан гаргах буюу албадан гаргах хүргтэл захиргааны журмаар саатуулах явдал түгээмэл хэрэглэгдсээр байна.

АНУ-д 2013 оны 10-р сараас 2014 оны 7-р сар хүртэл 52 193 ганцаараа яваа цагаач хүүхдүүдийг саатуулсан нь өмнөх 12 сартай харьцуулахад бараг 2 дахин өссөн үзүүлэлт юм. АНУ-ын засгийн газар 2014 оны 11-р сарын эцэс гэхэд Техас, Аризона, Калифорни гэх мэт хил орчмын муж улсуудад ганцаараа явж байгаад саатуулагдсан цагаач хүүхдийн тоо 90 000 давна гэж тооцоолсон. Эдгээр хүүхдийн олонхи нь эх орноосоо аюул занал, ядуурлаас зугтан дүрвэсэн юм. Түүнчлэн Эль Сальвадор, Гватемал, Гондурас, Никарагуа зэрэг улсад дээрмийн бүлэглэлтэй холбоотой хүчирхийлэл, зохион байгуулалттай гэмт хэргийн төвшин урьд байгаагүй ихээр өссөн нь мянга мянган цагаач хүүхдийг АНУ руу бие даан цагаачлахад хүргэж байна.

Цагаачид ба тэдний үр удмын эсрэг алагчлал хаа сайгүй оршсоор

байгаа бөгөөд улс орнуудад өргөн тархсан тэрхүү үзлийн шалтгаантай тэмцэх улс төрийн хүсэл зориг тун ч өчүүхэн байна.

2013 оны 9-р сард Доминиканы БНУ-ын Үндсэн хуулийн шүүх өргөн хүрээтэй шүүмжлэлд өртсөн нэгэн шийдвэр гаргасан нь 1929-2010 оны хооронд төрсөн, гадаад гаралтай доминиканчуудын Доминикан улсын иргэний харьяаллыг дур зоргоор үгүйсгэх нөлөөтэй бөгөөд түүнд өртсөн хүмүүсийн дийлэнхи олонхи нь Хаити гаралтай хүмүүс байв. Энэ нь үндэсний болон олон улсын төвшинд, түүний дотор Хаитийн эрх баригчдын зүгээс ихээхэн жагсаал цуглаантай тулгарсан.

2014 оны 10-р сард Гондурас улсын Африк гаралтай Гарифуна овгийн гишүүн Ангел Колон 5 жил Мексикийн шоронд өршөөгдөх боломжгүйгээр ял эдлэсний эцэст суллагдсан. Түүнийг 2009 онд Гондурас ба АНУ-ын хооронд аялж явахад нь Тихуана хотод цагдаа баривчилсан юм. Цагдаа түүнийг зодож нүдэн, хүчээр өвдгөн дээр нь явуулж, гэдэс рүү нь цохиж өшиглөн, амьсгалыг нь боохын тулд пластик уут толгойд нь угласан. Түүнийг нүцгэлж, бусад хоригдлын гутлыг хэлээрээ долоож цэвэрлэхийг албадаж, бусад доормжилсон зүйл хийхийг тулгажээ. Эмнести Интернэшнл түүнийг угсаа гарлынхаа үндсэн дээр болон хууль бус цагаач гэдгээрээ ялгаварлан гадуурхагдаж хоригдсон, эрүү шүүлтэд өртөж ял сонссон үзэл санааны хоригдол хэмээн үзэж байна.

УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХ

20 гаруй жил уламжлалт газар нутгийнхаа төлөө тэмцсэний

эцэст 6-р сард хөрөнгө хураах тухай хууль батлагдаж, Парагвай улсын Савхояма уугуул иргэд газар нутгаа эргүүлэн авчээ. Гэвч бүс нутгийн уугуул иргэдийн амь амьжиргаа, оршин тогтнолд нийгэм, улс төр, эдийн засгийн аюул занал учирсаар байна. Тэдний соёлын өв уламжлал, өвөг дээдсийн нутаг, өөртөө засан тогтнох эрх байнгын дайралталд өртсөөр байгаа билээ. Төрийн ба төрийн бус тоглогчдын аль аль нь, тухайлбал бизнесийн байгууллагууд болон хүчирхэг газар өмчлөгчид нийгэм-эдийн засгийн хөгжүүлэх нэрээр хүчээр тэдний газрыг хүчээр булаан авсаар байна. Олон тохиолдолд хөгжлийн хөтөлбөрүүдийн умлаас хүрээлэн буй орчин болоод соёл устгагдаж, уугуул иргэд нутгаасаа дайжиж байна. Сайн дураараа нийгмээс тусгаарлагдан амьдардаг, ялангуяа Амазоны сав газарт амьдардаг хүмүүсийн илүү их эрсдэлд өртдөг.

Бүс нутгийн бүх улс орон 2007 онд батлагдсан Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ын тунхаглалыг сайшаан дэмжсэнийг эс харгалзан амь амжиргаанд нь нөлөөлөх хөгжил төсөл, түүний дотор олборлох үйлдвэрлэлийн төслийн талаар уугуул иргэдтэй зөвлөлдөх, тэдний чөлөөтэй, урьдчилан мэдээлэл авч зөвшилцөх эрхийн хэрэгжилт туйлын сул байна.

Уугуул иргэдийн эрхийг хамгаалж чадахгүй байгаа нь тэдний аж амьдралд сөрөг нөлөө үзүүлж байгаа бөгөөд амьдардаг газрынх нь нөөц баялгийг ашиглах ажил эрчимжихийн хэрээр тэд улам их заналхийлэл, сүрдүүлэгт өртөж, орон гэрээсээ хөөгдөж, албадан нүүж, элдэв дайралтад өртөж, тэр байтугай амь насаа алдсаар

байна. Тэдний чөлөөтэй, урьдчилан мэдээлэл авч зөвшилцөхийг шаардах, эсэргүүцэх эрхээ хэрэгжүүлэхэд айлган сүрдүүлэлт, дайралт, хүч хэтрүүлэн хэрэглэх, дур зоргоор баривчлан хорих, хууль шүүхийг алагчлан хэрэглэх явдал саад тотгор учруулсаар байна. Тухайлбал, 7-р сард Америк дундын Хүний эрхийн шүүх Чили улсад 8 Мапуче хүнд оноосон ял нь алагчилсан хэвшмэл ойлголт болон шударга бус хандлага дээр үндэслэсэн болохыг тогтоосон.

Уугуул эмэгтэйчүүд хүчирхийлэл ба алагчлалын хохирогч болох явдал харьцуулшгүй ихээр тохиолдсоор байна. 5-р сард Канадын Хатан Хааны Морьт цагдаагийн алба 1980-2012 оны хооронд 1017 уугуул охид эмэгтэйчүүд бусдын гарт хөнөөгдсөн гэж мэдэгдсэн бөгөөд энэ нь хүн амын бусад бүлгийн эмэгтэйчүүдтэй харьцуулахад 4 дахин өндөр үзүүлэлт юм. 2014 оны 1-р сард Перу улсын Лима хотын Прокурорын газар 1990-ээд оны үед бүрэн дүүрэн мэдээлэл авч, зөвшөөрөл өгөлгүйгээр үргүй болгох мэс засал хийлгэсэн

2000 уугуул болон кампесино эмэгтэйчүүдийн хэргийг хаасан. Тэдгээр 2000 хэрэг нь 1990-ээд оны үед үргүй болгох мэс засал хийлгэсэн 200 000 гаруй эмэгтэйчүүдийн өчүүхэн хэсэг юм. Эдгээр хүчээр үргүй болгох зорилготой хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хариуцаж байсан засгийн газрын нэг ч албан тушаалтны хэргийг шүүхээр авч хэлэлцээгүй.

ЭРСДЭЛД БУЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧИД

Хүний эрхийг хамгаалагчид Бразил, Колумби, Куба, Доминиканы

БНУ, Эквадор, Гватемал, Хаити, Гондурас, Мексик, Перу, Венесуэл зэрэг олон оронд хүний эрхийн хууль ёсны үйл ажиллагаа явуулсныхаа төлөө дайралт, хүчирхийлэлд өртсөөр байна. Тодруулбал, тэдний амь нас, бие махбодод халдаж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон эвлэлдэн нэгдэх эрхийг нь боомилдог. Хэвлэлээр болон засгийн газар албан тушаалтнууд нэр хүндийг нь гутаадгаас гадна тэд хүний эрхийг хамгаалагчдыг хэрэгт холбогдуулах зорилгоор хуулийн тогтолцоог урвуулан ашигладаг.

Санаа зовоосон өөр нэг зүйл бол Колумби, Гватемал зэрэг зарим улсын орон нутгийн хүний эрхийн байгууллагуудын тайлагнасаар хүний эрхийг хамгаалагчдын эсрэг халдлагын тоо нэмэгдсэн байна. Эдгээр халдлагад буруутай этгээдүүдийн хэргийг бараг хэзээ ч шүүхээр авч хэлэлцдэггүй.

Ялангуяа, ял завших явдлын эсрэг, эмэгтэйчүүдийн эрхийн төлөө болон газар, байгалийн баялагтай холбоотой эрхийн асуудлаар ажилладаг хүний эрхийн хамгаалагчид онцгой эрсдэлд оршсоор байна.

Бразил, Колумби, Мексик гэх мэт эрсдэлд байгаа хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах механизм бий болгосон орнуудад ч олон тохиолдолд хамгаалалтын арга хэмжээ нь баталгаатай бус эсхүл үр дүнтэй бөгөөд цаг алдахгүй баталгаа болж чаддаггүй. Энэ нь ялангуяа улс төрийн хүсэл зориг хангалтгүй байгаа төдийгүй үр дүнтэй хэрэгжилтийг хангах нөөц бололцоо дутмаг байгаатай холбоотой. Түүнчлэн, хамгаалалтын арга хэмжээний тухайд хүйсийн онцлогийг харгалзсан, ялгавартай

хандлагыг практикт нэвтрүүлээгүй.

Бүс нутаг даяар хүний эрхийг хамгаалагчид эр зоригтой, нэр төрөө өндөрт өргөсөн, шаргуу чанараараа хүн бүрт хүний эрхийг тэгш эдлүүлэхийн төлөө тэмцлээ маш аюултай, дайсагнасан орчинд үргэлжлүүлсээр байна.

ОХИД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

Бүс нутгийн улс орнууд охид эмэгтэйчүүдийг хүчин, аюул занал, аллагаас хамгаалах үйлсийг улс төрийн мөрийн хөтөлбөрийнхөө нэн тэргүүнд анхаарах асуудлын тоонд багтаахгүй байна. Хүйст суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн хэрэгжилт удаан, алаг цоог байгаа нь ихээхэн сэтгэл зовоож байгаа бөгөөд ийм төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах ажиллагаанд эх үүсвэр дутагдаж байгаа нь эдгээр асуудлыг шийдэх албан ёсны хүсэл эрмэлзэл байгаа эсэхэд эргэлзэхэд хүргэж байгаа юм. Эдгээр гэмт хэрэгт буруутай этгээдүүдийг шүүхээр шийтгэж чадахгүй байгаа нь хүйст суурилсан хүчирхийлэл үйлдэгчид ял завших, охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг улам өөгшүүлж байна.

2013 оны 8-р сард бүс нутгийн улс орнууд Уругвай улсын Монтевидео хотноо түүхэн тохиролцоонд хүрсэн бөгөөд үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцох нь эхийн эндэгдэл болоод нас баралтыг нэмэгдүүлдэг, харин үр хөндөлтийн тоог бууруулдаггүй болохыг хүлээн зөвшөөрсөн нь энэ чиглэлд нэлээд урагшилсан явдал болсон. 12-р сард Доминиканы БНУ үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцохоо больсон.

Гэвч 2014 оны эцсийн

байдлаар охид эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрх зөрчигдөж, амь нас, эрүүл мэндэд нь нөхөж баршгүй гарз хохирол учирсаар байв. Чили, Эль Сальвадор, Хаити, Гондурас, Никарагуа, Суринам зэрэг улсад ямар ч нөхцөлд, түүний дотор охид эмэгтэйчүүд хүчиндүүлсний улмаас жирэмсэн болсон, жирэмслэлт нь амь насанд нь халтай хүндрэл учруулж байгаа тохиолдолд ч хориглодог практик хэвээр үргэлжилж байна. Үр хөндөлт хийлгэхийг оролдсон буюу үр хөндөлт хийсэн хүмүүс урт хугацаагаар хоригдох ял авах эрсдэлтэй байна.

2014 оны 3-р сард Ерөнхийлөгч Мишель Бачелет албан тушаалдаа орохдоо түүний тэргүүлэх зорилтын нэг бол Чили улсад үр хөндөлтийн ямар ч нөхцөлд хориглодог явдлыг өөрчлөх алхам хийнэ гэж амалсан. Эль Сальвадорд ч ирээдүй бүрхэг байна. Энэ улсад өнгөрсөн арван жилд 129 эмэгтэй жирэмслэлттэй холбоотой шалтгаанаар хорих ял сонсчээ. Оны эцсийн байдлаар эдгээр эмэгтэйчүүдийн 17 нь өршөөл хүссэн өргөдлийнхөө хариуг хүлээж байв. Тэдэнд эхлээд үр хөндөлт хийлгэсэн хэргээр ял оноосон бөгөөд зарим нь хүн амины хүндрүүлсэн хэргээр 40 хүртэл жилийн хорих ял эдлэж байна. Үр хөндөлтийг хуулиар тодорхой нөхцөлд хүлээн зөвшөөрдөг дийлэнхи улсад үр хөндөлт хийлгэх зөвшөөрөд авах процесс хэт их цаг авдаг нь үр хөндөлт хийлгэх боломжийг бараг хаадаг. Ялангуяа, хувийн эмнэлэгт үр хөндүүлэх төлбөрийг төлж чадахгүй хүмүүсийн хувьд энэ илүү хэцүү байдаг.

Бүс нутгийн хэмжээнд

гадуурхагдсан охид эмэгтэйчүүдэд, тэдний дундаас нийгмээс хамгийн их шоовдорлогдон хэсэгт жирэмслэхээс хамгаалах эм бэлдмэл, бэлгийн болон нөхөн үржихүйн талаар мэдээлэл олж авахад саад бэрхшээл тулгарсаар байна.

Зарим улсад хүчиндүүлсэн тохиолдолд үр хөндөлтийг зөвшөөрөх хандлага үе шаттайгаар хэрэгжиж байна. Боливи улсын Үндсэн хуулийн шүүх 2-р сард хүчиндүүлсэн тохиолдолд үр хөндөлт хийлгэхийн тулд шүүхээс зөвшөөрөл хүсэх нь үндсэн хуулинд харш гэсэн шийдвэр гаргасан. Мөн Перу улсын Конгресс оны эцсийн байдлаар хүчиндүүлсэн тохиолдолд үр хөндөлтийг зөвшөөрөх тухай хуулийн төслийг хэлэлцэж байв. Гэвч Эквадор улсад үүнтэй төстэй санаачлагад 2013 онд ерөнхийлөгч Рафаэл Корреа хориг тавьсан.

Бүс нутгийн дийлэнхи улс орон хувийн болон олон нийтийн талбарт охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль баталсан. Гэвч охид эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах үр дүнтэй бөгөөд нөөц бололцоогоор бүрэн дүүрэн хангагдсан механизм ялангуяа хаягдсан, ядуу орон нутагт хараахан бий болж чадаагүй байна.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тоо хэмжээ бүс нутгийн хэмжээнд өссөн үзүүлэлттэй байна. Америк дундын Хүний эрхийн шүүх, мөн Америк дундын Хүний эрхийн Комисс охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн төвшин болон хүчирхийлэл үйлдэгчид ял завших явдалд сэтгэл зовниж буйгаа илэрхийлээд, эмэгтэйчүүдийг дорд үзэх нийгмийн итгэл үнэмшил хууль сахиулах болон шүүхийн

байгууллагын хүрээнд тэднийг алагчлан үзэх явдлыг бий болгодог ба үүний улмаас мөрдөн шалгах ажиллагаанд тоомсоргүй хандаж, буруутай этгээдүүдэд бүрэн дүүрэн хариуцлага хүлээлгэж чаддаггүй гэж дүгнэсэн.

ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨН

Колумби улс дахь зэвсэгт мөргөлдөөнөөс үүдэн гарч буй хүний эрхийн зөрчлийг зогсоож чадахгүй байгаагаас гадна тэдгээр гэмт хэрэгт сэжиглэгдсэн хүмүүсийн дийлэнхи хувийг шударга шүүхээр шүүж чадахгүй байгаа нь цаашид байгуулах ямар ч энх тайвны хэлэлцээр тогтвортой хэрэгжих итгэлийг алдагдуулж байна.

Колумбийн засгийн газар Колумбийн Хувьсгалт Зэвсэгт хүчний (Fuerzas Armadas Revolucionarias de Колумби, FARC) хооронд Куба улсад явагдсан энх тайвны яриа хэлэлцээ нэлээд ахиц авчирсан. Уг яриа хэлэлцээ нь сүүлийн арван жилд анх удаа энэ бүс нутагт хамгийн удаан үргэлжилж буй дотоодын зэвсэгт мөргөлдөөнийг эцэслэх боломж олгосон юм. Гэвч бүх талууд ялангуяа, уугуул болон африк гаралтай хүмүүс, кампесино айл хотлууд, хүний эрхийг хамгаалагчид, үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн хүний эрхийг зөрчсөөр байгаа бөгөөд олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн гэрээ конвенциудыг уландаа гишгэсээр байна.

Тус улсын засгийн газар цэргийн шүүхээр шийдэх хэргийн хамрах хүрээг өргөтгөх хуулийн төслийг батлуулахаар ажиллаж байгаа бөгөөд ингэснээр хүний эрхийн зөрчилд холбогдсон аюулаас хамгаалах хүчнийхний хэргийг

цэргийн шүүхэд шилжүүлэхэд хялбар болох юм. Мөн иргэний шүүхүүдийн зүгээс хохирогчдод шударга үнэнийг тогтоож өгөх чиглэлээр хүрсэн өчүүхэн амжилтаа үгүй хийх аюултай юм.

ТЕРРОРИЗМЫН ЭСРЭГ ТЭМЦЭЛ БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ

АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама тус улсын эсрэг хийсэн 2001 оны 9-р сарын 11-ний террорист халдлагын эсрэг арга хэмжээ авахдаа эрүү шүүлт хэрэглэж байсан гэдгийг хүлээн зөвшөөрсөн хэдий ч энэ талаар хариуцлага хүлээлгэх буюу нөхөн төлбөр олгох талаар юу ч дурдаагүй. 2014 оны эцсийн байдлаар Куба улсын Гуантанамо арал дээрхи АНУ-ын хорих газарт 127 хүн хоригдож байв. Тэдний дийлэнхи олонхи нь шүүхийн шийдвэргүйгээр тэнд хоригдож байгаа бөгөөд 6 хүний хэргийг цэргийн комиссоор авч хэлэлцэж байгаа юм. Тэдэнд АНУ-ын засгийн газар олон улсын шударга шүүхийн хэм хэмжээнд нийцэхгүй тогтолцооны хүрээнд цаазаар авах ял оноохыг эрмэлзэж байна.

2012 оны сүүлчээр АНУ-ын Сенатын Тагнуулын асуудлаархи Тусгай хороо (СТТХ) 9-р сарын 11-ний халдлагын дараа Тагнуулын Төв Газрын (ТТГ) хэрэгжүүлж байсан нууц хорих газар болон байцаалт явуулах хөтөлбөрийн талаар 2009 онд эхэлсэн шалгалтын ажлаа дуусгажээ. 2014 оны 4-р сарын 3-нд уг шалгалтын дүнгийн хураангуй болон санал дүгнэлтийг нууцын зэрэглэлээс хасч, нийтэд мэдээлэхийг СТТХ-ийн 11 гишүүн дэмжиж, 3 гишүүн таталзсан. Шалгалтын хураангуйг

12-р сарын 9-нд нийтэд дэлгэсэн бөгөөд ерөнхийлөгчийн эрх мэдлийн дор хэрэгжиж байсан уг хөтөлбөрийн хүрээнд хүний эрхийг маш ноцтойгоор зөрчиж байсныг илчилсэн билээ. Тайлангийн бүрэн эх нууцын зэрэглэлд хэвээр байгаа ба СТТХ-ийн дарга, сенатч Дайэн Файнштайны мэдэгдсэнээр “дараа нууцын зэрэглэлээс гарах юм”. Хэдийгээр ТТГ-ын уг хөтөлбөрийн талаар олон жилийн турш олон нийтэд нэлээд мэдээлэл илэрхий болоод байсан ч уг хөтөлбөрийн хүрээнд үйлдэгдсэн хүний эрхийн зөрчил, түүний дотор эрүү шүүлт ба хүчээр сураггүй болгох зэрэг олон улсын эрх зүйн гэмт хэргийн төлөө нэг ч хүн шүүхээр шийтгэгдээгүй.

ЦААЗААР АВАХ ЯЛ

АНУ тус бүс нутагт цаазаар авах ял гүйцэтгэсэн цорын ганц орон байлаа. Гэсэн хэдий боловч тус улсад ч гэсэн цаазаар авах ялаас татгалзах үйл хэрэг амжилт олсоор байгаа бөгөөд 2-р сард Вашингтон муж улсын амбан захирагч албан тушаалаа хаших хугацаандаа цаазаар авах ялын гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй гэдгээ мэдэгдсэн. Энэ нь цаазаар авах ялыг 2013 онд халсан Мэриланд муж улсын дараа цаазаар авах ялыг халсан муж улсын тоог 18-д хүргэсэн юм. Колорадо муж улсын одоогийн амбан захирагчийн бүрэн эрхийн хугацаанд цаазаар авах ялыг гүйцэтгэхгүй гэдэг нь тодорхой байна.

Карибын арлуудын тухайд Их Карибын хэд хэдэн улсад 1980 оноос хойш анх удаа цаазаар авахуулахаар хүлээгдэж буй хоригдолгүй боллоо.

АЗИ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Ази-Номхон далайн бүс нутаг дэлхийн бөмбөрцгийн хагасыг эзлэн оршдог бөгөөд дэлхийн хүн амын тал хувь энд амьдардгийн олонхи нь залуучууд билээ. Олон жилийн турш тус бүс нутгийн улс төр, эдийн засгийн хүчин чадал өссөөр ирсэн нь дэлхийн хүч чадал, эд баялгийн зүг чигийг хурдацтайгаар өөрчилж байгаа юм. Тус бүс нутагт БНХАУ болон АНУ хүч нөлөөгөө өсгөхийн төлөө өрсөлдөж байна. Энэтхэг, Хятад зэрэг бүс нутгийн томоохон гүрнүүд болон Зүүн Өмнөд Азийн Үндэстнүүдийн Нийгэмлэг (АСЕАН)-ийн харилцаа ихээхэн ач холбогдолтой юм. Тиймээс ч бүс нутгийн хүний эрхийн чиг хандлагыг энэ дэвсгэр дээр ойлгох ёстой.

2014 онд зарим нэг зэрэг өөрчлөлт, түүний дотор хүний эрхийн хэрэгжилтийг сайжруулах амлалт өгсөн зарим засгийн газар сонгуульд ялсан боловч ял завших явдал, эмэгтэйчүүдтэй тэгш бус харьцах болон тэдний эсрэг хүчирхийлэл, эрүү шүүлт болон цаазаар авах ял хэрэглэсээр байгаа, үзэл бодлоо илэрхийлэх болон эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг нухчин дарж, иргэний нийгэмд шахалт үзүүлж, хүний эрхийг хамгаалагчид ба хэвлэл мэдээллийн ажилтнуудыг айлган сүрдүүлж байгаа зэргээс үүдэн ерөнхийдөө арагш ухарсан хандлагатай байна. Шашны болон угсаатных нь хувьд эгдүүцэх, алагчлах явдал өсч байгаа сэтгэл эмзэглүүлсэн хандлага ажиглагдаж байгаа бөгөөд эрх баригчид нэг

бол тийм байдалтай хуйвалдаж, эсвэл түүнтэй шийдвэртэй тэмцэж чадахгүй байна. Бүс нутгийн зарим газарт, ялангуяа Афганистан, Пакистан улс дахь отог овгийн мэдлийн газар нутаг (FATA), Мьянмар, Тайланд улсад зэвсэгт мөргөлдөөн үргэлжилсээр байна.

НҮБ-аас БНАСАУ (Хойд Солонгос) дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаар цогц тайлан гаргасан бөгөөд тус улсад хүний бүхий л эрхийг системтэйгээр зөрчиж байгаа талаар нарийвчлан дурдсан. Олон зуун мянган хүн шоронгийн хуаран болон бусад хорих газарт хоригдож байгаа бөгөөд тэдний олонхи нь олон улсын хэмжээнд гэмт хэрэгт тооцогддог ямар нэг хэрэгт буруутгагдаагүй эсхүл тийм хэргийн төлөө шүүхээр шийтгэгдээгүй байна. Оны эцсийн байдлаар эдгээр асуудлыг НҮБ-ын Ерөнхий Ассамблей ба Аюулгүйн Зөвлөлөөр авч хэлэлцсэн.

Дүрвэгчид ба орогнол эрэгчид бэрхшээлтэй тулгарсаар байна. Малайз, Австрали гэх мэт хэд хэдэн улс дүрвэгчид ба орогнол эрэгчдийн хүний эрх нь ноцтойгоор зөрчигдөж болзошгүй улсад хүчээр буцаахыг хориглосон олон улсын хэм хэмжээг зөрчиж байна.

Цаазаар авах ялыг бүс нутгийн хэд хэдэн улсад хэрэглэсэн хэвээр байна. 12-р сард Пакистан улсын Пешавар хотод талибанчууд Армийн дунд сургууль халдсаны улмаас 149 хүн, түүний дотор 132 хүүхэд амь насаа алдсан нь Пакистаны түүхэнд хамгийн их цус урсгасан террорист халдлага болсон билээ. Халдлагын хариуд засгийн газар цаазаар авах ялын гүйцэтгэлийг түдгэлзүүлсэн шийдвэрээ цуцалж, өмнө нь

терроризмтэй холбоотой хэргээр ял сонсоод байсан 7 хүнийг цаазаар аваачсан. Тус улсын ерөнхий сайд цэргийн шүүхэд терроризмын хэрэгт сэжиглэгчдийг шилжүүлэн өгөхийг төлөвлөж байгаагаа мэдэгдсэн нь шударга бус шүүхийн асуудал дээр ахин сэтгэл түгшээх асуудал нэмээд байна.

Ижил хүйстэн байхыг тус бүс нутгийн хэд хэдэн улсад гэмт хэрэгт тооцсоор байна. Энэтхэгийн Дээд Шүүх трансжендэр хүмүүсийг хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрч, Малайзын Давж заалдах шүүх эсрэг хүйстэн мэтээр хувцаслахыг хориглосон хууль гаргасан нь Үндсэн хуулинд харшилж байна гэсэн шийдвэр гаргасан. Гэвч трансжендэр хүмүүсийн эсрэг заналхийлэл, хүчирхийлэл бүртгэгдсээр байна. Харилцаа холбооны хямд технологийн ачаар өөр хоорондоо холбогдсон залуусын идэвхитэй үйл ажиллагаа өссөн нь эерэг зүйл юм. Гэвч эрхээ шаардаж байгаа эдгээр бүлгүүдийн эсрэг олон орны эрх баригчид үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож, иргэний нийгмийг сулруулахыг чармайж байна.

ИДЭВХИТНҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨСӨЛТ

Харилцаа холбооны хямд технологийн ачаар өөр хоорондоо холбогдсон залуу үеийнхэн нийгмийн сүлжээг ашиглан эрхээ шаардах болсон бөгөөд 2014 онын байдлаар тус бүс нутаг дахь идэвхитнүүдийн үйл ажиллагаа өссөн бөгөөд тэдгээрийн тэргүүн эгнээнд ихэвчлэн эмэгтэйчүүд явж байна.

Сонгууль хүмүүст цөхрөл гомдлоо илэрхийлж, өөрчлөлтийг

шаардах орон зайг гаргаж өгдөг. Индонезид 7-р сард болсон сонгуулиар хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах кампанит ажлын амлалт өгснийхөө ачаар Жоко Видодо засгийн эрхэнд гарч чадсан. 9-р сард Фижи улсад 2006 оны цэргийн эргэлтээс хойш анх удаа болж өнгөрсөн тайван сонгуулийн үеэр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж байсныг эс хайхран нийгэм болон хэвлэл мэдээлэл, эрчимтэй хэлэлцүүлэг өрнүүлсэн. Камбож улсад болсон сонгууль, өргөн олныг хамарсан жагсаал цуглаанаас хойш жилийн дараа буюу 2014 оны эцсийн байдлаар нийслэл Пномпен хотод тайван жагсаал цуглаан бараг өдөр болгон шахам зохиогдох болсон.

Идэвхитнүүд ба хүний эрхийг хамгаалагчид засгийн газарт хариуцлага тооцох асуудлаар улам бүр нягт хамтран ажиллах боллоо. Мьянмар улсад 2-р сард Мичаунган нутгийн хүмүүс эрх баригчид газрын маргааныг шийдвэрлээгүйн улмаас Янгон хотын захиргааны байрны ойролцоо суулт, эсэргүүцлээ үргэлжлүүлсэн.

Улам олон хүний эрхийн идэвхитнүүд олон улсын хамтын нийгэмлэгээс дэмжлэг хүсэх болсон. Вьетнамын эрх баригчид сүүлийн 20 жилд анх удаа Эмнести Интернэшнлд тус улсад газар дээр нь судалгаа хийхийг зөвшөөрсөн. Хэдийгээр нэлээд олон шинэ бүлгүүд байгуулагдаж, идэвхитнүүд үзэл бодлоо илэрхийлэх эрхээ илүү сайн хэрэгжүүлдэг болсон ч тэдэнд хатуу хяналт, ял шийтгэл тулгарсаар байна. 4-р сард өөрөөр сэтгэгч 6 хүнийг хугацаанаас нь өмнө сулласныг эс харгалзан 6-р

сарын байдлаар дор хаяж 60 үзэл санааны хоригдол шоронд ял эдлэж байв.

Хонконгт голцуу оюутнуудаар удирдуулсан мянга мянган жагсагчид 9-р сараас эхлэн гудамжинд гарч бүх нийтийн сонгуулийн эрхийн төлөө тэмцлээ. Хятад улсад Хонконгийн жагсагчдыг дэмжсэн хэргээр 100 гаруй идэвхитнүүдийг хорьсон бөгөөд оны эцсийн байдлаар 31 хүн хоригдсон хэвээр байв.

ӨӨРӨӨР СЭТГЭГЧДИЙГ НУХЧИН ДАРЖ БАЙГАА НЬ

Идэвхитнүүдийн үйл ажиллагаа өсч байгаагийн эсрэг олон орны эрх баригчид үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал цуглаан хийх эрхийг хязгаарласаар байна. Хятад улсад идэвхитнүүдийн нухчин дарах ажиллагаа эрчимжсэн жил байлаа. Шинэ Иргэдийн Хөдөлгөөн хэмээх идэвхитнүүдийг сүлжээтэй холбоотой хувь хүмүүст 2-6,5 жилийн хорих ял оноов. 3-р сард хүний эрхийн хамгаалагч Као Шунлид хорих газарт байхад нь шаардлагатай эмчилгээ хийгээгүйн улмаас эмнэлэгт ирээд нас барсан.

Хойд Солонгост хараат бус иргэний нийгмийн байгууллагууд, сонин, улс төрийн нам байхгүй байна. Хойд Солонгосын эрх баригчид иргэдээ нэгжих эрхтэй бөгөөд тэдэнд гадаадын хэвлэл мэдээллийн материалыг уншсан, сонссон эсхүл үзсэн хэргээр ял оноодог.

Цэргийн болон аюулаас хамгаалах хүчнийхэн өөрөөр сэтгэх явдлыг нухчин дарахын тулд хүч хэтрүүлэн хэрэглэсээр байна. 1-р сард Камбож улсад тайван жагсаал цуглааныг тараахын тулд аюулаас хамгаалах хүчнийхэн хүч болон

галт зэвсэг хэрэглэж, жагсаал хийж байсан оёдлын үйлдвэрийн ажилчдыг буудан хөнөөсөн юм. Орон байраар хангагдах эрхийн төлөө тэмцэгчдийг тайван жагсаал хийснийх нь төлөө шоронд хорилоо. 5-р сард Тайландад төрийн эргэлт гарч, онц байдал зарласны улмаас олон хүнийг дур зоргоор баривчлан хорьж, таваас олон хүнтэй улс төрийн цуглааныг хорьж, энгийн иргэдийг цэргийн шүүхээр давж заалдах эрхгүйгээр хорих болов. Мөн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарласан хууль тогтоомжийг мөрдсөөр байна.

Малайзын эрх баригчид колонийн үеийн үймээн самуунд өдөөн хатгагчдын тухай хууль тогтоомжийг хүний эрхийг хамгаалагчид, сөрөг хүчний улс төрчид, эрдэмтэд болон оюутнуудыг мөрдөн шалгах, ял оноох, шоронд хориход ашиглаж эхэллээ. Уг хуулийн дагуу хэвлэл мэдээллийн байгууллагууд болон хэвлэлийн газрууд бүтээлээ хэвлүүлэхийн тулд тусгай зөвшөөрөл авах хэрэгтэй болсон бөгөөд Дотоод хэргийн сайд уг зөвшөөрлийг нь хэдийд ч цуцалж болно. Хараат бус хэвлэл мэдээллийн байгууллагуудын хувьд тусгай зөвшөөрөл олж авах нь туйлын хүндрэлтэй байна.

Индонези улсад тайван улс төрийн идэвхитнүүдийг, ялангуяа тусгаар тогтнолын төлөө тэмцэж байсан түүхтэй Папуа, Малуку зэрэг газрын идэвхитнүүдийг баривчилж хорих тохиолдолд бүртгэгдсээр байна. Мьянмар улс үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал цуглаан хийх эрхэд хатуу хязгаарлалт тогтоосон хэвээр байгаа төдийгүй маш олон хүний эрх хамгаалагчид,

сэтгүүлчид, улс төрийн идэвхитнүүд болон тариачдыг тайван замаар эрхээ хэрэгжүүлснийх нь төлөө баривчилж, шоронд хорьсоор байна.

Зарим засгийн газар хүний эрхийг хамгаалагчдад ихээхэн дарамт шахалт үзүүлсээр байна. Шриланка улсын Батлан хамгаалах яамнаас гаргасан меморандумд бүх ТББ-уудад хэвлэл мэдээллийн арга хэмжээ зохион байгуулах, хэвлэлийн мэдээ тараах явдлыг зогсоохыг анхааруулсан. Энэ нь айдас хүйдэс, хэлмэгдүүлэлтийн уур амьсгалыг улам гүнзгийрүүлж, сэтгүүлчид болон хүний эрхийг хамгаалагчдын биед халдах, амь насанд нь заналхийлэх, улс төрийн зорилгоор хэрэг тулгах зэрэг үйлдлийг өөгшүүлсээр байна.

Түүнчлэн үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд ч илүү их хязгаарлалтад өртөх болжээ. БНСУ (Өмнөд Солонгос)-ын нэгэн үйлдвэрчний эвлэлийн удирдагч Ким Жүн-вуг орон нутгийн захиргааны ажилтнууд суулт хийж байсан майхнуудыг нь нураах гэхэд эсэргүүцсэний төлөө хорих ялаар шийтгэсэн. Прокурор давж заалдсан тул түүнд дээд шатны шүүхээс илүү хүнд ял оноох эрсдэл тулгараад байгаа юм. Түүнчлэн эрх баригчдын зүгээс зарим томоохон үйлдвэрчний байгууллагуудыг бүртгэлээс хасах оролдлого хийж байгаа бөгөөд тэдгээр байгууллагуудын эсрэг шүүхэд өргөдөл гаргаад байна.

Сэтгүүлчдийн эсрэг улс төрийн зорилготой халдлага сэтгэл эмзэглүүлсэн хандлага хэвээр байна. Пакистан улсад дор хаяж 8 сэтгүүлч хийж буй ажилтайгаа шууд холбоотойгоор амь насаа алдсан бөгөөд тус улс хэвлэл

мэдээллийн ажилтнуудад хамгийн аюултай орны нэг болоод байна. Афганистан улсад сэтгүүлчдийн, ялангуяа сонгуулийн талаар бичдэг сэтгүүлчдийн амь насыг бүрэлгэх явдал өсч байна. Мальдив улсад хэд хэдэн сэтгүүлч дайралтад өртсөн бөгөөд буруутай этгээдүүдэд нь хариуцлага хүлээлгэж чадаагүй.

Түүнээс гадна хэвлэл мэдээллийн орон зайг хумих үзэгдэл газар авч байна. Шриланка улсад хэвлэл мэдээллийн байгууллагыг сүрдүүлэх явдал гарсаар байгаа бөгөөд Утхаян гэдэг сонин газрыг түр хугацаагаар хаасан. Бангладеш улсад блогчид болон хүний эрхийг хамгаалагчдыг баривчилж, шүүхэд өгч, шоронд хорьсоор байна. Пакистан улс хэд хэдэн телевизийн сувгийн эрхийг түдгэлзүүлсэн. Хятадын засгийн газар ардчиллын төлөө жагсаал цуглааны зургийг тавих, эерэгээр дурдах явдлыг хориглохыг эрмэлзэж байгаа бөгөөд телевиз, сонин хэвлэлээр зөвхөн засгийн газрын зөвшөөрсөн мэдээллийг гаргахыг зөвшөөрч байна.

ЭРҮҮ ШҮҮЛТ БА БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ ХАНДАХ

Хэд хэдэн улсын засгийн газар иргэддээ эрүү шүүлт тулгах буюу бусад хэлбэрээр хэрцгий харьцсан тохиолдол бүртгэгдээд байна.

Филиппин улсад цагдаа бусдад эрүү шүүлт тулгасан хэргийг барагтай бол мөрдөн шалгаж, ял шийтгэл оногдуулдаггүй. Эрүүдэн шүүхийн эсрэг олон улсын хоёр гэрээг соёрхон баталсныг эс харгалзан цагдаагийн ажилтнууд сэжигтнийг зэрлэгээр зодож нүдэх, тогонд цохиулах, ус цутгах зэрэг аргыг ихэвчлэн сүрдүүлэх буюу

гэм бурууг нь хүлээлгэх зорилгоор хэрэглэсээр байна. 12-р сард Эмнести Интернэшнлээс гаргасан “Хуулиас дээгүүр: Филиппиний цагдаагийн эрүү шүүлт” хэмээх тайланд ял завших явдал асар өргөн дэлгэрсэн нь цагдаагийн эрүү шүүлттэй холбоотой хэргийг мөрдөн шалгалгүй өнгөрөхөд хүрдэг болохыг дурдсан.

Хятад улс хууль сахиулах өргөн хүрээтэй техник хэрэгслийн, түүний дотор цахилгаан бороохой, хүндрүүлэгчтэй хөлийн гав болон нулимс асгаруулагч хий зэрэг хууль ёсоор хууль сахиулах ажиллаганд хэрэглэдэг хэдий ч хялбархан буруугаар ашиглагдах боломжтой техник хэрэгслийн томоохон үйлдвэрлэгч, экспортлогчийн байр сууриа улам бэхжүүлж байна.

Эрүү шүүлт тулгах болон бусад хэрцгий хандах явдал Хятад улсад өргөн тархсан. 3-р сард Хэйлонжиан мужийн Жиансанжиан хотын Хууль зүйн боловсролын төвд эрүү шүүлтийн тухай тайланг шалгаж байсан 4 хуульчийг хууль бусаар баривчлан хорьж, эрүүдэн шүүсэн тохиолдол гарсан юм. Нэг хуульчийнх нь хэлснээр цагдаа нар түүний толгойд юүдэн углаж, гарыг нь ард нь гавлаж, бугуйнаас нь дүүжлээд зоджээ.

Хойд Солонгост олон зуун мянган хүн улс төрийн хорих хуаран болон бусад хорих газарт хоригдож байгаа бөгөөд тэнд хуулиас гадуур цаазаар аваачих, эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий хандах зэргээр хүний эрхийг маш ноцтойгоор зөрчдөг.

Эрүү шүүлтийн талаар гаргасан гомдлыг үр дүнтэй шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх механизм сул байгаа нь олон тохиолдолд

хохилогчид ба тэдний гэр бүлд шударга үнэнийг тогтоолгох болон хохирлоо барагдуулах боломж олгохгүй байна. Афганистан улсад Үндэсний Аюулаас хамгаалах газрын ажилтнууд хүний эрх зөрчсөн тухай, түүний дотор эрүү шүүлт тулгасан болон хүчээр сураггүй болгосон тухай гомдол гарсаар байна. Шриланка улсад хоригдлуудад эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий хандах явдал өргөн дэлгэрсэн хэвээр байна.

Хэт сунжирсан хугацаагаар урьдчилан хорих болон шоронгуудын даац хэтрэх явдал Энэтхэг улсад ноцтой асуудал болоод байна. Хомроглон баривчлах, мөрдөн шалгах болон яллах ажиллагаа хэт удаашрах, хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо сул, үр дүнтэй хамгаалалт байхгүй зэрэг нь асуудлыг улам хүндрүүлж байна. Дээд шүүх тойргийн шүүгчдэд хэрэв ял сонссон байсан бол тухайн хугацааны тал хувийг урьдчилан хорих газарт өнгөрүүлсэн бүх хоригдлыг нэн даруй тодорхойлж, суллаж явуулах үүрэг өгсөн.

Япон улсын *daiyo kaТТБку* тогтолцоо буюу цагдаа сэжигтнийг хэрэгт татах хүртэл 23 хоног хүртэл хугацаагаар саатуулахыг зөвшөөрдөг практик байцаалтын үед гэм бурууг нь хүлээлгэхийн тулд эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий хандах явдлыг өөгшүүлсээр байна. Уг тогтолцоог устгах буюу шинэчилж, олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх талаар ямар ч алхам хийхгүй байна. Тайланд улсад цэргийн хорих болон цагдаа эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий хандах явдал гарсаар байна.

ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨН

Афганистанд 13 жил байрласан НАТО-гийн хүчин үүргээ гүйцэтгэж дууссан боловч олон улсын цэргийн хүчин тэнд үргэлжлүүлэн үүрэг гүйцэтгэхээр болсон. Зэвсэгт бүлэглэлүүдийн ажиллагаа цар хүрээгээ тэлсээр байгаа бөгөөд 2014 оны эхний хагас жилд түүхэнд байгаагүй хамгийн олон халдлага үйлдсэн. Пакистан улсад ч дотоодын зэвсэгт мөргөлдөөн үргэлжилсээр байгаа бөгөөд 6-р сард тус улсын арми Хойд Вазиристанд томоохон ажиллагаа эхлүүлсэн. АНУ ч мөн нисэгчгүй онгоцны дайралтаа дахин эхлүүлсэн юм. 12-р сард Пакистан улсын Пешавар хотод талибанчууд Армийн дунд сургуульд халдсаны улмаас 149 хүн, түүний дотор 132 хүүхэд бууны суманд болон амиа золиослогчийн бөмбөгөнд өртөн амь насаа алдаж, 10 гаруй хүүхэд шархадсан нь тус улсын түүхэнд хамгийн их цус урсгасан террорист халдлага байв.

Мьянмар улсын Качин болон Хойд Шан муж дахь зэвсэгт мөргөлдөөн 4 дэх жилдээ үргэлжилж байгаа бөгөөд сөргөлдөгч хоёр талын аль аль нь олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн хуулийг зөрчиж байгаагийн дотор хууль бус аллага үйлдэж, эрүү шүүлт тулгах буюу бусад хэлбэрээр хэрцгий хандах, түүний дотор хүчин болон бусад хэлбэрийн бэлгийн хүчирхийлэл үйлдсээр байна. Тайланд улсын өмнөд мужууд болох Паттани, Яала, Наративат болон Сонгла мужийн зарим хэсэгт зэвсэгт хүчирхийлэл үргэлжилсээр байна. Аюулаас хамгаалах хүчнийхэн хууль бус аллага үйлдэж, эрүү шүүлт тулгах буюу бусад хэлбэрээр хэрцгий хандаж байсан бөгөөд

жилийн турш энгийн номхон иргэдийг онилж, олон нийтийн газарт бөмбөг дэлбэлсээр байна.

ЯЛ ЗАВШИХ

Өнгөрсөн үед болон саяхан үйлдэгдсэн хүний эрхийн зөрчил, түүний дотор зэвсэгт мөргөлдөөний үеэр үйлдэгдсэн зөрчилд хэн ч хариуцлага хүлээхгүй, ял завшсаар байгаа нь анхаарал татах асуудал мөн. Энэтхэгийн эрх баригчид ихэнхи тохиолдолд иргэдийнхээ эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлж чадахгүй, тэр ч байтугай өөрсдөө гэмт хэрэг үйлдсээр байна. Хүмүүсийг хууль бусаар баривчлан хорих, эрүү шүүлт тулгах болон хууль бусаар цаазлах зэрэг гэмт хэрэг үйлдэгсэд ихэнхидээ ямар ч ял зэмгүй өнгөрдөг. Эрүүгийн шүүхийн тогтолцоо ачааллаа дийлэхгүй байгаа нь хүний эрхийн зөрчил, хүчирхийллийн золиос болсон хүмүүсийн шударга шүүхээр шүүллгэх эрхээ хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. Зэвсэгт бүлэглэлүүдийн үйлдэж буй хүчирхийлэл энгийн номхон иргэдийг эрсдэлд оруулсаар байна.

Өнгөрсөн үед үйлдэгдсэн гэмт хэрэгт холбогдуулан зарим хүмүүсийг баривчилж, ял оноосон. Камбож улсын Шүүхийн онцгой танхим Улаан Кмерчүүдийн дэглэмийн дээрээсээ хоёр дох хүн байсан Нуон Чеа болон төрийн тэргүүнээр ажиллаж байсан Киө Самфан нарыг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэргээр шүүж, бүх насаар нь хорих ял оноолоо. Филиппинд 8-р сард тэтгэвэрт гарсан хошууч генерал Жовито Палпараныг баривчилсан бөгөөд их сургуулийн оюутнуудыг хуль бусаар хулгайлж, цагдан хорьсон хэрэгт холбогдуулан шалгасан.

Индонези улсын ерөнхийлөгч асан Сухартогийн (1965-1998) эрх барьж байх үед болон түүний дараахи үед үйлдэгдсэн хүний эрхийн зөрчлийн хохирогчид шударгаар шүүлгэж, үнэн мөнийг тогтоолгох болон олон улсын эрх зүйн гэмт хэрэгт нөхөн төлбөр олгохыг шаардсаар байна. Үндэсний Хүний эрхийн Комиссоос (Komnas HAM) урьдчилсан мөрдөн шалгалт явуулсны дүнд Ерөнхий Прокурорын газарт шилжүүлсэн хүний эрхийн ноцтой зөрчлийн тухай олон хэргийг шийдвэрлэх талаар ямар нэг ахиц гараагүй.

Шриланка улсад НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл иргэний дайны үеэр үйлдэгдсэн дайны гэмт хэргийн талаар олон улсын мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлсэн. Засгийн газрын ажилтнууд болон тэднийг дэмжигчид хүний эрхийг хамгаалагчдыг олон улсын шинжээчидтэй уулзахгүй байх, мөрдөн шалгах ажиллагаанд оролцохгүй байхыг анхааруулж сүрдүүлсэн. 4-р сард Балба улсын парламент Үнэнийг тогтоох ба эвлэрлийн комисс (ҮТЭК) байгуулах тухай хууль баталсан бөгөөд ҮТЭК болон Хүчээр сураггүй болгох асуудлаархи комисс гэсэн өршөөл үзүүлэх, түүний дотор хүний эрхийг ноцтой зөрчигчдийг өршөөх бүрэн эрхтэй хоёр комисс байгуулсан. Уг нь 2013 оны 1-р сард Дээд Шүүх тэдгээртэй төстэй нэгэн ҮТЭК-ын гаргасан өршөөл үзүүлэх эрх бүхий захирамж нь олон улсын хүний эрх болон 2007 онд батлагдсан Түр Үндсэн хуулийн үзэл санаанд харшилж байна гэсэн шийдвэр гаргаад байсан юм.

ДҮРВЭН НҮҮЖ БҮЙ ХҮМҮҮС

Хэд хэдэн улс дүрвэгчид ба орогнол эрэгчдийг хүний эрхийн ноцтой зөрчилд орж болзошгүй улс орнууд руу албадан буцаахыг хориглосон олон улсын хэм хэмжээг зөрчлөө. Малайз улсын эрх баригчид 5-р сард НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар, НҮБ-ын Дүрвэгсдийн агентлагийн хамгаалалтад байсан 2 дүрвэгч болон нэг орогнол эрэгчийг эрүү шүүлтэд өртөх эрсдэлтэй Шриланка улс руу албадан буцаасан. Шриланка улс орогнол эрэгчдийг тэдний орогнол эрсэн өргөдлийг зохих ёсоор судлан үзэлгүйгээр хорьж саатуулан, албадан гаргаж байна.

НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газрын мэдээгээр дүрвэгчдийн дунд эзлэх афганчуудын хувь маш өндөр байна. Хөрш Иран, Пакистан улсад нийт 2.7 сая бүртгэлтэй афган дүрвэгчид амьдарч байна. 3-р сард НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар 659 961 афганчууд зэвсэгт мөргөлдөөн, аюулгүй байдал хүндэрсэн, байгалийн гамшиг зэрэг шалтгаанаар дотооддоо шилжин суурьшсан талаар мэдэгдсэн. 2014 оны төгсгөлөөр хийхээр төлөвлөөд байгаа аюулгүй байдлын шилжилтээс үүдээд өмнө нь олон улсын хүчний хяналтад байсан нутаг дэвсгэрийг босогчид эзлэн авахыг зорих учраас дотооддоо шилжин суурьшигчдын тоо нэмэгдэх магадлалтай.

Түүнчлэн дотоодын цагаачид алагчлалд өртсөөр байна. Хятад улсад *hukou* хэмээх өрхийн бүртгэлийн тогтолцоонд хийсэн өөрчлөлтөөр хөдөөгийн иргэд

жигж ба дунд зэргийн хот руу шилжих явдал өмнөхөөсөө хялбар болсон. Гэвч нийгмийн халамж, үйлчилгээ авах, түүний дотор боловсрол ба эрүүл мэндийн үйлчилгээ *hukou*-гийн статустай холбоотой байдаг учир алагчлалд өртөх үндэслэл болсоор байна. Уг системээс үүдээд олон дотоодын цагаачид хүүхдээ хөдөө орхихоос аргагүйд хүрдэг билээ.

Цагаач ажилчид хүний эрхийн зөрчил болон алагчлалын золиос болсоор байна. Хонконгт Индонези гаралтай 3 цагаач эмэгтэйтэй холбоотой олны анхаарал татсан шүүх хурал эхэлсэн. Тэдгээр эмэгтэйчүүдийн ажил олгогчдод 21 зүйлт хэрэг, түүний дотор бие махбодод ноцтой гэмтэл учруулсан болон цалин хөлс олгоогүй зэрэг хэрэг тулгасан. 10-р сард Эмнести Интернэшнл Өмнөд Солонгос улсад хөдөө аж ахуйн салбарт ажилладаг цагаач ажилчидтай хийсэн ярилцлага дээр үндэслэсэн тайланг танилцуулсан. Хөдөлмөрлөх Зөвшөөрлийн системийн улмаас тэдгээр цагаач ажилчид уртасгасан цагаар ажиллах, доогуур цалин авах, долоо хоногийн болон жил бүрийн цалинтай амралтаа эдлэж чадахгүй байх, хууль бусаар давхар гэрээгээр ажиллах болон шаардлага хангахгүй нөхцөлд амьдрах зэрэг бэрхшээлтэй тулгардаг. Мөн тэдний олонхи нь ажлын байран дээрээ гадаадын иргэн гэдгээрээ гадуурхагдаж байдаг.

Австрали улс орогнол эрэгчдийн эсрэг хатуу бодлогоо үргэлжлүүлж, завиар ирсэн хүмүүсийг ирсэн газар луу нь буцаах буюу Папуа Шинэ Гвинейн Манус арал, Науруд байх цагаачдыг хорих төв рүү илгээж, эсхүл Австралид хорьж байна.

ӨСӨН НЭМЭГДСЭЭР БҮЙ ШАШНЫ БОЛОН УГСААТНЫ ҮЛ ТЭВЧИХ ҮЗЭЛ

2014 онд шашны болон угсаатны үл тэвчих үзэл, алагчлал өсч байгаагийн зэрэгцээ эрх баригчид нэг бол түүнтэй хуйвалдаж, нэг бол түүний эсрэг тэмцэж чадахгүй байгаа нь тодорхой харагдсан. Пакистан улсад Аллахыг доромжлохыг хориглосон хуультай холбоотой хүчирхийлэл гарсаар байна. Цагдаагийн байгууллага зарим үед “Аллахыг доромжилсон” гэх сэжигтнүүдийн эсрэг халдлага болох гэж байгаа талаар мэдсэн ч тэднийг хамгаалах зохих арга хэмжээ авч чадахгүй байна. Индонези улсад үл тэвчих үзлийн уур амьсгалыг өдөөж байна. Эмнести Интернэшнл Индонези улсад Аллахыг доромжлохыг хориглосон хуулиа хүчингүй болгож, уг хуулиар шийтгэгдэн шоронд хоригдож байгаа хүмүүсийг нэн даруй суллахыг зөвлөмж болгосон.

Шашны болон угсаатны онцлогоос нь шалтгаалан хүч хэрэглэн халдах явдал түгээмэл хэвээр байна. Засгийн газрууд шашны болон угсаатны үл тэвчих үзлийн эсрэг тэмцэж чадахгүй байгаа нь тодорхой байна. Мьянмар ба Шриланка улсын засгийн газар үндсэрхэг үзэлт буддист бүлгүүдийн үндэс угсаа, арь өнгө, шашны үзэн ядалтад үндэслэсэн хүчирхийлэлд уриалсан явуулгыг, хүч хэрэглэсэн тохиолдол олон гарсан хэдий ч зогсоож чадахгүй байна. Тэрчлэн Мьянмар улсын засгийн газар Рохингячуудад тус улсын иргэн болох тэгш нөхцөл олгохыг зөвшөөрөхгүй байна. Пакистанд зэвсэгт бүлэглэлийнхэн шийтгүүдийг хороож, ахмадич

болон христийн шашинтнуудыг мөн онилж байна. Шриланка улсад ч мөн адил зэвсэгт бүлэглэлүүд исламын болон христийн шашинтнуудын эсрэг хүчирхийлэл үйлдсээр байгаа бөгөөд цагдаагийн байгууллага тэднийг хамгаалж чадахгүй байгаагаас гадна тэдгээр хэрэг явдлыг мөрдөн шалгах ажиллагаа хийхгүй байна.

Хятад улсад төвд угсаатнууд алагчлалд өртөж, итгэл үнэмшил, шашин шүтлэгтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал цуглаан хийх эрхээ хязгаарлуулсаар байна. Сичуан мужийн Карзе (хятадаар Ганзи)-д тосгоны даргыг нь хорьсныг эсэргүүцэн жагссан төвдүүдийн эсрэг цагдаа болон аюулаас хамгаалах хүчнийхэн гал нээжээ. Уйгурчууд ажилд орох, боловсрол эзэмших, орон байраар хангагдах зэрэгт алагчлалд өртөж, шашны эрх чөлөөгөө хумиулж, улс төрийн гадуурхалтад өртсөөр байна.

Зарим засгийн газрын эрх баригчид шашныг өөрсдийн алагчлах үзлийг зөвтгөх хэрэгсэл болгодог. Малайз улсын Холбооны шүүх нэгэн христийн шашины сонин өөрийн нийтлэлд “Аллах” гэдэг үгийг ашиглахыг хориглосон шүүхийн шийдвэрийг цуцлуулахаар давж заалдсан өргөдлийг хүлээж аваагүй. Эрх баригчид уг үгийг исламын шашны бус ном бүтээлд ашиглах нь төөрөгдөл үүсгэж, исламын шашинтнуудыг өөр шашинд урвахад хүргэнэ гэж мэдэгдсэн. Уг хориг нь христийн шашинтнуудыг айлган сүрдүүлэх, дарамтлах шалтаг болсон.

Энэтхэг улс 1984 сикхчүүдийг хомроглон хядсан эмгэнэлт явдлын 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд тэрхүү хэрэг

болоод шашны цөөнхийн эсрэг бусад өргөн хүрээтэй дайралтын буруутнууд ял завшсан хэвээр байна.

АЛАГЧЛАЛ

Олон оронд хүмүүс алагчлалд өртсөөр байгаа ба ялангуяа эрх баригчид тэдгээр хүмүүсийг болон айл хотлуудыг хамгаалах зохих арга хэмжээ авахгүй байгаа газарт алагчлал бүр ч хүчтэй.

Алагчлал, түүний дотор хүйс, каст, анги давхарга, угсаа гарал болон шашнаар нь алагчлах явдал Балба улсад оршоор байна. Хохирогчид нийгмээс гадуурхагдаж, эрүү шүүлт буюу бусад хэлбэрээр хэрцгий харьцах, түүний дотор бэлгийн хүчирхийлэлд өртдөг. Шоовдорлогдсон бүлгийн эмэгтэйчүүд, түүний дотор далит гаралтай болон ядуу эмэгтэйчүүд олон хэлбэрийн алагчлалын улмаас зовлон бэрхшээлтэй учирсаар байна. Энэтхэг улсад далит охид эмэгтэйчүүд кастад суурилсан алагчлал ба хүчирхийллийн янз бүрийн төвшний золиос болсоор байна. Өөрсдөө томилогдсон тосгоны зөвлөлүүд нийгмийн зөрчил гаргалаа гэсэн үндэслэлээр эмэгтэйчүүдэд ял шийтгэл оноосон хууль бус шийдвэр гаргадаг.

Япон улсын засгийн газар алагчилсан шинжтэй үг хэллэгийн эсрэг үг дуугарч чадахгүй байгаа бөгөөд *Zainichi* (“Япон улсад амьдарч байгаа” гэсэн утгатай) хэмээн нэрлэгддэг Солонгос гаралтай хүмүүс болон тэдний үр удмын эсрэг доромж утгатай үг хэрэглэх, дарамтлах явдлыг таслан зогсоож чадахгүй байна. 2-р сар Дээд Шүүх “*Zainichi Tokken wo Yurusanai Shimin no Kai*” бүлгийг Солонгос бага сургуулийн дэргэд

нийтийн жагсаал цуглаан зохион байгуулахдаа солонгосчуудын эсрэг арьс өнгөөр доромжилсон утгатай үг хэрэглэхийг хориглосон.

Шриланка улсад угсаатны, хэлний болон шашны цөөнх, түүний дотор тамил, ислам болон христийн шашинтай айл хотлуудыг алагчлах явдал үргэлжилсээр байна. Цөөнхийн гишүүдийн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хууль бусаар хязгаарласаар байна.

БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ БА НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ

Бүс нутгийн олон оронд бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэх, хамгаалах хэрэгжүүлэх талаар ахиц дэвшил гаргах шаардлага байсаар байна.

4-р сард Филиппин улсын Дээд Шүүх Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тухай хуулийг батламжилсан нь засгийн газарт жирэмслэхээ хамгаалах орчин үеийн арга хэрэгслийг санхүүжүүлэх, сурагчдад нөхөн үржихүйн эрүүл мэнд болон бэлгийн боловсрол олгох замыг зассан юм. Гэвч Филиппин улс ямар ч тохиолдолд үр хөндөлтийг гэмт хэрэг гэж үздэг, дэлхий дээр хамгийн хатуу үр хөндөлтийн хуультай улс хэвээр байна. Индонези улсад 7-р сард хүчингийн гэмт хэргийн хохирогчдод хууль ёсоор үр хөндөлт хийлгэх хугацааг 40 өдрөөр тогтоосон хууль батлагдсан. Ийнхүү уг хугацааг богиносгосон нь хүчингийн гэмт хэргийн олон хохирогчдын аюулгүй үр хөндөлт хийлгэх боломжийг хязгаарлаж болзошгүй юм.

Балба улсын засгийн газрын охид эмэгтэйчүүд эсрэг хүйсийн алагчлалыг таслан зогсоох

хүчин чармайлт олигтой үр дүнд хүрэхгүй байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн савны өвчний эрсдлийг бууруулж чадахгүй байна. Эмнести Интернэшнлийн ЕНБД Салил Шетти уг өвчин тархсан тус улсын хөдөөгийн айл хотлуудын эмэгтэйчүүдийн дунд “Миний бие-миний эрх” кампанит ажлыг эхлүүлсэн.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ

Бүс нутаг даяар эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртсөөр байгаа бөгөөд тэр ч байтугай тэрхүү эрхээ хэрэгжүүлэхийг зорьж байхдаа ч хүчирхийлэлд өртөж байна. Тухайлбал, Пакистан улсын Хойд Вазиристан мужийн Утхманзай овгийн ахлагчдын *jirga* (уламжлалт шийдвэр гаргах байгууллага) эмэгтэйчүүдийг дүрвэгсдийн хуарангаас хүмүүнлэгийн туслалцаа эрснийх нь төлөө хүч хэрэглэнэ гэж сүрдүүлсэн.

Энэтхэг улсын эрх баригчид 2013 онд хүчин төгөлдөр болсон эмэгтэйчүүдийн эсрэг гэмт хэргийн тухай шинэ хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхгүй байгаагаас гадна хэрэгжүүлэх талаар дорвитой шинэчлэл хийхгүй байна. Хэрэв эхнэр нь 15-аас дээш настай бол гэр бүл дэх хүчингийн хэргийг гэмт хэрэгт тооцдоггүй хэвээр байна.

Тус бүс нутгийн хэд хэдэн оронд хүүхдийг хүчээр гэрлүүлэх явдал байсаар байна. “Нэр төрийн аллага” Афганистан болон Пакистан улсад гарсаар байна. Афганистанд Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай хуулийн дагуу бүртгэгдсэн хэргийн тоо нэмэгдсэн хэдий ч энэ нь гэмт хэргийн тоо өссөнөөс эсхүл гэмт хэргийг мэдээлэх явдал өссөний

алинаас нь шалтгаалсан нь тодорхойгүй юм. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг хамгийн бага бүртгэгддэг гэмт хэргийн нэг байсаар байна. Афганистаны Хараат бус Хүний эрхийн комисс зөвхөн 2014 онд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн 4 154 хэргийг бүртгэсэн. Эрх баригчид хэд хэдэн хуулийг батлах буюу нэмэлт өөрчлөлт оруулж, гэмт хэргийн хохирогчид болон буруутай этгээдүүдийн гэр бүлийн гишүүдийг мэдүүлэг өгөхийг хориглосон. Хүйст суурилсан хүчирхийллийн дийлэнхи хувь гэр бүлийн хүрээнд гардаг учраас энэ нь хүчээр гэрлүүлэх буюу хүүхдийг гэрлүүлэх болон гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийг амжилттай шүүн таслах ажиллагааг бараг боломжгүй болгосон.

Япон улсад Коногийн мэдэгдлийг (20 жилийн өмнө засгийн газар Дэлхийн 2-р дайны өмнө болон дайны үед байсан цэргийн бэлгийн боолчлолын тогтолцооны хохирогчдоос уучлалт хүссэн мэдэгдэл) боловсруулсан үйл явцыг эргэн шалгасан тухай засгийн газраас хэрэгжүүлсэн судалгааны дүнг олон нийтэд танилцуулсан. Хэд хэдэн олны танил хүмүүс уг тогтолцоог зөвтгөсөн буюу буруушаасан мэдэгдэл хийсэн. Японы засгийн газар албан ёсоор “бэлгийн боолчлол” хэмээх нэр томъёог хэрэглэхээс татгалзсаар байгаа ба мөн хохирогчдод үр дүнтэй нөхөн олговор олгохоос татгалзсаар байна.

Папуа Шинэ Гвиней улсад илбэ жатга хийсэн хэрэгт буруутган эмэгтэйчүүд, хүүхдүүдийг хүчирхийлж, зарим тохиолдолд амь насыг нь бүрэлгэж байна. НҮБ-ын Шүүхээс гадуур, дур зоргоор

цаазаар аваачих асуудлаархи Тусгай илтгэгч илбэ жатгатай холбоотой аллага ихээхэн сэтгэл түгшээж байгааг онцолсон.

ЦААЗААР ВАХАХ ЯЛ

Бүс нутгийн хэд хэдэн улс цаазаар авах ялыг хэрэглэсээр байгаа бөгөөд Хятад улс цаазаар авах ялыг маш өргөнөөр ашиглаж байна.

Япон улсад цаазаар авах ялыг гүйцэтгэсээр байна. 3-р сард шүүхээс Хакамада Иваогийн хэргийг ахин шүүж, нэн даруй суллах шийдвэр гаргасан. Хакамада Иваог 1968 онд хүчээр авсан мэдүүлэгт үндэслэн шударга бусаар шүүж, цаазаар авах ял оноосон бөгөөд тэрээр дэлхий дээр үхэх ялаа хамгийн удаан хүлээж байгаа хоригдол юм.

Вьетнамд цаазаар авах ялыг гүйцэтгэсээр байгаа бөгөөд хэд хэдэн хүнийг эдийн засгийн гэмт хэрэгт холбогдуулан цаазаар авах ял оноожээ.

Үндэсний болон олон улсын шүүмжлэл зарим нэг үр нөлөө авчирсан. Малайз улсад Чандран Паскаран болон Осариаки Эрнст Обаяанбон нарын цаазаар авах ялын гүйцэтгэлийг хойшлуулсан. Гэвч цаазаар авах ял оноосон хэвээр байгаа ба цаазаар авах ялыг нууцаар гүйцэтгэж байгаа талаар мэдээ бий.

1-р сард Энэтхэгийн Дээд Шүүх цаазаар авах ялын гүйцэтгэлийг зүй бусаар сунжруулах нь эрүү шүүлттэй дүйцэх бөгөөд сэтгэцийн өвчтэй хүнийг цаазаар авах нь үндсэн хуульд харш гэсэн шийдвэр гаргасан. Мөн цаазаар авах ял сонссон хүмүүсийн эрхийг хамгаалах удирдамжийг гаргасан.

12-р сард Пакистаны Пешавар мужийн нэгэн сургууль руу

талибанчууд довтолсны дараа тус улс цаазаар авах ялын гүйцэтгэлийг түдгэлзүүлсэн байснаа цуцалж, терроризмтай холбоотой хэрэгт ял сонссон хоригдлуудыг цаазалж эхэлсэн. 500 гаруй хүмүүс цаазаар авахуулах эрсдэлтэй байна гэсэн мэдээ байна.

Афганистан улс ихэнхидээ шударга бус шүүх хурлаар цаазаар авах ял оноож байна. 10-р сард Кабулын Пул-э-Чарки шоронд 6 хүнийг цаазалжээ. Бүлэглэн хүчиндсэн хэрэгт холбогдсон 5 эрийн хэргийг тэдэнд хатуу ял оноохыг шаардсан олон нийтийн ба улс төрийн дарамт шахалтын улмаас шударга бусаар шүүсэн гэж үзэж байгаа бөгөөд яллагдагчид цагдаа тэднийг хорьж байхдаа эрүү шүүлт тулгаж хэрэг хүлээлгэсэн гэж мэдэгдсэн.

КОМПАНИЙ ХАРИУЦЛАГА

Компаниуд хүний эрхийг хүндэтгэх үүрэг хүлээдэг. Гэвч Ази-Номхон далайн бүс нутгийн хэд хэдэн улсад компаниуд тэрхүү үүргээ төдийлөн сайн хэрэгжүүлэхгүй байна. Энэтхэг улсад томоохон дэд бүтэц болон арилжааны төслөөс болж мянга мянган хүнийг орон гэр, төрсөн нутгаас нь албадан нүүлгэж байна. Ялангуяа, шинэ болон өргөжиж байгаа уурхай, далангийн ойролцоо амьдардаг адиваси (уугуул) иргэд үүнд ихээхэн өртсөн. Папуа Шинэ Гвинейн Поржера алтны уурхай дээр уул уурхайн компани ба орон нутгийн оршин суугчдын хооронд зөрчилдөөн хурцадсан. 6-р сард албадан нүүлгэх ажлыг хариуцаж байсан цагдаа нар 200 айлын гэр орныг шатаасан. Албадан нүүлгэлтийн үеэр цагдаа бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл үйлдсэн талаар гомдол ирсэн.

12-р сард Энэтхэгийн Бопалд 1984 онд хорт хий алдагдсан гамшиг тохиолдсоны 30 жилийн ойг тэмдэглэв. Ослоос амьд үлдэгсдэд алдагдсан хорт хий болон үйлдвэрийн байрлаж байсан газрын бохирдлоос үүдэн эрүүл мэндийн ноцтой хохирол учирсан билээ. Доу химийн үйлдвэр болон Юнион Карбид компани Бопалын шүүхээс гаргасан гэмт хэргийн зарлан дуудах хуудаст хариу өгөөгүй. Энэтхэгийн засгийн газар үйлдвэрийн бохирдсон газрыг өнөө хүртэл хоргүйжүүлж цэвэрлэх ажлыг хийгээгүй.

Камбож улсад газар болон албадан нүүлгэлттэй холбоотой зөрчил мөргөлдөөн үргэлжилсээр байна. Энэ нь орон нутгийн эрх баригчид болон хувийн компаниудыг татан оролцуулсан жагсаал цуглаан, мөргөлдөөнийг дэвэргэж байна. 10-р сард олон улсын эрх зүйн хэсэг шижээчид 10 хохирогчийг төлөөлөн Олон улсын эрүүгийн шүүхэд мэдээлэл хийхдээ Камбожийн засгийн газар “өргөн далайцтайгаар, системтэйгээр” газрыг булаан авч байгаа нь хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг хэмээн мэдэгдсэн.

ЛЕСБИ, ГЕЙ, БИСЕСУАЛЬ, ТРАНСЖЕНДЕР БОЛОН ИНТЕРСЕКС ХҮМҮҮСИЙН ЭРХ

Бүс нутгийн хэд хэдэн улсад ижил хүйстнүүдийн бэлгийн харилцааг гэмт хэрэгт тооцсоор байна. Ганц эерэг зүйл гэвэл 4-р сард Энэтхэгийн Дээд Шүүх түүхэн шийдвэр гаргаж трансжендер хүмүүсийг хүлээн зөвшөөрсөн. Энэхүү шийдвэрийн дагуу эрх баригчид трансжендер хүмүүсийн өөрсдийгөө эрэгтэй, эмэгтэй

эсхүл “гуравдагч хүйс” хэмээн тодорхойлсныг хүлээн зөвшөөрч, тэдэнд зориулсан нийгмийн халамжийн бодлого болон боловсрол ба ажил эрхлэлтэд квот олгох ёстой болсон. Гэвч трансжендэр хүмүүсийн эсрэг дарамт, хүчирхийлэл гарсаар байна.

11-р сард Малайз улсын Давж заалдах шүүх түүхэн шийдвэр гаргаж, эсрэг хүйстнийхээ хувцсыг өмсөх нь хууль бус гэж заасан Негри Сембилан шариатын хуулийг Үндсэн хуульд харш хэмээн үзлээ. Гэвч Эмнести Интернэшнлд ЛГБТИ хүмүүсийг зөвхөн бэлгийн чиг баримжаан дээр нь үндэслэн баривчлах, хорих тохиолдол гарсаар байгаа тухай мэдээлэл ирсээр байгаа бөгөөд тэднийг алагчлан үзсээр байна.

10-р сард Сингапур улсын Дээд Шүүх харилцан зөвшилцсөн ижил хүйстнүүдийн харилцааг гэмт хэрэг хэмээн үздэг Эрүүгийн хуулийн 377А заалтыг хэвээр үлдээсэн. Бруней улсын шинэ Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцогдох ёсгүй гэр бүлээс гадуурхи харилцаа, харилцан зөвшилцсөн ижил хүйстнүүдийн харилцаа болон хулгай, хүчингийн гэмт хэрэгт чулуугаар шидэж цаазлах ял оноох болсон.

Эцэст нь дүгнэхэд Ази-Номхон далайн бүс нутагт өрнөж байгаа геополитик ба эдийн засгийн эрчимтэй шилжилт нь тус бүс нутгийн бүх хүн аливаа шийтгэл хүлээх эрсдэлгүйгээр иргэний эрхээ шаардах боломжийг бий болгохын тулд хүний эрхийн баталгааг сайжруулж, доголдолтой зүйлсийг засаж залруулах талаар хойшлуулалгүй ажиллахыг шаардаж байна.

ЕВРОП БА ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

2014 оны 11-р сарын 9-нд Берлиний хана нуран унаж, Хүйтэн дайн дуусч, нэгэн тоймчийн хэлснээр “түүхийн төгсгөл ирсний” 25 жилийн ойг тэмдэглэв. Энэхүү ойг Берлин хотноо тэмдэглэхдээ Германы канцлер Ангела Меркель “Берлиний хана нуран унасан нь бидэнд мөрөөдөл биелдэг гэдгийг харуулсан юм” хэмээн мэдэгдсэн. Үнэндээ коммунист Европын олон хүний хувьд мөрөөдөл нь биелсэн. Гэвч 25 жил өнгөрчихөөд байхад илүү их эрх чөлөөнд хүрэх мөрөөдөл хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсуудын сая сая хүмүүсийн хувьд алс хэтийн зүйл шиг санагдсаар байгаа бөгөөд хуучнаас төрсөн шинэ элитүүд хүмүүсийн гараас өөрчлөлт хийх боломжийг нь булааж авсаар байна.

2014 он зөвхөн ахиц дэвшил царцсан жил байсангүй. Мөн ухралт гарсан жил байлаа. Хэрэв Берлиний хана нуран унасан нь түүхийн төгсгөл ирснийг илтгэж байсан бол Зүүн Украин дахь хямрал мөргөлдөөн, Оросууд Крымиийг өөртөө нэгтгэсэн зэрэг нь түүх ахин үргэлжилж буйг харуулав. Ангела Меркелийн нэгэн адил мөн өдөр үг хэлсэн ЗХУ-ын удирдагч асан Михайл Горбачев “Дэлхий ертөнц шинэ хүйтэн дайны ирмэгт ирээд байна. Тэр бүү хэл түүнийг аль хэдийнэ эхэлчихсэн гэж хэлэх хүмүүс ч байна.” хэмээн шулуухан мэдэгдсэн юм.

Украинд өрнөж буй ноцтой үйл явдал мөрөөдөхийн хэцүү бөгөөд бэрхшээлтэй талыг харуулж байна. 2-р сард Евромайданы жагсаал

цуглаан цуст төгсгөлөө хийх үеэр 100 гаруй хүн амь насаа алдсан юм. Оны эцсийн байдлаар Зүүн Украин дахь байлдааны улмаас 4000 гаруй хүн амиа алдсаны олонхи нь энгийн номхон иргэд байв. 9-р сард гал зогсоох хэлэлцээрт гарын үсэг зурсныг эс харгалзан орон нутгийн шинжтэй байлдаан үргэлжилсээр байсан бөгөөд оны эцсийн байдлаар асуудлыг хурдан шийдэх төлөв харагдахгүй байв. ОХУ босогчдыг цэрэг арми, техник хэрэгслээр дэмжиж байгаа гэдгээ хүлээн зөвшөөрөхгүй байгаа хэдий ч бодит байдал дээр энэ нь эсрэгээрээ гэдэг нь улам олон нотлох баримтаар нотлогдсоор байна. Хоёр талын аль аль нь олон улсын хүний эрхийн ба хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээг зөрчсөөр байсан ба ялагаврлалгүй бөмбөгдсөний улмаас олон зуун энгийн иргэд амь насаа алдсан. Хямрал мөргөлдөөний шугамын дагуу болон босогчдын эзлэн авсан нутаг дэвсгэрт хууль цааз, дэг журам үгүй болсноос босогчид ба Киевийн талыг баримтлагч сайн дурынхны аль аль нь хүмүүсийг хулгайлж, цаазаар аваачиж, эрүүдэн шүүх буюу бусад хэлбэрээр хэрцгий харьцаж байна. Талуудын аль аль нь хүний эрхийн тэдгээр зөрчлийг мөрдөн шалгах, хяналтдаа авах эрмэлзэлгүй байна.

Крымын нөхцөл байдал урьдчилан таамагласан шугамын дагуу доройтлоо. ОХУ-ын бүрэлдэхүүнд орсноор өөрчлөлтийг эсэргүүцэгчдийн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарлахын тулд Оросын хууль тогтоомж, практикийг хэрэглэх болов.

Украины талыг дэмжигч идэвхитнүүд болон Крымын татарчуудыг дайрч довтлон,

баривчлан хорьж, зарим тохиолдолд сураггүй алга болгосон. Киевт хуулийн засаглалыг бэхжүүлж, эрүүгийн шүүхийн тогтолцоон дахь гажуудлыг арилгах, ужгирсан авлигатай тэмцэхэд шаардлагатай шинэчлэлийг эхлүүлэх асар том зорилт ерөнхийлөгчийн болон парламентын сонгууль болон нутгийн зүүн хэсэгт өрнөсөөр байгаа хямрал мөргөлдөөний улмаас хойшилсон. Оны эцсийн байдлаар Евромайданы жагсагчдыг хөнөөсөн хэргийг мөрдөн шалгах талаар олигтой ахиц гарсангүй.

Украин дахь геополитикийн шугамд гарсан өөрчлөлт ОХУ-д хэд хэдэн үр дагавар авчирсны дотор ерөнхийлөгч Путины нэр хүнд өссөний зэрэгцээ Кремль өөрөөр сэтгэгчдэд илүү болгоомжтой хандах болсон. Өрнөдийн орнуудтай харилцаа муудсан нь голлох хэвлэл мэдээллийн хэрэгслээр Өрнөдийн эсрэг, Украины эсрэг суртал ухуулга хүчтэй хийх болсноор илэрч байна. Түүний зэрэгцээ Кремлийн зүгээс хэвлэл мэдээлэл ба интернэтийг атгасан барьцаа чангалж, эсэргүүцлийг нухчин дарж, хараат бус ТББ-уудыг элдвээр муучлахын хэрээр үзэл бодлоо илэрхийлэх, санал нийлэхгүй байгаагаа хуваалцах орон зай мэдэгдэхүйц хумигдсаар байна.

Хуучин ЗХУ-д багтаж байсан бусад газарт ч Берлиний хана нурсны дараа гэрэлтэж байсан итгэл найдвар, гэгээн зорилтууд улам бүдгэрлээ. Төв Азийн Казакстан улсад авторитар засгийн газар хүчээ авч, Туркменистанд бүр ч илүү хүчирхэгжлээ. Узбекистанд авторитар засаглал бага зэрэг ганхаж байгаа хэдий ч тэр нь эрх

баригч элитүүдийн хоорондын зөрчилтэй илүү холбоотой болохоос өнөөг хүртэл нухчин дарсаар байгаа дэглэмд нийтээр дургүйцэх үзэлтэй холбоогүй юм. Азербайжан улс өөрөөр сэтгэгчдийг хүчтэйгээр нухчин дарсан бөгөөд оны эцсийн байдлаар Эмнести Интернэшнл тус улсад нийт 23 үзэл санааны хоригдол байгааг тогтоосон. Тэдний дотор блогчид, улс төрийн идэвхитнүүд, иргэний нийгмийн удирдагчид болон хүний эрхийн хуульчид байв. Оны эхний 6 сард Азербайжан улс Европын Зөвлөлийг тэргүүлсэн хэдий ч энэ асуудлаар ахиц гараагүй. Азербайжанд төдийгүй Төв Азийн бусад улсад стратегийн ашиг сонирхол зарчимч олон улсын шүүмжлэл болон өргөн тархсан хүний эрхийн зөрчлийн эсрэг тэмцлээс ямагт түрүүнд чухлаар тавигдсаар байна. ОХУ-ын тухайд ч гэсэн иргэний болон улс төрийн эрхийг нухчин дарах явдал өргөжсөөр байгаа ч хачирхалтай нь олон улсын төвшинд хэн ч шүүмжлэхгүй байна.

Хэрэв ОХУ-ыг зах зээлийн алдартай удирдагч гэж үзвэл “ардчилсан” авторитаризм бүс нутгийн бусад газарт ч мөн ажиглагдах боллоо. 8-р сард Турк улсад Ресеп Эрдоган өөртэй нь болон гэр бүлийнхэнтэй нь холбоотой их хэмжээний авлигын дуулиан шуугианыг эс харгалзан ерөнхийлөгчийн сонгуульд давуу ялж, санал цуглуулах хүч чадлаа харуулав. Тэрээр эдгээр асуудалтай үүний өмнөх жил Гезигийн эсэргүүцлийг намжаасныхаа нэгэн адил нэгэн цагт түүний хамтрагч явсан Фетулла Гюлений талыг баримтлагч гэж сэжиглэгдсэн олон зуун прокурор, цагдаагийн

ажилтан, шүүгчдийг өөр албанд шилжүүлэх замаар тэмцсэн. 4-р сард Унгар улсад эрх баригч Фидеж нам сонгуульд дахин ялалт байгуулснаар засаглал хуваах зарчим улам бүдгэрч, нөлөө бүхийн ТББ-уудыг гадаадын засгийн газрын ашиг сонирхлыг хамгаалсан хэрэгт буруутган дарамтлах болжээ. Оны эцсийн байдлаар хэд хэдэн ТББ-ыг санхүүгийн зөрчил гаргасан хэрэгт буруутган мөрдөн шалгахаар сүрдүүлээд байна.

Европын Холбоо (ЕХ) даяар тархаад байгаа эдийн засгийн хүндрэл болон улс төрийн голлох намуудад итгэх итгэл суларсан нь улс төрийн хоёр туйлд хамаарах популист намууд сэргэхэд түлхэц болсон. Үндсэрхэг үзэл хийгээд гадаадынхныг үзэн ядах үзэл цагаачлалын бодлого улам чангарч байгаагаар, мөн ЕХ-ны эрх мэдэлд үл итгэх үзэл нэмэгдэж байгаагаар илэрч байна. ЕХ-г өөрийг нь болон Европын Хүний эрхийн конвенцийг шүүмжлэх явдал нэмэгдсээр байна.

Их Британи болон Швейцарь улсын эрх баригч намууд Европын хүний эрхийн шүүх рүү ил тодоор довтолж, Европын хүний эрхийн конвенцийн тогтолцооноос гарах талаар хамгийн түрүүнд ярьцгааж байна.

Товчоор хэлбэл, Берлины хана нуран унаснаас хойш тийм ч их удаагүй байхад олон улсын хүний эрхийн болон хүмүүнлэгийн эрх зүйн цар хүрээ Европ ба Төв Азийн бүс нутагт нэлээдгүй хэврэг болчихоод байна.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ БА ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүн байсан улсууд даяар автократ засгийн

газар эрх мэдлээ хэвээр хадгалах буюу улам бэхжүүлж байна. ОХУ-д Владимир Путин ерөнхийлөгчийн эрх мэдлээ эргүүлэн авснаас хойш үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөөний хэрэгжилт хурдацтайгаар муудав. Жагсаал цуглаан зохион байгуулах тухай хууль зөрчихөд оногдуулах шийтгэл, түүний дотор гэмт хэрэгт тооцож ял оноох явдал нэмэгдсэн. Өнгөрсөн жилийн турш жижиг хэмжээтэй, гэнэтийн жагсаал цуглааныг хэдий тайван замаар болж байсан ч тогтмол тарааж, олон зуун хүнийг баривчилж, торгууль ногдуулж, богино хугацаагаар хорих ял оноолоо. Дайны эсрэг 3-р сард ба 9-р сард зохион байгуулсан арай томхон бөгөөд төлөвлөсөн жагсаал цуглааныг явуулахыг зөвшөөрсөн. Хараат бус, асуудалд шүүмжлэлтэй ханддаг ТББ-уудыг хэвлэл мэдээлэл болон улс төрчид гадаад гүрнүүдийн мөнгөөр, тэдний ашиг сонирхлыг хамгаалахаар ажиллаж байгаа 5 дахь тулгуур хэмээн байнга сурталчилж байна. Хэвлэл мэдээллийн хар кампанит ажлын улмаас нэр төр нь унасан арав гаруй ТББ улс төрийн хувьд ихээхэн хортой “гадаадын агент” хэмээх нэр хаягаар бүртгүүлэхгүй гэж шүүхэд хандсан ч амжилт олоогүй бөгөөд эцсийн бүлэгт тэдний 5 нь татан буугдахаас аргагүйд хүрсэн юм.

Беларус улсад жагсаал цуглаан хийхийг ихээхэн хязгаарласан хууль хэрэгжиж байгаа нь олон нийтийн жагсаал цуглаан хийх боломжийг үр дүнтэйгээр хаасан. Жагсаал цуглаан хийхийг оролдсон цөөн хэдэн хүн богино хугацаагаар хоригдлоо. 5-р сард болсон Мөсний хоккейн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг угтан 16

иргэний нийгэм идэвхитнүүдийг баривчилж, 5- 25 хоног захиргааны журмаар хорих ял оноосон.

Чернобылийн цөмийн ослын ойг тохиолдуулан зохион байгуулсан тайван жагсаалтай холбогдуулан 8 хүнийг шүүхийн шийдвэргүйгээр баривчилсан. Тэдэнд “танхайрсан” болон “цагдаагийн тушаал биелүүлээгүй” хэрэг тулгасан байна. Жагсаал болохоос хэд хоногийн өмнө улс төрийн идэвхитэн өөр 8 хүнийг түүнтэй төстэй хэрэгт буруутган хорьсон юм.

Азербайжан улсад иргэний нийгэм болон улс төрийн идэвхитнүүдийг ихээхэн онилж байна. Хүний эрхийн 10 тэргүүлэх байгууллагыг хүчээр татан буулгах буюу үйл ажиллагаагаа зогсоохоос аргагүйд хүргэсэн бөгөөд дор хаяж 6 нэртэй хүний эрхийг хамгаалагчийг ажилтай нь холбоотой зохиомол хэрэгт холбогдуулан шоронд хорьсон.

Блогчид болон сөрөг хүчний залуу удирдагчдыг хар тамхитай холбоотой хэрэгт холбогдуулах нь түгээмэл байна. Хараат бус сэтгүүлчид дарамт шахалт, хүчирхийлэлд өртөж, зохиомол гэмт хэргийн золиос болсоор байна.

Төв Азийн нөхцөл байдал огт дээрдсэнгүй. Туркменистан улсад сүүлийн жилүүдэд нэр төдий парламентийн шинэчлэл хийж, хараат бус хэвлэл мэдээллийн байгууллага, ТББ-ууд буюу улс төрийн намуудыг бий болгохыг зорьсон ч тэдгээр нь жинхэнэ утгаараа бүрэлдэн бий болоогүй л байна. Интернэтэд холбогдох болон онлайнаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг маш их хязгаарлаж байна. Узбекистанд зүрх зоригтой цөөн тооны хүний

эрхийн идэвхитнүүд ажлаа үргэлжлүүлж байгаа хэдий ч байнгын хяналтын дор, амь насандаа эрсдэл учруулсан нөхцөлд ажиллахаас аргагүй байна. Эдгээр хоёр улсад жагсаал цуглаан хийнэ гэдэг бараг боломжгүй зүйл юм. Киргизстан улсад иргэний нийгмийн идэвхитнүүд илүү эрх чөлөөтэйг нөхцөлд ажилладаг ч дайралтад өртөх явдал байсаар байна. Гэвч энэ улсад ч гэсэн засгийн газрын зүгээс бүртгэлгүй нийгэмлэг холбоо байгуулах эрхийг цуцлах хуулийн төсөл санаачилсан бөгөөд парламент дээр ОХУ-тай адил “гадаадын агент”-ын тухай хууль батлах талаар яриа өрнүүлээд амжсан.

Казакстан улсад шинээр батлагдсан Гэмт хэргийн тухай хуульд ТББ-уудын хууль ёсны үйл ажилагааг хязгаарлахад хэрэглэгдэж болох хэд хэдэн гэмт хэргийг багтаасан бөгөөд засгийн газар ТББ-ууд гадаадаас санхүүжилт авахад илүү хатуу хязгаарлалт тогтоох асуудлыг судлаж эхэлсэн. Хэдийгээр олон нийтийн жагсаал цуглаан явагдаж байгаа ч тэдгээрт оролцогчдод торгуулах буюу хоригдох эрсдэл тулгарч байна. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө хумигдаж, интернэтэд илүү хатуу хязгаарлалт тогтоож, нийгмийн сүлжээ болон блогийг хязгаарлаж, хаалттай шүүх хуралдаанаар гаргасан шийдвэрээр интернэтэд суурилсан эх сурвалжид хориг хаалт тогтоолоо.

Турк улсын эрх баригч АК нам ихэвчлэн нийтийн ба хувийн хэвшлийн бизнесийн хэлхээ холбоогоо ашиглах замаар хэвлэл мэдээлэл дэх нөлөөгөө бэхжүүлэв. Хараат бус сэтгүүлчдийг бухимдсан редакторууд, дургүй нь хүрсэн

ээд ажлаас нь халсаар байгаа бөгөөд өөрөө өөртөө цензур тавих явдал түгээмэл хэвээр байна. 2013 онд болсон Гезигийн жагсаалын үеэр хүч хэрэглэн дарсан бөгөөд жагсаал цуглаан хийхийг хязгаарласан хууль, тайван жагсагчдыг хүч хэрэглэн тараах замаар тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөг зөрчсөөр байна. Хүмүүс олон тоогоор цуглах аюултай эсхүл эмзэг сэдвийн талаар жагсаал хийх болгонд ийнхүү хүч хэрэглэн жагсагчдыг тараадаг. 12-р сард хэд хэдэн сэтгүүлчийг авлигын хэргийн талаар мэдээ сурвалжлага бичсэнийх нь төлөө терроризмын эсрэг хуулийн дагуу баривчилж хорив.

ДҮРВЭГЧИД БА ЦАГААЧДЫН ЭРХ

Дэлхийн 2-р дайн дууссанаас хойш анх удаа дэлхий даяар шилжин суурьшсан хүмүүсийн тоо 50 саяд хүрлээ. ЕХ болон цөөхөн улсыг эс тооцвол, нийт гишүүн орнууд тэдгээр хүмүүсийг өөрсдийн нутаг руу оруулахгүй байх хүсэлтэй байна. Энэ нь ЕХ-ны зүгээс Сирийн дүрвэгчдийн хямралд өгсөн хариу үйлдлээс илт харагдсан билээ. Оны төгсгөл гэхэд 4 сая гаруй Сирийн дүрвэгчдийн ердөө 150 000 нь л ЕХ-нд амьдарч байсан бөгөөд түүнтэй бараг адил тооны дүрвэгчид Исламын улс бүлэглэл Кобаниг эзэлсний улмаас ганц долоо хоногийн дотор Турк улс руу орж ирсэн юм. ЕХ-ны гишүүн улсууд НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар, НҮБ-ын Дүрвэгсдийн агентлагаас шилжин суурьших шаардлагатай гэж тодорхойлсон 380 000 гаруй Сирийн дүрвэгчдээс ердөө 36300 орчмыг нь хүлээн авахаа амалсан.

Герман улс 20 000 дүрвэгчийг суурьшуулна гэсэн. Харин Их Британи, Франц, Итали, Испани, Польш зэрэг нийлээд 275 сая хүн амтай улсууд 2 000 дүрвэгчийг хүлээж авна гэсэн нь хүн амынх нь дөнгөж 0.001% хувь юм.

Дүрвэгчид болон цагаачдад Европ руу хүрэх хууль ёсны аюулгүй зам байхгүйгээс, мөн газрын хилээ битүүмжлэх ЕХ-ны хатуу бодлогын улмаас урьд өмнө нь байгаагүй олон тооны хүн Европ руу далайгаар хүрэхээр эрмэлзэж, олноороо далайд живж амиа алдаж байна. Оны эцсийн байдлаар НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газрын тооцоолсноор 3400 орчим дүрвэгчид ба цагаачид Газрын дундад тэнгист амиа алдсан нь дэлхий дээрхи хамгийн аюултай далайн зам болоод байна.

Оны эхний 10 сард Маре Нострум хэмээх Итали улс дангаараа явуулсан гайхамшигтай эрэн хайх, аврах ажиллагааны ачаар илүү олон хүн далайд амиа алдах байснаас сэргийлж чадсан юм. 100 000 орчим хүний амийг аварсны бараг тал хувь нь Сири, Эритрей, Сомали улсын дүрвэгчид байв. Гэвч ЕХ-ны бусад гишүүн орнуудын ихээхэн шахалтын дүнд 10-р сарын 31-нд уг ажиллагааг зогсоосон юм. Түүний оронд ЕХ-ны хамтарсан, Фронтекс хилийн агентлагийн удирдлага зохицуулалтын дор Тритон хэмээх ажиллагааг эхлүүлсэн ч цар хүрээ, төвшин, бүрэн эрх нь ихээхэн хумигдмал юм.

ЕХ-ны газрын хилийн шугамын дагуу улам өндөр, улам урт болсоор байгаа хамгаалалтын хашааг давж гарч чадсан нэгнийг нь Испани, Грек, Болгар улс хууль бусаар Турк, Марокко руу буцаан

хөөх эрсдэл тулгардаг. Испанийн эрх баригч нам Олон нийтийн Аюулгүй байдлын тухай хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах санал тавьсан бөгөөд ингэснээр тус улсын Сеута ба Мелиллагаас Марокко руу албадан гаргах явдлыг хуульчлах юм. ЕХ эдгээр улстай хилийн хяналтын удирдлагаа бэхжүүлэхийг эрмэлзэж байгаа нь албадан гаргах явдлыг улам дэвэргэж байна.

Европ хэмээх цайзны гяндан болсон цагаачдыг хорих төвүүд дүүрэн хүнтэй, дийлэнхидээ даац нь хэтэрсэн байдалтай байна. Бичиг баримтгүй цагаачид болон орогнол эрэгчид, гэр бүл үр хүүхдийнхээ хамтаар олон тоогоороо, удаан хугацаанд, зарим тохиолдолд нүд хальтрам нөхцөлд хоригдсоор байна.

ЭРҮҮ ШҮҮЛТ БА БУСАД ХЭЛБЭРИЙН ХЭРЦГИЙ ШИЙТГЭЛ

12-р сард АНУ-ын Сенатын Тагнуулын асуудлаархи Тусгай хорооноос (СТТХ) Тагнуулын төв газрын (ТТГ) цагдан хорих хөтөлбөрийн талаар гаргасан тайлан нь зөвхөн хүний эрхийн зөрчлийн талаар цочирдмоор баримтуудаас гадна Европын улсууд түүнд хэрхэн хамтран оролцсон талаар дэлгэрэнгүй мэдээллийг ил болгосон билээ. Польш, Литва, Румын гэх мэт хэд хэдэн улс нууц хорих газар нутагтаа ажиллуулж байснаас гадна Их Британи, Швед, Македони, Итали зэрэг улс АНУ-ын засгийн газрын олон арван хоригдлыг хууль бусаар шилжүүлэх, хүчээр сураггүй болгох, эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий харьцаж шийтгэх үйл ажиллагаанд

нь бусад хэлбэрээр тусалж байсан ажээ. Эдгээр улсын алинд нь ч энэ хэрэг явдалд буруутай нэг ч хүнд одоогоор хариуцлага тооцоогүй байна. Хэдийгээр Польш, Литва, Их Британи зэрэг улсын хохирогчдын шүүхэд гаргасан гомдлын хувьд зарим нэг эерэг өөрчлөлт гарч байгаа ч (7-р сард Европын Хүний эрхийн шүүх Польшийн засгийн газар 2002-2005 оны хооронд ТТГ-тай хуйвалдан тус улсад нууц шорон байгуулсан болохыг тогтоосон), асуудлаас зайлсхийх, үгүйсгэх, сунжруулах замаар хариуцлагаас зугтсаар байна.

6-р сард Ирландын телевизийн RTI суваг 1971-1972 онд Умард Ирландад Их Британий аюулаас хамгаалах хүчнийхний хэрэглэж байсан 5 төрлийн эрүү шүүлтийн техникийг Их Британий засгийн газар мэдэж байсан тухай өмнө нь нийтэд ил болоогүй баримтыг дэлгэсэн. Тэдгээр арга техник нь 30 жилийн дараа ТТГ-ын хэрэглэсэн арга техниктэй ихээхэн төстэй байв. Европын Хүний эрхийн шүүх түүнээс өмнө Ирландын засгийн газрын Их Британий эсрэг гаргасан гомдлын үндсэн дээр эрүү шүүлт бус харин хэрцгий байдлаар харьцаж шийтгэсэн тохиолдол байжээ гэсэн шийдвэр гаргаад байсан юм. 12-р сард Ирландын Засгийн газар Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрийг давж заалдана гэдгээ мэдэгдсэн.

Хуучин ЗХУ-ын нутаг дэвсгэрт эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгий шийтгэл газар сайгүй тархсан. Терроризмтай холбоотой хэрэгт буруутгагдсан буюу Исламын бүлэглэлд харьяалагддаг хэмээн сэжиглэгдсэн хүмүүс ОХУ ба Төв Азийн орнуудын аюулаас хамгаалах хүчнийхний гарт эрүү

шүүлтэд өртөх магадлал илүү өндөр байгаагаас гадна тус бүс нутгийн авлигад идэгдсэн, хяналт султай хууль сахиулагчид мэдүүлэг болон хээл хахууль авахын тулд эрүү шүүлт тулгах буюу бусад хэлбэрээр хэрцгий харьцаж шийтгэх явдал түгээмэл байна. Үр дүнтэй, хараат бус мөрдөн шалгах ажиллагаа явагдаггүйн улмаас тийм зөрчил гаргасан хүмүүс ял завших үзэгдэл ердийн зүйл болжээ.

Турк улсад жагсаал цуглааныг цагдаагийн хүч хэрэглэн тараах явдал хэвийн зүйл болсон хэдий ч хорих газарт эрүү шүүлт тулгах явдал буурах хандлагатай байна. 2013 онд Гези цэцэрлэгт хүрээлэнд болсон жагсаал цуглааныг тараахдаа цагдаа хүч хэтрүүлэн хэрэглэсний улмаас алагдсан 10 гаруй хүн, хүндээр шархадсан олон зуун хүний хохирлыг барагдуулж, шударга үнэнийг тогтоохыг нэг бол үгүйсгэж, нэг бол хойшлуулсаар байна.

Грек, Испани улсын хууль сахиулагчид жагсаал цуглааныг хүч хэрэглэн тараасаар байгаа бөгөөд үүнийхээ төлөө ямар ч хариуцлага хүлээдэггүй нь байдлыг улам өөгшүүлж байна.

Жагсаал цуглаантай холбоотой хүний эрхийн хамгийн ноцтой зөрчил Украин улсын Киев хотод Евромайданы хөдөлгөөний үеэр болон түүний цус урсгасан төгсгөлөөр гарсан билээ. Хүчирхийллийн улмаас дор хаяж 85 жагсагч, 18 цагдаагийн ажилтан амиа алдсан бөгөөд шархадсан хүмүүсийн талаар тодорхой тоо баримт байхгүй. 2013 оны 11-р сарын 30-нд тайван жагсагчдын эсрэг цагдаа анхлан хүч хэрэглэснээс хойш хүч хэтрүүлэн хэрэглэх, дур зоргоор баривчлах, жагсагчдын эсрэг

эрүүгийн хэрэг үүсгэх явдал 2014 оны эхний саруудад шил дараалан гарсан юм. 2-р сарын сүүлчээр байлдааны сумтай галт зэвсэг, түүний дотор мэргэн буудагчдын урт буу зэргийг тараасан бөгөөд гэхдээ аль анги салбар тэдгээрийг хэрэглэсэн болон хэний тушаалаар энэ бүхэн хийгдсэн нь тодорхойгүй хэвээр байна. Жагсаал цуглааны үеэр Евромайданы хэдэн арван идэвхитнүүд сураггүй алга болсон. Тэдний заримыг хулгайлж, эрүүдэн шүүсний эцэст суллан явуулсан боловч оны эцсийн байдлаар 20 орчим хүний хувь заяа хэрхсэн нь тодорхойгүй байв.

Украины ерөнхийлөгч Виктор Янукович албан тушаалаасаа огцорсны дараа шинэ эрх баригчид Евромайданы хөдөлгөөний үеэр гарсан аллага, хүний эрхийн зөрчилд буруутай этгээдүүдийг үр дүнтэй мөрдөн шалгаж, зохих ял шийтгэл оноох болно гэдгээ олон нийтэд амалсан. Гэвч хуучин засгийн улс төрийн зарим удирдагчдад ял оноосныг эс тооцвол энэ чиглэлд тодорхой алхам хийгдсэнгүй. Оны эцсийн байдлаар Евромайдантай холбоотой хэргээр цөөн хэдэн бага тушаалын хууль сахиулах ажилтнуудад ял оноогоод байв.

ЦААЗААР АВАХ ЯЛ

Беларус улсад дор хаяж 3 хүнийг цаазаар авсан бөгөөд тус улс цаазаар авах ялыг практикт хэрэглэдэг цорын ганц улс болоод байна. Тэдгээр 3 хүнийг НҮБ-ын Хүний эрхийн хорооноос ирүүлсэн тэдний хэргийг нягтлан үзэх хүртэл цаазаар авахыг түр зуур хойшлуулах хүсэлтийг эс харгалзан цаазалсан юм.

ШИЛЖИЛТИЙН ШУДАРГА ЁС

Хуучин Югославын асуудлаархи олон улсын эрүүгийн шүүхэд Боснийн Сербийн удирдагч асан Радован Каражич болон генерал Ратко Младич нарын хэргийг үргэлжлүүлэн шүүж байгаа бөгөөд уг шүүхээр шийдүүлэхээр үлдсэн цөөн хэдэн хэргийг шийдэх ажил алгуур урагшилсаар байна. Үндэсний төвшинд хуучин Югославт болж өнгөрсөн хямрал мөргөлдөөний үед үйлдэгдсэн дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хариуцлага тооцох ажил хэт удаашралтай байна. Шинээр хэрэгт холбогдуулан шалгах хүний тоо цөөн, шүүх хурал хэт сунжирч, дайны гэмт хэргийн шүүхийн эсрэг улс төрийн дайралт үргэлжилсээр байна. Дайны гэмт хэргийн шүүхүүд, прокурорын газрууд болон мөрдөн шалгах хэлтсүүдэд хүн хүч, санхүүжилт хүрэлцэхгүй байгаа нь шударга ёсыг тогтоох улс төрийн хүсэл эрмэлзэл цаашаа явах гэсэн хүслийн ард нуугдаж байгааг илтгэж байна.

Бүс нутаг даяар дайнаас хохирсон энгийн иргэд, түүний дотор бэлгийн хүчирхийллийн хохирогчдод нөхөн төлбөр олгохгүй байгаа нь тэдний статус болон эрхийг нь баталгаажуулсан цогц хууль тогтоомж батлан гаргаж чадаагүйтэй холбоотой. 9-р сард Хорват, Серби, Босни Герцоговин зэрэг улс хямралаас хойш сураггүй хэвээр байгаа олон мянган хүний хувь заяаг тодруулж, шарилыг нь буцаан өгөх талаар өнөөг хүртэл удаашралтай байгаа ажлыг эрчимжүүлэх асуудлаар бүс нутгийн хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зурсан. Сураггүй алга болсон хүмүүсийн талаар хууль

тогтоомж байхгүйн улмаас дээрхи 3 улсад амьдарч байгаа тэдгээр хүмүүсийн төрөл төрөгсдийн эрх, амь амжиргаа хохирсоор байна.

Умард Ирландад хямрал мөргөлдөөнтэй холбоотой хүний эрхийн зөрчлийн асуудлыг хариуцуулахаар байгуулсан буюу бүрэн эрх олгосон механизм болон байгууллагууд өөр хоорондоо уялдаа холбоогүй, хангалтгүй ажиллаж байна. 2006 онд хямрал мөргөлдөөнтэй холбоотой бүх үхлийг эргэн шалгах зорилготой Түүхэн асуудлыг тодруулах баг байгуулсан боловч өргөн хүрээтэй шүүмжлэлийн улмаас татан буугдсан. Уг багийн зарим ажлыг Умард Ирландын Цагдаагийн албаны шинээр байгуулагдах нэгжид шилжүүлэхээр төлөвлөсөн нь цаашдын хэргийг хараат бусаар шалгаж чадах эсэх талаар эргэлзээ төрүүлсэн юм. 2014 оны 12-р сард Умард Ирландын томоохон намууд нэг жилийн өмнө АНУ-ын дипломат Ричард Хаасын санал болгосон хоёр шинэ механизм буюу Түүхэн Мөрдөн шалгах ажиллагааны хэлтэс болон Мэдээлэл цуглуулах хараат бус комисс зэргийг байгуулахыг зарчмын хувьд зөвшөөрсөн. Гэвч тэдгээрийн санхүүжилт, байгуулах хугацаа болон хууль тогтоомжийн асуудал одоогоор шийдэгдээгүй хэвээр байна.

ТЕРРОРИЗМЫН ЭСРЭГ ТЭМЦЭЛ БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ

2013 онд Эдвард Сноуден АНУ-ын нууцаар хянах хөтөлбөрийн цар хүрээ ямар болохыг нийтэд дэлгэсэнтэй холбогдуулан олон нийтийн зохион байгуулсан жагсаал цуглаануудыг эс харгалзан тус бүс нутгийн бүх засгийн газар

интернэтэд суурилсан харилцаа холбоог ямар хүрээнд нууцаар хянаж байгаа талаар амаа үдүүлсэн мэт дуугүй байсаар байна.

Их Британи улсад Эмнести Интернэшнл болон бусад ТББ-ын нэхэмжлэгчид Их Британий нууцаар хянах тогтолцоо хүний эрхэд нийцэж байгаа эсэхийг шалгуулахаар шүүхэд өгсөн боловч амжилт олоогүй бөгөөд одоо Страсбургийн шүүхэд давж заалдахаар болоод байна.

ЕХ-ны улсууд бусад улс орны үндэсний аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй хувь хүмүүсийг эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгий шийтгэлд өртөж болзошгүй улс руу буцаахгүй байх талаар найдвартай бус дипломат баталгааг хэрэглэсээр байна. Энэ практик ОХУ-д ихээхэн дэлгэрсэн бөгөөд эрэн сурвалжлагдаж байгаа хүмүүсийг Төв Ази руу албадан гаргах явдлыг хориглосон Европын Хүний эрхийн шүүхийн удаа дараагийн шийдвэрийг тойрч гарахыг оролдсон. Хуучин ЗХУ-ын нутаг дэвсгэрт хамтран ажиллаж байгаа улс орнууд хууль ёсоор болон нууцаар өөр улсад террорист хэрэгт сэжиглэгдсэн хүмүүсийг эрүү шүүлтэд өртөх өндөр магадлалтай улс руу шилжүүлэн өгөх нь түгээмэл байна.

Умард Кавказ дахь аюулгүй байдлын нөхцөл байдал тогтворгүй хэвээр байгаа ба аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үеэр хүний эрхийг ноцтой зөрчих явдал хэвийн зүйл болжээ. Хууль сахиулагчид хүний эрхийг хэрхэн зөрчдөг нь 12-р сар Грозный хотод болсон өргөн хэмжээтэй хадлага үйлдэгчдийн гэр бүлийнхний эсрэг арга хэмжээ авна хэмээн Чечений удирдагч Рамзан Кадыров

мэдэгдсэний дараа түүнд үнэнч хүчнийхэн хэд хэдэн байшиг галдан шатааснаар тод илэрсэн. Турк улсад терроризмын эсрэг хэт өргөн хүрээтэй хууль тогтоомжийг үзэл бодлоо илэрхийлэх хууль ёсны эрх чөлөөгөө эдлэхийг хүссэн хүмүүсийг шүүхэд хэрэглэсээр байна. Гэхдээ урьдчилан хорих дээд хугацаанд шинэ хязгаар тавьснаар олон хүн суллагдсаныг дурдах ёстой.

АЛАГЧЛАЛ

Алагчлал тус бүс нутгийг олон сая хүний амьдралд нөлөөлсөөр байна. Эртнээс нааш хүмүүсийн хэл амны бай болсоор ирсэн хүмүүс, цыганчууд, исламын шашинтнууд цагаачид алагчлалд хамгийн их өртөж байгаа боловч мөн еврейн эсрэг үзэл өргөн тархсан хэвээр бөгөөд үе үе хүч хэрэглэсэн дайралтаар илэрч байна. Лесби, гей, бисексуаль, трансгендер болон интерсекс (ЛГБТИ) хүмүүсийн эрхийн хувьд дэвшил ба ухралтын аль аль нь гарлаа.

Улс төрийн тунхаглал, үйл ажиллагааны төлөвлөгөө, үндэсний стратеги зэрэг нь шоовдорлогдон гадуурхагдсан сая сая цыганчуудын амьдралд ямар ч нөлөө үзүүлж чадахгүй байна. Учир нь тэдгээр баримт бичгүүдийг бодитоор хэрэгжүүлэх улс төрийн хүсэл эрмэлзэл байхгүй байгаагаас гадна цыганчуудыг нийгмээс гадуурхаж байгаа гол шалтгаан болох арьс өнгөний үзэл, үзэн ядалт зэргийг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг тусгаж чадаагүй.

Тийм ч учраас, цыганчуудыг орон байр болон ажлын байраар хангах, боловсрол эзэмших зэрэгт алагчлах явдал өргөн тархсан. Зөвшөөрөлгүй газарт амьдарч байгаа олон зуун

мянган цыганчууд тэдний нөхцөл байдлыг огтхон ч харгалзан үзээгүй, тэдний хувьд биелүүлэх боломжгүй шаардлагуудаас болоод нийгмийн халамжийн байранд орж чаддаггүй. Тэдний амьдардаг албан бус суурингийн аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх талаар гаргасан парламентийн санал санаачлага олон оронд ихээхэн маргаан дагуулсан бөгөөд алинд нь ч батлагдаж чадаагүй. Тиймээс Европ даяар албан бус сууринд амьдарч байгаа хүмүүст албадан нүүлгэлтийн аюул заналхийлсээр байна.

Цыганчуудыг боловсролын байгууллагад тусгаарлан сургах явдал Төв болон Зүүн Европт ихээхэн дэлгэрсэн бөгөөд ялангуяа, Словак, Чех улсын эрх баригчдын энэ асуудлыг шийднэ гэсэн амлалтыг эс харгалзан хэрэглэгдсээр байна. Нэг эерэг алхам хийгдсэн нь ЕХ Чех улсын эсрэг ЕХ-ны алагчлалын эсрэг хууль тогтоомжийг (Арьс өнгөний тэгш байдлын тухай захирамж) зөрчин цыганчуудыг боловсролын салбарт алагчилж байгаа зөрчлийг шалгах ажилагаа эхлүүлээд байна. Итали болон нэр нь тодорхойгүй байгаа ЕХ-ны гишүүн бусад хэд хэдэн оронд ЕХ-ны Комисс Арьс өнгөний тэгш байдлын тухай захирамжийг зөрчин, цыганчуудыг өргөн хүрээнд алагчилсан байж болзошгүй хэмээн шалгалт явуулсан нь ЕХ-ны зүгээс үгүй ядаж 10 жилийн өмнө батласан хууль тогтоомжоо хэрэгжүүлэх эрмэлзэлтэй байгаагаа харуулав.

7-р сард Европын хүний эрхийн шүүх Франц улс олон нийтийн газарт нүүрээ бүхэлд нь битүүлэн хаахыг хориглосон шийдвэр гаргасан нь Европын Хүний эрхийн конвенцийн зүйл заалтыг

зөрчөөгүй болохыг тогтоосон нь дээрхи шийдвэр илэрхий нүүрний гивлүүрний эсрэг чиглэсэн бөгөөд гивлүүр зүүхийг сонгосон исламын шашинт эмэгтэйчүүдийн үзэл бодлоо илэрхийлэх, шашин шүтэх, алагчлалаас ангид байх эрх чөлөөг хязгаарласан явдал болсныг харгалзан үзээгүй. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө сөрөг үр дагавар авчирч болох энэхүү хязгаарлалтыг Европын шүүх “хамтдаа амьдрах” гэсэн туйлын бүрхэг шаардлагыг иш татан зөвтгөсөн юм.

Цыганчууд, исламын шашинтнууд, еврейчүүд, цагаачид болон ЛГБТИ хүмүүсийг онцгойлон чиглэсэн үзэн ядалтын ноцтой гэмт хэргүүд Европ тив даяар үргэлжилсээр байна. Хэд хэдэн улсад, түүний дотор ЕХ-ны гишүүн улс орнуудад үзэн ядах гэмт хэргийн тухай хууль тогтоомжид бэлгийн чиг баримжаа болон хүйсийн тодорхойлох шинж зэргийг хориглох үндэслэл болгон оруулаагүй. Бүс нутаг даяар үзэн ядах гэмт хэргийн талаар цагдаад хандах нь бага, тэдгээрийг мөрдөн шалгах ажиллагаа сул хэвээр байна. Дангаар үйлдэгдсэн үзэн ядах гэмт хэрэг болон Эрүүгийн хуулийн алагчлах сэдлийг хүндрүүлсэн нөхцөл байдал хэмээн үзэж илүү чанга ял оноох заалтыг ихэнхидээ ашиглахгүй байгаа нь мөрдөн байцаагчид алагчлах сэдэл байсан эсэхийг тогтоодоггүй, прокурорууд гэмт этгээдүүдэд зохих ялыг нь оноодоггүй, эсхүл холбогдох нотлогдох баримтыг шүүхэд танилцуулдаггүйтэй холбоотой.

Ижил хүйсийн хамтран амьдрагчдад тэгш эрх олгодог (гэхдээ үрчлэлтийн хувьд бол тун цөөхөн улсад) орнуудын тоо

нэмэгдсээр байгаа бөгөөд ЕХ-ны хяналтын дор Серби болон Монтенегро улсад Бэлгийн цөөнхийн Бахархлын жагсаал амжилттай бөгөөд аюулгүй зохион байгуулагдав. Гомосекс хүмүүсийг үзэн ядах үзэл өргөн тархсан хэвээр бөгөөд Өрнөдийн орнуудад тэдэнд илүү нааштай хандахын хэрээр Дорнын орнуудад ЛГБТИ хүмүүсийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласаар байна. ОХУ орон нутгийн эрх баригчидтай хамтран насанд хүрээгүй хүүхдүүдэд ижил хүйстний харилцааг сурталчахыг хориглосон хууль тогтоомжийг иш үндэс болгон ЛГБТИ идэвхитнүүдийг олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг байнга хориглодог. Литва улсад түүнтэй төстэй хууль тогтоомжийг хүүхдийн үлгэр, ижил хүйсийн харилцааг өгүүлсэн үлгэрийг хориглоход ашигласан. Киргизстан улсын парламент “уламжлалт бус бэлгийн харилцаа”-г хориглох тухай хууль тогтоомжийг хэлэлцсэн. ЛГБТИ хүмүүс, байгууллага, үйл ажиллагааны эсрэг дайралт Зүүн Европ ба Балканы орнуудад түгээмэл гардаг бөгөөд эрүүгийн шүүхийн тогтолцоо нь тэдгээр хэрэгт үл тоомсорлон хандаж, зохих арга хэмжээ авах нь ховор байдаг.

ОХИД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ

Хүйсэд суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэл бүс нутаг даяар өргөн тархсан хэвээр байна. ЕХ-ны Үндсэн эрхийн агентлагаас 3-р сард гаргасан тайланд ЕХ-ны гурван эмэгтэй тумын нэг нь 15 настайгаасаа хойш бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртдөг хэмээн дурдсан. Европын

зөвлөлийн охид эмэгтэйчүүд эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлээс урьдчилж сэргийлэх, тэмцэх тухай конвенци батлагдсан нь цагаа олсон хэрэг байсан боловч оны эцсийн байдлаар ердөө 15 улс уг конвенцийг соёрхон батлаад байв.

Хэдийгээр эерэг өөрчлөлт гарч байгаа ч тус тив даяар эрүүгийн шүүхийн болон хамгаалалтын тогтолцоо гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохиогчдын эрхийг муу хамгаалж байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохиогчдод зориулсан хамгаалах байр хангалтгүй, мөрдөн шалгах ажиллагааг хэрэгсэхгүй болгох тохиолдол түгээмэл зэрэг нь бүс нутаг даяар тулгарч буй нийтлэг бэрхшээл юм.

БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ БА НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ

Мальта улсад ямар ч тохиолдолд үр хөндөлтийг хуулиар хориглосон хэвээр байна. Ирланд ба Польш улсын аль аль нь Европын Хүний эрхийн шүүхээс 2010 ба 2012 онд тус тус гаргасан тодорхой тохиолдолд эмэгтэйчүүдэд үр хөндөлт хийлгэх эрхийг баталгаажуулах тухай шийдвэрийг бүрэн дүүрэн хэрэгжүүлээгүй. Хэдий тийм боловч Сайд нарын хороо Ирландын хувьд шүүхийн шийдвэрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих ажлаа зогсоохоор шийдсэн.

ОЙРХИ ДОРНОД БА ХОЙД АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

2014 оныг эргэн харвал Ойрхи Дорнод ба Хойд Африкийн сая сая хүмүүсийн хувьд гамшиг нүүрлэсэн

жил болсон бөгөөд Сири, Иракт зэвсэгт мөргөлдөөн үргэлжилж, хүний эрхийг аймшигтайгаар зөрчиж, Газын зурвасын энгийн номхон иргэд Израйль ба Хамасын хооронд явагдаж буй амь өрссөн тулааны галд өртөж, Ливи улс улам бүр иргэний дайнд нэрвэгдэж сүйрсэн улс болоход ойрхон болжээ. Йемений нийгэм ч мөн маш хуваагдмал байдалтай байгаа ба тус улсын төв засгийн газар нутгийн хойд хэсэгт шийтийн босогчидтой, өмнөд хэсэгт салан тусгаарлагчидтай, баруун урд хэсэгт босогчидтой үргэлжлүүлэн тэмцэж байна.

2011 онд Арабын ертөнцийг донсолгосон дуулиант бослого гарахад хүргэсэн өөрчлөлтийн төлөөх итгэл найдвар хийгээд Тунис, Ливи, Йемен, Египетийн он удаан жил эрх барьсан удирдагчдыг түлхэн унагасан явдал мартагдсан дурсамж шиг санагдах болжээ. Гэхдээ Тунисийг эс тооцож болох юм. Учир нь 11-р сард Тунист парламентийн шинэ сонгууль амжилттай явагдсан бөгөөд эрх баригчид хүний эрхийн зөрчилд хариуцлага хүлээлгэх талаар дор хаяж зарим алхмыг хийсэн. Харин Египетэд өөдрөг зүйл бага байна. 2013 онд бослогын даарахи анхны ерөнхийлөгчийг суудлаас нь зайлуулах ажлыг гардан удирдсан цэргийн генерал сонгуулийн дараа өөрөө ерөнхийлөгчийн суудалд суусан бөгөөд зөвхөн Исламын Ахан дүүс болон тэдний холбоотнууд төдийгүй бусад олон нам хүчний улс төрийн идэвхитнүүд, хүний эрхийг хамгаалагчид болон хэвлэл мэдээллийн ажилтнуудыг хэлмэгдүүлж, мянга мянган хүнийг шоронд хорьж, олон зуун хүнийг

цаазаар авах ялаар шийтгэж байна. Персийн булангийн Бахрайн, Саудын Араб болон Арабын Нэгдсэн Эмират улсын эрх баригчид өөрөөр сэтгэгчдийг нухчин дарах, эрх барьж байгаа хүчнийг сөрөх хүчний аливаа шинж тэмдгийг тэр дор нь арчиж хаях хүчин чармайлтаа ердөө ч сааруулахгүй байгаа бөгөөд Өрнөдийн ардчилсан орнууд дахь холбоотнууд нь тэднийг огтхон ч эсэргүүцэхгүй гэдэгт итгэлтэй байгаа юм.

Түүнээс гадна 2014 он бол Сири болон Ирак дахь зэвсэгт мөргөлдөөнд оролцож буй зэвсэгт бүлэглэлүүд, тэр дундаа Исламын Улс хэмээх бүлэглэл хүний ёсноос ангид олон харгислал үйлдсэн жил байв. Сири улсад Исламын Улс бүлэглэлийн болон бусад зэвсэгт бүлэглэлийн дайчид тус улсын томоохон нутаг дэвсгэр, түүний дотор хамгийн том хот болох Алеппо эзлэн, хяналтдаа авсан бөгөөд исламын шашны хууль зөрчсөн хүмүүсийг нийтийн өмнө цаазлах, гар хөлийг нь тайрах, ташуурдах гэх мэт “шийтгэл” оногдуулах боллоо. Исламын Улс бүлэглэл мөн Ирак дахь суннит урсгалынхны гол нутагт нөлөөгөө нэмэгдүүлж, айдас хүйдэст автуулж байгаа бөгөөд засгийн газрын олзлогдсон цэргүүд, цөөнхийн бүлгийнхэн, шийт урсгалыг дэмжигч омгийнхон болон тэдэнд эсэргүүцэл үзүүлсэн суннит овгийнхон зэрэг олон зуун хүнийг цаазалсан. Түүнчлэн Исламын Улс бүлэглэл шашны болон угсаатны цөөнхийн эсрэг овоо хараагаа онилж, христийн шашинтнуудыг нутгаас нь хөөж, олон мянган езидис болон бусад цөөнхийн бүлгүүдийг төрсөн нутаг, орон гэрээс нь хүч

хэрэглэн хөөж байна. Исламын улс бүлэглэлийн цэргүүд езиди овгийн эрчүүд, хөвгүүдийг цаазаар аваачих хэлбэрээр буудан хороож, олон зуун охид эмэгтэйчүүдийг хулгайлан боолчилж, өөрсдийн “эхнэр” болохыг албаддаг. Тус бүлэглэлд Европ, Хойд Америк, Австрали, Хойд Африк, Булангийн орнууд болон бусад газраас ирсэн олон мянган сайн дурын цэргүүд багтдагийг дурдах ёстой.

Хууль бус аллагыг бусдын нүднээс далд үйлдэхийг хичээдэг хүмүүсээс ялгаатай нь Исламын улс өөрийнхөө үйлдлүүдийг ичих нүүргүйгээр хэрцгийгээр дэлгэн үзүүлдэг. Сэтгүүлчид, хүмүүнлэгийн ажилтнууд, Ливи болон Иракийн олзлогдсон цэргүүдийн толгойг авах зэрэг өөрсдийн хамгийн бузар үйлдлээ ч хальсан дээр буулгах зорилгоор тэд зураглаачаа бэлэн байлгадаг. Ингээд сэтгэл ээртхийлгэсэн тэдгээр бичлэгээ интернетэд тавиан суртал ухуулга, барьцааны хүн солилцох, шинээр хүн элсүүлэх арга хэрэгсэл болгон ашигладаг юм. Сири ба Ирак дахь Исламын улс бүлэглэлийн хурдацтай давшилт болон Өрнөдийн барьцааны хүмүүсийг цаазалсан явдал зэрэг нь 9-р сард АНУ-ыг Бахрейн, Йордан, Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират улс зэрэг 60 гаруй улс орныг эгнээндээ нэгтгэсэн Исламын улсын эсрэг эвсэл байгуулахад хүргэлээ. Тус эвслийн хүчнийхэн Исламын улс бүлэглэлийн хэд хэдэн байршил болон улс бус зэвсэгт бүлэглэлүүдэд агаараас цохилт өгсний улмаас энгийн номхон иргэд амь насаа алдаж, шархадсан тохиолдол гарсан. Засгийн газрууд хийгээд улс бус зэвсэгт бүлэглэлүүдийн хоорондын тэмцэл үндэсний

хэмжээнээс хальж гарахын хэрээр АНУ-ын цэргийн хүч Йемен дэх Ал-Кайдагийн хамсаатнуудын эсрэг дроны болон бусад дайралтыг хийж байна. Түүний зэрэгцээ ОХУ НҮБ-д Сирийн засгийн газрын талд бат зогссоор байгаа бөгөөд Сирийн эрх баригчдын үйлдсэн дайны гэмт хэрэг болон хүний эрхийн бусад ноцтой зөрчлүүдийг үл харгалзан дайны хүчин чмармалтыг нь дэмжин зэр зэвсэг, сум хэрэгслээр хангасаар байна.

Исламын улсын харгислал, сурталчилгаа болон тэдгээрээс үүдсэн улс төрийн хямралт байдал хэсэг хугацааны турш Сирийн засгийн газар хяналтдаа байгаа нутаг дэвсгэрээ алдахгүйн тулд эсхүл зэвсэгт бүлэглэлийн хяналтад байгаа газрыг буцаан авахын тулд байлдааны ажиллагаа явуулахдаа энгийн номхон иргэдийн амь насыг огтхон ч хайхралгүй, олон улсын хүмүүнлэгийн эрхзүйгээр хүлээсэн үүргээ үл хүндэтгэж байгааг бүрхэгдүүлсэн юм. Засгийн газрын цэргүүд энгийн иргэд хорогдож байгаа газрууд руу тэсрэх бөмбөг, танк, их буу зэрэг хүнд зэвсэг ашиглан дайралт хийж, энгийн номхон иргэдийг хоол хүнс, ус, эм тариа авах эрхийг боогдуулан урт хугацаагаар бүслэлтэд оруулж, эмнэлэг, эмнэлгийн ажилчид руу дайралт хийсээр байна. Тэд мөн сөрөг хүчнийг гэж сэжиглэгдсэн олон хүнийг баривчлан нүд хальтирмаар нөхцөлд хорьж, эрүүдэн шүүж, хууль бус аллага үйлдсээр байна.

Ирак улсын засгийн газар Исламын Улс бүлэглэлийн давшилтын хариу болгож аюулаас хамгаалах хүчнээ засгийн газрын талыг дэмжигч шийт урсгалын дайчдаар бэхжүүлж, тэднийг

засгийн газрын эсрэг, Исламын улс бүлэглэлд талтай ханддаг хэмээн буруутгагддаг суннитуудын эсрэг хяналтгүй тавьсан. Түүнчлэн Мосул болон Исламын Улсын хяналтад байгаа бусад төвүүд рүү агаарын дайралт хийсэн юм.

Өнөөгийн дийлэнхи хямрал мөргөлдөөнийг нэгэн адил дайтагч талууд энгийн иргэдийн амь насыг хэлтрүүлэх үүргээ үл ойшоодгийн улмаас тэд хамгийн хүнд хохирол амссаар байна. Израйль болон Хамас, түүнчлэн Газын зурвас дахь Палестины зэвсэгт бүлгийн хоорондох 50 хоногийн мөргөлдөөний үеэр Палестины энгийн иргэд, орон гэр, дэд бүтцэд учирсан сүйрэл, хохирол, үхэл хагацал, гэмтэл бэртлийн цар хэмжээ нүд хальтрам байв. Израйлийн арми хүн ам суурьшсан газрууд руу довтолж, зарим тохиолдолд бүхэл бүтэн гэр бүлийг хүйс тэмтрэн, эмнэлэг, сургууль руу дайралт хийж байв. Иргэдийн орон гэр болон дэд бүтцийг санаатайгаар устгаж байв. Газын зурваст 2000 гаруй энгийн иргэд амиа алдсаны 1500 гаруй нь палестинчууд, түүний дотор 500 гаруй нь хүүхэд байсан ажээ. Хамас болон Палестины зэвсэгт бүлэглэлүүд Израйлын энгийн иргэд суурьшсан бүс рүү олон мянган пуужин харваснаас болж 6 энгийн иргэн амь насаа алдсан бөгөөд тэдний дотор 1 хүүхэд байжээ. Хамасын зэвсэгт дайчид Палестин иргэдийг шоронгоос нь гаргасны дараа Израйльтай хамтран ажилласан гэж буруутгаж 23 хүний амийг хороосны дотор хэрэг нь шүүхээр шийдэгдээгүй хүмүүс ч байв. Мөргөлдөөний үеэр хоёр талын аль аль нь дайны гэмт хэрэг, хүний эрхийн ноцтой зөрчил үйлдсэн ч

ямар нэг ял шийтгэл хүлээгээгүй нь өнгөрсөн жилүүдийн танил дүр зургийг санагдуулав. Израйль улс 2007 оноос хойш Газын зурвасыг агаар, далай, газраар хаасан хэвээр байгаа нь 50 өдрийн мөргөлдөөний үр дагаврыг улам ч хүндрүүлж, сэргээн босгох үйл ажиллагаанд ихээхэн саад тотгор учруулсан нь Газын 1,8 сая хүний эрхийг зөрчин нийтээр нь шийтгэж байгаа олон улсын эрх зүйгээр гэмт хэрэгт тооцогдох зүйл байв.

2014 онд Ойрхи дорнод ба Хойд Африкт өрнөсөн улс төрийн болон бусад хурцадмал байдал зэвсэгт мөргөлдөөнд нэрвэгдсэн улс орнуудад хамгийн тодоор илэрсэн боловч энэ бүс нутаг даяар тэдгээр хурцадмал байдлыг дэвэргэх тогтолцооны болон бусад сул тал оршсоор байна. Үүнд засгийн газрууд хийгээд улс бус зэвсэгт бүлэглэлийн аль аль нь шүүмжлэл болоод өөрөөр сэтгэгчдийг хүлцэн тэвчих хандлагаар дутмаг, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үйлдсэн зөрчлийг хянах буюу тэнцвэрийг хангах хууль тогтоох байгууллага байхгүй буюу маш сул, шүүхийн хараат бус байдал хангагдаагүй, эрүүгийн шүүхийн тогтолцоо гүйцэтгэх эрх мэдэлд үйлчилдэг, хариуцлага хүлээлгэх тогтолцоо байхгүй, түүний дотор олон улсын эрх зүйгээр хүлээсэн үүргээ биелүүлдэггүй зэргийг дурдаж болно.

ӨӨРӨӨР СЭТГЭГЧДИЙГ НУХЧИН ДАРЖ БАЙГАА НЬ

Тус бүс нутагт засгийн газрууд өөрөөр сэтгэгчдийг нухчин дарж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, түүний дотор нийгмийн сүлжээгээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хумьж байна. Төр,

засгийн тэргүүн, засгийн газрын болон шүүхийн албан тушаалтан, тэр ч байтугай гадаадын засгийн газрын удирдагчдыг доромжилсон гэж тооцогдохоор хэлбэрээр үзэл бодлоо илэрхийлэх явдлыг гэмт хэрэгт тооцох хууль тогтоомж Бахрейн, Египет, Йордан, Кувейт, Марокко, Оман, Саудын Араб зэрэг улсад мөрдөгдөж байна. Тухайлбал, Бахрейн улсад нэгэн алдартай идэвхитэн эмэгтэйд эзэн хааны зургийг урсан гэх шалтгаанаар 3 жил хорих ял оноосон юм. Иран улсад эрх баригчдыг шүүмжлэгчид *moharebeh* буюу "Бурханы эсрэг тэрс үзэлтэн" хэмээх цаазын ялтай хэргээр шүүгдэх аюултай тулгардаг. Арабын Нэгдсэн Эмират улсад эрх баригчид шинэчлэлийг дэмжигч идэвхитнүүдийн хэргийг шударга бус шүүхээр шүүж, урт хугацаагаар хорих ял оноосоор байгаа бөгөөд терроризмын эсрэг хэт өргөн хүрээтэй шинэ хууль баталсан нь тайван жагсаал цуглааныг цаазын ял авч болох террорист үйлдэлтэй адилтгахад хүргээд байна.

АНЭУ-ын болон Булангийн Бахрейн, Кувейт, Оман зэрэг зарим орон тайван замаар дэглэмийг шүүмжлэгчдийг иргэний харьяаллыг нь цуцлах замаар шийтгэх болсон нь тэдний иргэний эрхийг үгүйсгэж, зарим тохиолдолд иргэний харьяалалгүй хүн болгож байгаа юм. Бахрейн, Кувейт, Арабын Нэгдсэн Эмират улс өнгөрсөн оны турш энэхүү эрх мэдлээ хэрэгжүүлсэн. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө улам бүр хумигдсаар байна. Олон орны засгийн газар хараат бус үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа бөгөөд

тэр дундаа Алжир, Марокко/ Баруун Сахарын эрх баригчид хүний эрхийн байгууллагууд болон хараат бус үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудыг хууль ёсоор үйл ажиллагаа явуулахын тулд албан ёсоор бүртгүүлэхийг шаардаж байгаа боловч тэднийг бүртгэхээс татгалзах юм уу өмнө нь бүртгүүлсэн байгууллагуудыг дарамтлах болсон. Тэр ч бүү хэл, Египетийн эрх баригчид хараат бус ТББ-уудын оршин тогтнолд заналхийлэх боллоо.

2011 онд тус бүс нутгийг донсолгосон үйл явдлын үеэр тодорхой илэрсэн тайван жагсаал, цуглаан хийх эрхийг 2014 онд олон засгийн газар ихээхэн хумилаа. Алжирийн эрх жагсаал, цуглаан хийх газар луу очих замыг хааж, идэвхтнүүдийг баривчлах замаар жагсаал цуглаанд саад хийж байна. Кувейтын эрх баригчид Бидуинчуудын жагсаал цуглааныг хориглодог хэвээр байгаа бөгөөд тэдний олонхид Кувейтын иргэний харьяалал олгохоос татгалздаг. Бахрейн, Египет болон Йемений аюулаас хамгаалах хүчнийхэн жагсагчдын эсрэг хүч хэтрүүлэн хэрэглэдэг бөгөөд шаардлагагүй байхад галт зэвсэг хэрэглэсний улмаас хүний амь хохироож, шархдуулж байна.

Израйлийн цэргүүд, Баруун эрэг дэх хилийн хамгаалагчид Израйлын суурингууд, хана зэрэг Израйлын цэргийн урт хугацаан булаан эзлэлтийн бэлэг тэмдэг болсон бусад зүйлсийг эсэргүүцсэн Палестины чулуу шидэгчид болон бусад жагсагчид руу гал нээсэн. Тодорхой бус хүмүүс хууль бус аллага үйлдэх явдал гарсаар байгаа хэдий ч түүний төлөө ямар ч хариуцлага хүлээхгүй байгаа

бөгөөд зарим үед тэд хүний эрх, хуулийн засаглалын төлөө дуугарсан хүмүүсийг онилж байна. Ливи улсад 2011 оны бослогын тэргүүлэх дуу хоолойн нэг байсан Салва Бугагис хэмээх хүний эрхийн хуульчийг хэвлэлд өгсөн ярилцлагадаа тус улсын хүчирхэг боловч хууль дүрэмгүй зэвсэгт бүлэглэлүүдийг шүүмжилсний дараахан зэвсэглэсэн эрчүүд гэрт нь буудаж хөнөөсөн.

ХУУЛЬ ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО

Дур мэдэн баривчлан хорих, шүүх хурал хийлгүйгээр удаан хугацаагаар цагдан хорих, хүчээр сураггүй алга болгох, шударга бус шүүх хурал, авлига зэрэг нь энэ бүс нутагт нийтлэг байгаа бөгөөд авлигад идэгдсэн эрүүгийн шүүхийн тогтолцоог эрх баригчид эсэргүүцлийг дарах хэрэгслээ болгон ашигладаг. Сири, Египет, Ирак, Саудын Араб зэрэг улсад мянга мянган иргэд шударга бусаар шүүгдэж, шоронд хоригдох буюу ямар нэг шүүхийн шийдвэргүйгээр хоригдож байна. Бахрейн, Иран, Арабын Нэгдсэн Эмират зэрэг улсад цөөн тооны хоригдол хоригдож байгаа бөгөөд хүчээр сураггүй алга болсон зарим тохиолдол гарсан. Израйлийн эрх баригчид шүүх хуралгүйгээр 500 гаруй палестин иргэнийг захиргааны журмаар цагдан хорьж байгаа бөгөөд Палестиний өөр олон мянган иргэн Израйлийн шоронд хоригдож байна. Баруун эрэг болон Газын зурвас дахь Палестины эрх баригчдын аль аль нь улс төрийн өрсөлдөгчдөө хорьсоор байгаа бөгөөд Израйльтай "хамтран ажилласан" гэсэн хэрэгт

буруутгагдсан хүмүүст цэргийн болон бусад шүүхээр цаазаар авах ял оноодог. Ливи улсад өрсөлдөгч цэргийн бүлэглэлүүд олон мянган хүнийг хорьж байгаагийн зарим нь Муамар аль-Каддафигийн дэглэм нурсан 2011 оноос хойш хоригдож байгаа бөгөөд тэдний олонхи нь туйлын хүнд нөхцөлд эрх суллагдах ямар ч найдваргүйгээр хоригдож байна. Бүс нутаг даяар шүүхийн зүгээс баттай нотлох баримтгүйгээр, эрүү шүүлтээр олж авсан мэдүүлгийн үндсэн дээр урт хугацаагаар хорих, зарим тохиолдолд цаазаар авах ял ноогдуулж байна. Тулгаж буй ял нь маш өргөн хүрээтэй, тун бүрхэг томъёологдсон байдаг тул ял сонсох нь бараг тодорхой байдаг. Египет улсад нэгэн шүүгч цагдаагийн газар руу дайрсан халдлагад буруутган 100 гаруй иргэнийг 2 удаагийн маргаантай шүүх хурлын дараа цаазаар авах ял урьдчилан оноосон бол өөр нэг шүүгч бодит баримт нотолгоогүйгээр олны танил 3 хэвлэл мэдээллийн ажилтанд урт хугацаагаар хорих ял оноосон. Түүнчлэн шинэ төрийн тэргүүн нь шударга бус гэдгээрээ алдартай цэргийн шүүхэд терроризм болон бусад хэргээр энгийн иргэдийн хэргийг шийдэх эрхийг өргөжүүлэн олгосон шийдвэр гаргав. Бахрейн болон Арабын Нэгдсэн Эмират улсад шүүхүүд аюулгүй байдалтай болон эрх мэдэлтнүүдийн эсрэг хэрэгт холбогдсон хүмүүсийн хэргийг шийдэхдээ эрх баригчдын талыг баримталдаг бөгөөд ойр дотны хүнээ шударга бусаар ялласан хэмээн үзэж суллахыг шаардсан кампанит ажил өрнүүлсэн гэр бүлийн гишүүдэд нь мөн хорих ял оноолоо. Ираны хувьсгалт шүүх

хүмүүст тодорхойлоход хэцүү хэрэг тулган хатуу ял, түүний дотор цаазаар авах оноох явдал гарсаар байна. Саудын Араб улсад хорих ял шийтгэгдсэн хүмүүсийн дотор аюулгүй байдалтай холбоотой шүүх хуралд яллагдагчийн өмгөөлөгчөөр оролцож, шүүхийн шударга бус байдлыг шүүмжилсэн хуульчид байна.

Саудын Араб, Иран, Ирак улс тус бүс нутагт цаазаар авсан ялтны тоогоор тэргүүлсэн хэвээр байгаа бөгөөд эдгээр улсад шударга бус шүүхээс ял сонссон маш олон хүнийг цаазалжээ. Саудын Араб улсад цаазлуулсан хүмүүсийн дотор олон хохирогч байсан ба зөвхөн 8-р сарын 26-нд нийтийн өмнө толгойгоо авахуулсан хүмүүсийн дотор илбэ жатгын хэргээр нэг хүн, хар тамхины хөнгөн хэргээр хэд хэдэн хүн цаазлуулсан. 6-р сард Египет улс 30 сар завсарласны эцэст магадгүй Исламын ахан дүүс бүлгийнхний давж заалдах бүх боломж дууссантай холбоотойгоор уг бүлгийн олон зуун дэмжигчид болон бусад хүмүүсийг цаазлав. Иордан улс мөн 8 жил завсарласны эцэст 12-р сард цаазын ялыг дахин сэргээжээ. Ливаны шүүх цаазаар авах ял оногдуулсан хэвээр байгаа ч Алжир, Марокко, Тунис зэрэг улсын эрх баригчдын нэгэн адил цаазын ял гүйцэтгэлийг де-факто байдлаар түдгэлзүүлсээр байна.

ЭРҮҮ ШҮҮЛТ БОЛОН БУСАД ХЭЛБЭРИЙН ХЭРЦГИЙ ШИЙТГЭЛ

Бүс нутгийн хэмжээнд аюулаас хамгаалах хүчнийхэн баривчлагдсан иргэдийг эрүүдэн шүүх буюу бусад хэлбэрээр хэрцгий шийтгэх явдал өргөн дэлгэрсэн бөгөөд зарим тохиолдолд ийм явдал туйлын

өндөр зохион байгуулалттай явагдаж байна. Сири улсад хохирогчдын дунд хүүхдүүд байсан мэдээ байгаа бөгөөд маш олон хоригдол эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгий шийтгэлийг даалгүй нас барсан талаар мэдээ байгаа боловч нотлоход төвөгтэй байна. 1-р сард Сирийн засгийн газрын хорих газруудад эрүү шүүлт, зодуур, өлсгөлөнгөөс болж нас барсан олон мянган хоригдлын цогцоснуудын гэрэл зургийн баримт олдлоо. Египет улсад ч эрүү шүүл өргөн тархсан бөгөөд хохирогчид нь хөнгөн гэмт хэргийн сэжигтнээс авахуулаад засгийн газрын тусгай ажиллагаагаар баривчилсан Исламын ахан дүүс бүлгийн гишүүд байдаг. Эдгээр болон бусад оронд түгээмэл хэрэглэгддэг эрүү шүүлтийн аргууд нь хөлийн ул руу цохих, гар хөлнөөс нь дүүжлэн зодох, удаан хугацаагаар эвгүй байрлалд зогсоох буюу суулгах, бэлэг эрхтэн болон бусад эмзэг газрыг цахилгаанаар цохиулах, хоригдол болон гэр бүлийнхэнд нь заналхийлэх, зарим тохиолдолд хүчин болон бусад бэлгийн хүчирхийлэл зэргийг хэрэглэдэг. Ихэнх тохиолдолд эрүү шүүлтийг бусад сэжигтнийг баривчлах мэдээлэл олж авах эсхүл засгийн газрыг шүүмжлэгчид, өрсөлдөгчдөд ял оноох “мэдүүлэг” авахад ашигладаг. Тэрчлэн хохирогчдын нэр төрийг гутаах, доромжлох, сэтгэл зүй, бие махбодын хувьд шархлуулахын тулд хэрэглэдэг. Эрүү шүүлт үйлдэгчид ял завших нь ердийн үзэгдэл бөгөөд засгийн газрууд эрүү шүүлтийн хэргийг хараат бусаар мөрдөн шалгах, зохих ял шийтгэл оногдуулах талаар олон улсын эрх зүйгээр хүлээсэн үүргээ биелүүлдэггүй.

ЯЛ ЗАВШИХ

Зөвхөн эрүү шүүлт үйлдэгчид ял завшдаггүй. Сири, Ирак, Ливи, Йемений хямрал мөргөлдөөний үеэр засгийн газрын зэвсэгт хүчний үйлдсэн дайны гэмт хэрэг, олон улсын эрх зүйн бусад зөрчлийг, тэрчлэн Газын зурвас, Израйлд израилын зэвсэгт хүчин болон Палестины зэвсэгт бүлэглэлийн үйлдсэн хүний эрхийн зөрчлүүдийг санаачилсан буюу тушаал өгсөн, улс төр, цэргийн удирдагчид, мөн Египет, Иран, Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират улсад өргөн хүрээтэй үйлдсэн хүний эрхийн зөрчлийг толгойлсон хүмүүс бүгд ял завшихын ашгийг хүртэж байна. Бахрейн улсын засгийн газар 2011 онд гарсан эрүү шүүлтийн хэргийн талаар олон улсын шинжээчдийн гаргасан дүгнэлтийн хариуд хараат бус мөрдөн шалгалт явуулна гэж амалсан хэдий ч оны эцсийн байдлаар тодорхой зүйл хийгээгүй байв.

Алжир улсын эрх баригчид хууль бус аллага болон бусад түүхэн зөрчлийг мөрдөн шалгах ажлыг удаан хугацаагаар татгалзсан хэвээр, 2011 онд болсон жагсаал цуглааны үеэр засгийн газрын хүчин олон хүнийг хөнөөсөн хэдий ч тухайн үед Йемен улсын ерөнхийлөгч асан болон түүний ойр хамсаатнууд албан тушаалаасаа огцрохдоо халдашгүй эрх эдлэх баталгаа авсныгаа ашигласаар байна. Тунис улсын шинэ эрх баригчид өмнөх засгийн зарим дээгүүр албан тушаалтан болон аюулаас хамгаалах хүчиний ажилтнуудын хэргийг шүүсэн боловч цэргийн давж заалдах шүүх тэдний ялыг ихээхэн бууруулснаас ял сонссон хүмүүийн ихэнхи нь эргээд эрх чөлөөтэй болжээ. Сири

улсад үндэсний шүүхийн тогтолцоо ял завших явдалтай үр дүнтэй тэмцэж чадахгүй нөхцөлд хүний эрхийн байгууллагууд, түүний дотор Эмнести Интернэшнл НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд хандан Сири, Израйл болон Палестины эзлэгдсэн газар нутаг дахь нөхцөл байдлыг олон улсын эрүүгийн шүүхийн харьяалалд шилжүүлэхийг ахин дахин уриалсан боловч ямар нэг арга хэмжээ аваагүй. Үүний зэрэгцээ, Ливи улс нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл 2011 оны шийдвэрээр ОУЭШ-ийн харьяалалд багтдаг боловч тус улсад иргэний дайн дахин дэгдсэнтэй холбоотойгоор дайны гэмт хэргүүд шинээр гарах болсныг эс харгалзан ОУЭШ-ийн прокурор ямар нэг шинэ мөрдөн шалгах ажиллагаагаа одоогоор эхлүүлээгүй байна.

УГСААТНЫ БОЛОН ШАШНЫ ЦӨӨНХИЙН АЛАГЧЛАЛ

Энэхүү бүс нутаг дахь улс төрийн үймээн самуун, бүс нутгийг хэрсэн шашны болон угсаатны хуваагдмал байдлын улмаас засгийн газрууд ба улс бус зэвсэгт бүлэглэлүүд угсаатны цөөнхийг улам бүр хардаж сэрдэн, тэдэнд үл тэвчих байдлаар ханддаг. Энэ нь олон хүнийг хаанаас гаралтай, ямар шашин шүтдэг гэдгээр нь гэр орноос нь баривчилж, хулгайлж, "угсаатны цэвэрлэгээ" хийж, амь насыг нь хөнөөсөн Ирак, Сирийн мөргөлдөөний үеэр хамгийн харгисаар илрэн гарсан билээ. Гэвч энэ байдал Ливи улсад ч давтагдаж байгаа бөгөөд үндэс угсаа, овог аймгийн харьяаллаас болсон аллага түгээмэл төдийгүй, тоо нь өсөн нэмэгдэж байна. Булангийн орнуудын хувьд Ираны засгийн

газар Бахайчуудыг хорих, дээд боловсрол эзэмших эрхийг хаах, мөн Азерис, Курдууд болон бусад угсаатны цөөнхийн хүмүүсийн шашны эрхийг хязгаарласаар байгаа бөгөөд Ахвазийн араб идэвхитнүүдийг нууцаар цаазласан мэдээ байна. Саудын Араб улсын эрх баригчид газрын тосны баялагтай Зүүн мужид засгийн газрыг шүүмжлэгч шийтүүдийг нухчин дарсан бөгөөд хүний эрхийг хамгаалагчдыг шударга бус шүүхээр оруулж, удаан хугацаагаар шоронд хорих ял, дор хаяж нэг хүнд цаазаар авах ял оноосон. Кувейтын засгийн газар олон мянган Бидуин оршин суугчдын иргэний харьяалал, түүнтэй холбоотой эрхийг түтгэлзүүлсэн хэвээр байна.

ДҮРВЭГЧИД БА ДОТООДДОО ШИЛЖИН СУУРЬШИГЧИД

2014 онд Сирийн хямрал нь дүрвэгчид ба дотооддоо шилжин суурьшигчдын тоогоор дэлхийн хамгийн аюултай хямралын нэгд тооцогдох боллоо. Жилийн эцэс гэхэд ойролцоогоор 4 сая дүрвэгчид Сирийн хямралаас болж орон гэрээсээ дайжсан байна. Тэдний ихэнхи нь буюу 95%-ийг хөрш орнууд нь хүлээж аваад байгаа бөгөөд НҮБ-ын Дүрвэгчдийн асуудлаархи Дээд комиссарын газрын мэдээлснээр Ливанд 1.1 сая, Турк улсад 1.6 сая, Иорданд 600 000, Иракт 220 000, Египетэд 130 000 гаруй Сирийн иргэд байна. Олон улсын хүмүүнлэгийн хүчин чармайлт шилжин суурьшсан тэдгээр хүмүүсийн эрэлт хэрэгцээг хангаж хүрэлцэхгүй байна. 12-р сарын байдлаар НҮБ-ын жил тутмын Сирийн Бүсийн дүрвэгчдийн асуудлаархи 2014

оны төлөвлөгөөний зөвхөн 54% хувийг санхүүжүүлж чадсан бөгөөд Дэлхийн хүнсний хөтөлбөр санхүүжилт дутагдалтай байгаагийн улмаас 1.7 сая сиричуудын хүнсний тусламжийг зогсоохоос аргагүйд хүрч байв. Олон газарт дүрвэгчид хэт олноороо богино хугацанд хил даван орж ирэх нь хүлээн авагч оронд ихээхэн хүндрэл авчирдаг бөгөөд дүрвэгчид болон тухайн орон нутгийн иргэдийн хооронд хурцадмал байдал үүсгэдэг. Иордан, Ливаны эрх баригчид Сири улсаас Палестины дүрвэгчдийг оруулахыг зогсоох арга хэмжээ авсан бөгөөд тус улсаас ирэх бусад дүрвэгчдийг ч оруулахыг хориглож эхлээд байна. Египетийн эрх баригчид Сирийн зарим дүрвэгчдийг хүч хэрэглэн буцаав. Сири улсад 7.6 сая хүн дотооддоо шилжин суурьсан бөгөөд тэдний олонхи нь дайн тулаан, шашны бүлэглэлийн халдлагад өртөн орон гэрээсээ дайжихад хүрчээ. Тэдний зарим нь олон дахин шилжин дүрвэгчид юм. Олон дүрвэгч олон улсын хүмүүнлэгийн байгууллагаас алслагдсан газарт, эсхүл засгийн газрын хүчин болоод улс бус зэвсэгт бүлэглэлүүдийн бүслэсэн нутагт амьдарч байна. Тэдний нөхцөл байдал туйлын хүнд бөгөөд сайжрах магадлал бараг байхгүй байна. Хэдийгээр Сирийн хямралыг давах хямрал одоогоор байхгүй ч Ирак улсад мянга мянган иргэд Исламын улсын хүчирхийлэл, харгислал, түүнчлэн засгийн газрын талыг баримтлагч шийт босогчдын дайралт, харгислалын улмаас дотооддоо шилжин суурьшсан байна. Ливи улсад 2011 онд Мистрата хотын зэвсэгт босогчид олон мянган хүнийг Таварга хотоос албадан нүүлгэсэн бөгөөд одоо ч

орон гэртээ буцаж ирэхэд нь саад учруулсаар байсан бөгөөд нийслэл Триполи болон бусад газар зэвсэгт мөргөлдөөн даамжирвал тэд ахин өөр тийш дүрвэх хэрэгтэй болох юм. Газын зурвас дахь Израйлийн бөмбөгдөлт, бусад халдлага 7-р сарын 8-нд эхэлсэн 50 хоногийн зэвсэгт мөргөлдөөний үед олон мянган орон байрыг нь эвдэн сүйтгэж, олон мянган хүнийг дүрвэхээс аргагүйд хүргэсэн. Израйл улсын засгийн газар Негевийн цөл дэх байгууламжид Судан, Эритрей болон бусад улс орноос шинээр ирсэн орогнол эрэгчдийг хорьж байгаа бөгөөд бусад дүрвэгчдийг аюулгүй байдлын өндөр эрсдэлтэй журмаар төрөлх нутаг руу нь “сайн дураар нь” буцааж байгаа юм.

ЦАГААЧДЫН ЭРХ

Цагаач ажилчид зөвхөн газрын тос, байгалийн хийгээр баялаг Булангийн орнуудын барилгын болон үйлчилгээний бусад салбарт чухал үүрэг гүйцэтгэж байгаа төдийгүй тус бүс нутгийн олон улс орны эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулж байна. Орон нутгийн эдийн засагт тэд маш чухал үүрэг гүйцэтгэдгийг эс харгалзан ихэнхи улс оронд цагаач ажилчдыг орон нутгийн хөдөлмөрийн хуулиар зохих ёсоор хамгаалж чадахгүй байгаагаас хөдөлмөрийн мөлжлөг, хүний эрхийн зөрчилд өртсөөр ирсэн. Катар улс 2022 онд Хөлбөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахаар сонгогдсон нь тус улс шинээр барих цэнгэлдэх хүрээлэн, бусад барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэх ажилчидтай холбоотой албан ёсны бодлого, үйл ажиллагааг хатуу хяналтын

дор явуулах хэрэгтэй болсон бөгөөд засгийн газар гаднаас ирж буй шахалтын хариуд шинэчлэл хийнэ хэмээн амласан юм. Гэсэн хэдий ч Катар улс Персийн булангийн бусад улс орнуудын адил цагаач ажилчдыг ажилд авах болон тэдний хөдөлмөрийг зохицуулахад ашигладаг *kafala* буюу ивээн тэтгэгчийн тогтолцоо нь хүний эрхийн зөрчлөөс сэргийлж чаддаггүйн дээр цагаачдын эрхийн хэрэгжилтийг хянах алба ёсны мехаизм байдаггүй нь байдлыг улам хүндрүүлж байна. Тус бүс нутгийн олон цагаач ажилчид завсарлага, амралтын өдөргүйгээр хэт олон цагаар ажиллаж, баривчлагдах буюу албадан гаргагдах сүрдүүлгээс болж эрхийг нь зөрчиж байгаа ажил олгогчдыг хаяж явж чадахгүй байна.

Тэдний дундаас эрхийн зөрчилд өртөх хамгийн өндөр магадлалтай хүмүүс бол гэрийн үйлчлэгчээр ажилладаг олон мянган Ази эмэгтэйчүүд бөгөөд бие махбодын болон бусад төрлийн хүчирхийлэл, түүний дотор бэлгийн хүчирхийлэл болон хөдөлмөрийн хүчирхийллийн бусад хэлбэрт өртдөг бөгөөд тэдний хохирлыг барагдуулах үр дүнтэй арга хэрэгсэл байдаггүй. Саудын Арабын эрх баригчид “тоо нь хэтэрсэн” цагаач ажилчдыг ихэвчлэн хатуу ширүүн нөхцөлд хорьж саатуулсны эцэст олноор нь Йемен болон бусад улс руу албадан гаргасаар байна. Түүнчлэн Ливи гэх мэт хууль дүрэм хөсөрдсөн улсад цагаач ажилчдыг алагчлах, эрхийг нь зөрчих явдал, тухайлбал шалган нэвтрүүлэх цэг, замын хаалт болон гудамжинд хүчирхийлэх, зэвсэглэн дээрэмдэх явдал гарсаар байна. Хүний наймаа, хууль бусаар хил

нэвтрүүлэгчдийн золиос болсон мянга мянган хүмүүс ихэвчлэн даац нь хэтэрсэн, далайд аялах шаардлага хангахгүй хөлөг онгоцоор Газрын дундад тэнгисийг гаталж, амьдралаа шинээр эхлэхийг зорьдог. Тэдний зарим нь Европ руу хүрч чаддаг бол, зарим хэсгийг нь Италийн тэнгисийн цэргийнхэн уснаас гаргаж, наад зах нь 3000 хүн дүрвэх далайд живж нас барсан мэдээ байна.

АЛБАДАН НҮҮЛГЭЛТ

Египетийн эрх баригчид Каир хот болон бусад газрын албан бус суурингийн оршин суугчдыг зохих мэдэгдэл өгөлгүйгээр, эсхүл өөр орон байр буюу нөхөн төлбөр өгөлгүйгээр албадан нүүлгэх ажлаа үргэлжлүүлсээр байна. Шинэ арилжааны бүсийн хөгжлийг дэмжих зорилгоор эрх баригчид “аюулгүй байдал хангагдаагүй” газарт суурьшиж байсан эдгээр хүмүүсийг албадан нүүлгэж байна. Түүнчлэн тус улсын арми “жийргэвч” бүс бий болгохын тулд Газын зурвасын хилийн дагуу амьдарч байгаа 1000 орчим гэр бүлийг албадан нүүлгэжээ. Израйлийн эрх баригчид ч албадан нүүлгэх ажил хийв. Зүүн Иерусалимыг оролцуулаад Баруун эрэгт оршин суугч палестинчуудын орон гэрийг Израйлийн энгийн иргэдийн эсрэг шалдлага үйлдэгчдийн гэр бүл гэсэн шалтгаанаар нурааснаас гадна хууль бусаар байшин барьсан гэх арав гаруй палестинчуудын орон гэрийг мөн нураасан. Израйлийн эрх баригчид Негев бүс нутагт албан ёсоор “хүлээн зөвшөөрөгдөөгүй тосгод”-д амьдарч байгаа Бедуинчуудыг албадан нүүлгэж байна.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

Бүс нутгийн хэмжээнд охид эмэгтэйчүүд албан ёсны бодлогын улмаас хуулиар зөвшөөрсөн алагчлалд өртсөөр байгаа бөгөөд бэлгийн болон бусад төрлийн хүчирхийллээс зохих ёсоор хамгаалагдаж чадахгүй байна. Алагчлалын үндэс суурь ихээхэн бат бөх бөгөөд 2014 онд тун цөөн нааштай өөрчлөлт гарсан. 2011 онд бүс нутгийг тэр чигээр нь ганхуулсан бослого хөдөлгөөнд эмэгтэйчүүд урьд өмнө байгаагүй идэвхитэй оролцооноос хойш 3 жил өнгөрсөн хэдий ч түүний үр дүнд бий болсон улс төрийн өөрчлөлтийн хамгийн гол хохирогчид болоод байна. Египет улсад бүлэг эрчүүд Кайр хотын Тахрирын талбайн ойролцоо жагсаал цуглаанд оролцож байсан эмэгтэйчүүд рүү дайрч, бэлгийн дарамт учруулсан. Харин Тунис улсад байдал өөр байна. Тус улсад хүчингийн хэрэг үйлдсэн цагдаагийн хоёр ажилтанд урт хугацааны хорих ял оноосон бөгөөд засгийн газар нь Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцид хийсэн тайлбараа хүчингүй болгож, охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн төсөл боловсруулах шинжээчдийн хороог байгуулсан. Алжир болон Марокко улсын эрх баригчид хэдийгээр хязгаарлагдмал боловч эрх зүйн зарим эерэг арга хэмжээ авч хэрэгжүүлсний дотор Алжир улс 1990-ээд оны дотоодын зэвсэгт мөргөлдөөний үед хүчиндүүлсэн эмэгтэйчүүдийн нөхөн төлбөр авах эрхийг хүлээн зөвшөөрсөн бол Марокко улс хүчингийн хэрэг үйлдэгчид хохирогчтойгоо гэрлэвэл ял сонсохоос мултардаг байсан

заалтыг Эрүүгийн хуулинаасаа хасчээ.

Булангийн орнуудын хувьд Иран ба Саудын Араб улсууд улс төр, шашны асуудлаар бие биентэйгээ эвлэрэшгүй дайсагналцдаг боловч эмэгтэйчүүдийн эрхийг аль аль нь аймшигтайгаар зөрчсөөр байна. Сүүлийн жилүүдэд Иран улсад эмэгтэйчүүдийн эрхийн олон идэвхитнүүдийг баривчлан саатуулах буюу шоронд хорьсон бөгөөд эрх баригчид зарим нэг спортын уралдаан тэмцээнийг үзэхийг хориглосон албан ёсны шийдвэрийг эсэргүүцсэн охид эмэгтэйчүүдийг баривчилсан. Саудын Арабт эрх баригчид жолоо барих албан ёсны хоригийг зөрчсөн эмэгтэйчүүдийг баривчлах буюу айлган сүрдүүлж байна. Энэ хоёр улсын эрх баригчид эмэгтэйчүүдэд хувцаслалт, биеэ авч явах хатуу дэг журмыг тулгадаг бөгөөд гэр бүлээс гадуурхи харилцаанд цаазаар авах ял оноодог хуулиа мөрдсөөр байна. Йемен улсад охид эмэгтэйчүүд бага насандаа, хүчээр гэрлэх эрсдэлтэй тулгарсаар байгаа төдийгүй зарим мужид эмэгтэйчүүдийг бэлэг эрхтнийг зэрэмдэглэх явдал өндөр хувьтай байсаар байна.

Засгийн газрууд охид эмэгтэйчүүдийг бэлгийн болон гэр бүлийн хүчирхийллээс зохих ёсоор хамгаалж чадахгүй байгаагийн дотор Исламын улс бүлэглэлийн Ирак дахь хүчин олон мянган угсаатны ба шашны цөөнхийн эмэгтэйчүүдийг хулгайлж, зэвсэгт бүлэглэлийн гишүүд, түүний дотор Исламын улс бүлэглэлийн гишүүдэд “эхнэр” буюу боол болгон худалдах явдал хэрээс хэтэрч байна. Шашны удирдагчид энэ талаар үг дуугархгүй байгаа нь иймэрхүү явдлыг улам ч өөгшүүлж байгаа юм.

2014 он Ойрхи Дорнод ба Хойд Африкийн бүс нутгийн хувьд зовлон зүдгүүр дүүрэн жил болж өнгөрсөн бөгөөд сүүлийн жилүүдэд гарч байгаагүй хүний эрхийн ноцтой зөрчлүүд гарсаар, нааштай өөрчлөлт гарах ямар нэг шинж тэмдэг одоогоор алга байна. Гэсэн хэдий боловч айшигт харанхуйн дунд улс төрийн янз бүрийн үзэл баримтлалтай орон нутгийн тоглогчид, идэвхитнүүд төрөл бүррийн арга хэрэгсэл ашиглан эрх мэдэлтнүүдийн эсрэг үнэнийг өгүүлж, дарангуйлагчдыг дагахгүй гэдгээ зоригтой мэдэгдэж, хүчин мөхөс, дарлагдсан нэгэнд тусалж, зөвхөн өөрсдийн эрхийн төлөө бус бусдын эрхийн төлөө, өөрсдөд нь учрах эрсдлийг үл хайрхан зүтгэж байна. Хүний эрхийг хамгаалагч тэдгээр хүмүүсийн халирашгүй зориг 2014 оны хамгийн бахархмаар онцлог байсан бөгөөд тус бүс нутгийн хүний эрхийн ирээдүйн итгэл найдвар болж байна.

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



amnesty.org
amnesty.mn

Хаяг: Сүхбаатар дүүрэг,
6-р хороо, Бага тойруу - 44
Утас/факс: 976-11-324705
Цахим хаяг: aimncc@maginet.mn
www.amnesty.mn

